

ГАРЧИГ

1. Ц.НЯМДОРЖ, Д.МӨНХБАТ. ГАРЫН МӨРНИЙ ШИНЖИЛГЭЭНД ХЭРЭГЛЭГДЭЖ БАЙГАА НЭР ТОМЬЁОНЫ ЗАРИМ АСУУДАЛ

.....

**2. С.БЯМБАА. МЭРГЭЖЛИЙН ЁС
ЗҮЙ**.....

**3.Ч.БАДАМДОРЖ. ОНЦ БАЙДЛЫН ИНСТИТУД ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ
ХЭМЖЭЭНИЙ БАЙР СУУРИНААС**

.....

**4.А.АМАРСАЙХАН ЗАРИМ ГАДААД ОРНЫ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН САХИЛГА
ЁС ЗҮЙН ДҮРМИЙН
ОНЦЛОГ**.....

**5. Р.БАЯРМАГНАЙ. ХҮНИЙ ЦУС, ЭД ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ОЛОН УЛСЫН
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

.....

6. Б.БАЯНМӨНХ. НҮБ-ЫН ИРГЭНИЙ ЦАГДАА, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

.....

**7. Г.БЯМБАДОРЖ. ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ
АСУУДАЛ...**

**8.С.ГАНТУЛГА. ХУУРАМЧ ГЭРЛЭЛТ, ҮРЧЛЭЛТЭЭР ХАЛХАВЧЛАН ҮЙЛДЭГДЭХ ХҮН
ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨХ ЭРСДЭЛ, АНХААРАХ АСУУДАЛ**

.....

**9.Ш.ЧУЛУУН. ГАЛТ ЗЭВСЭГ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ**

.....

**10.А.ГАНСҮХ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ЭРҮҮГИЙН ЭРХ
ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ
АСУУДАЛ**.....

**11. З.ЦЭРЭНБАТ. ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАТАЛГААНЫ ЗАРИМ
АСУУДАЛ.**

**12. Т.АЗЖАРГАЛ. ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ**

.....

**13. Ч.БАТЧИМЭГ ГАДААД ХЭЛИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ
АСУУДАЛ**.....

**14. С.АРИУНБАЯР. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МАШИНТ
ЭРГҮҮЛИЙГ АШИГЛАЖ БАЙГАА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ
АСУУДАЛ...**

**15.Ж. БАТМӨНХ. ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ИРГЭДИЙН
ОРОЛЦОО**

.....

16. Т.БОЛОРЭРДЭНЭ. ХУУЛЬ БУСААР МОНГОЛ УЛСЫН ХИЛ НЭВТРЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

ГАРЫН МӨРНИЙ ШИНЖИЛГЭЭНД ХЭРЭГЛЭГДЭЖ БАЙГАА НЭР ТОМЬЁОНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Цэрэнгийн Нямдорж

ХСИС-ийн ШУТГ-ын ШШСТ-ийн дарга бөгөөд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, хууль зүйн доктор, профессор, цагдаагийн хурандаа

Д.Мөнхбат

Завхан аймгийн Шүүхийн шинжилгээний албаны дарга, магистр, цагдаагийн хошууч

Криминалистикийн шинжлэх ухааны хүний мөр судлалын /антропоскопи/ гол судлагдахуун болох гарын мөрний адилтгалын шинжилгээнд орчин үеийн шинжлэх ухааны ололт, дэвшилтэт технологи, техник тоног төхөөрөмжүүдийг ашиглах болсонтой холбоотойгоор тэдгээрт хэрэглэгдэж байгаа тодорхойлолт, нэршлүүдийг нэг мөр ойлгох, нэр томъёонуудыг цэгцлэх, шинэ ухагдахуун бий болгож нэрлэх, тодорхойлолтыг өөрчлөх, хамрах хүрээг өргөсгөх, ялгаж зааглах, таних тэмдгүүдийг нэвтрүүлэх шаардлага урган гарч байна.

Гарын мөр нь гарын хуруунууд болон алганы папилляр шугамуудын хээ болон бусад бичил шинж тэмдгүүд, материаллаг объектод дүрслэгдэж эсвэл хуулбарлагдан үлдсэн толин тусгал дүрст ором буюу тэдгээрийн урвуу дүрс юм. /fingir frint/

Монголын Криминалистикийн эрдэмтэн судлаачид гарын мөрний нэр томъёо нэршлүүдийг өөр өөрөөр тодорхойлсон нь тэдгээрийн бүтээлээс харагдаж байна.

Эдгээр бүтээлийн нэгэнд гарын мөрний ерөнхий шинжүүдийг битүү хээ, гогцоо хээ, нуман хээ гэж ангилсан байхад нөгөө нэг нь дугуй хээ, гогцоо хээ, нуман хээ, тодорхой бус хээ гэжээ. Зарим бүтээлд эргүүлгэн хээ, усан хээ, уулан хээ гэж тодорхойлжээ.

Эдгээр ном сурах бичгүүд дэх нэршлүүд нь эрдэмтэн судлаачдын өөрийн үзэл баримтлал судалгаа шинжилгээ, эрэл хайгуулын үр дүнд хүрсэн тодорхойлолтууд боловч нэгдсэн нэр томъёо ойлголтонд хүрээгүй байгаа нь түүнийг судалж хэрэглэж байгаа оюутан, сонсогч, хэрэглэгчдэд нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл учруулж байна гэж судлаачийн зүгээс бид дүгнэж байна.

Хэдийгээр эрдэмтэн судлаачдын бүтээлд гарын хээний ерөнхий болон хувийн онцлог шинжүүдийг өөр өөрөөр тодорхойлсон байх боловч ШШҮХ-ийн гарын мөрний шинжилгээнд ерөнхий шинжүүдийн нэршлийг дараахь нэр томъёогоор нэг мөр ойлгож хэрэглэгдэж байна. Үүнд:

Англи	Орос	Монгол
Whorl	Завиток	Битүү
Loop	Петля	Гогцоо
Arch	Дуга	Нум
Tented Arch	Шатровая дуга	Майхан
	Неопределенный	Тодорхой бус

Түүнчлэн гарын мөрний хувийн онцлог шинжүүдийг шугамын салаалалт, шугамын нийлэлт, шугамын эхлэл, шугамын төгсгөл, арал, нүд, богино шугам, гүүр, цэг, дэгээ, уулзалдсан шугам, шугамын тасралт гэж ангилж шинжилгээнд хэрэглэж байна.

Энэтхэгийн гарын мөрний судлаачид дараахь гарын хээний онцлог төрлүүдийг тусгайд нь авч үздэг. Үүнд:

Эгц босоо хэлбэрийн папилляр шугамтай хээ, тодорхой хээгүй, өөрөөр хэлбэл папилляр шугамгүй гарын мөр ордог. Энэ төрлийн мөрөнд хөлсний сүвний дүрс /Пороскопи/ үлддэг бөгөөд хөлсний сүвний хэлбэр хэмжээ, харилцан байрлалаар нь адилтгалын шинжилгээ хийдэг байна.

Орчин үеийн техник технологийн ололт болох ГМАМАС /AFIS/-ийг гарын мөрний адилтгалын шинжилгээнд ашиглах болсноор уг системийн нэр томъёонуудыг нэг мөр ойлгож хэрэглэх шаардлага гарч байна.

ОХУ-ын Папилон АДИС системийн программ англи хэлээр бичигдсэн хэрэглэгчийн командууд, орос хэлээр мэдээллийн бичмэл өгөгдөхүүнүүдийг Монгол хэл дээр хөрвүүлэх тохиргоог хийж гүйцэтгэсэн.

Системийн программ Linux Mandrake Red Hat Linux хувилбарын үйлдлийн системийн гүйцэтгэл учир ажиллах хэл нь англи байдаг. Программын протокол зааварчилгаа орос хэлээр бичигдсэн байгаа. Иймээс энэ үйлдлийн системийн гүйцэтгэлийг хянаж хэрэглэх, засварлах түвшиний хэрэглэгч англи, орос хэлний мэдлэгтэй байх шаардлага тавигддаг. st хэрэглэгч /шинжээч оператор/ орос хэлний тодорхой түвшиний мэдлэгтэй, программын атрибуты томъёоллуудыг ойлгодог байх шаардлага зүй ёсоор тавигддаг.

Учир нь үндсэн командууд орос хэл дээр байдаг, мэдээллийн бичмэл өгөгдөхүүнүүдийг Монгол хэл дээр хөрвүүлсэн боловч атрибуты буюу стандарт цифр тэмдэглэгээнүүд англи үгний эхний үсгүүдээр тэмдэглэдэг. Жишээ нь E /empty/ сегмент хоосон, O /pull/ сегмент дүүрсэн, - /working/ сегмент ажиллагаанд байгаа гэсэн тэмдэглэгээ юм. F /finger frint/ гарын хээний дардас, T /palm/ алганы мөр, L /latent/ гарын мөр гэж ойлгодог.

Текстовые данны буюу бичмэл өгөгдөхүүнүүдийг монгол хэл дээр том үсгийн фондоор бичдэг. Учир нь Папилон систем дан ганц гарын мөрөөр адилтгал хийдэг бус хүний овог нэр, төрсөн он, сар, өдөр болон бусад мэдээллүүдийг бичиж үсгийн формат фондоор нь таниулж автомат адилтгал, хайлт хийдэг. Иймээс операторууд бичмэл өгөгдөхүүнийг янз бүрийн фондоор бичих нь хайлтанд нөлөөлдөг учир нэг хэлбэрээр бичих шаардлага тавьдаг.

Мөн бичмэл өгөгдөхүүнүүдийг алдаагүй зөв бичих, иргэдийн бичиг баримтыг нь үзэж тэнд бичигдсэн овог нэр, хаягийг бичих ёстой. Жишээ нь: Чимидийг Чимэд, Цэгмидийг Цэгмэд гэж бичсэнээс хайлтын үр дүн сөргөөр гардаг. Бичиг баримтыг нь үзэлгүй амаар асууж авснаас хуурамч нэр, хаяг бичүүлдэг, зарим тохиолдолд хоёр өөр овогтой байх тохиолдлууд байдаг. Энэ тохиолдолд ашиглах атрибуты систем байдаг тул тэдгээрийг ашиглаж чаддаг байх шаардлагатай.

Бидний гарын хээний дардас гэж хэлж заншсан нэр томъёо утга агуулгын хувьд шаардлага хангахгүй байна. Гарын хээний дардас гэж зөвхөн хар будагчаар авсан гарын хээний дардсыг хэлдэг. Энэ гарын хээний дардасны карт гэдэг нэр томъёо /дактилокарт/ агуулгын хувьд нийцэж байна. Карт нь гарын хээний дардас, мэдээллийн бичмэл өгөгдөхүүнүүд, таниулах гэрэл зураг, онцлог шинж тэмдгийн зураг бүхий бүтэцтэй байдаг.

Гарын хээний дардсыг папилон системийн санд оруулсанаар тэнд файл үүсэж, файл нь ТЭГ-д хуваагдаж сегмент үүсгэдэг ба үүнийг цахим карт гэж нэрлэх нь агуулгын хувьд нийцтэй гэж үзэж байна.

Гарын хээний дардасны картыг санд оруулахдаа сканер ашигладаг ба ердийн сканер, живой сканер ашигладаг. Живой сканерыг амьд сканер гэж нэрлэж болох ба амьд гэдэг нь амьд хүний дардас авах зориулалттай гэж ойлгох нь алдаа юм. Зарим хүмүүс хүний дулааныг мэдэрдэг гэж ойлгодог. Живой сканер дардас авах зориулалт бүхий призм, түүний доор байрлах хөндлөн 2 эгнээ лазеран гэрэл үүсгэгчүүд, түүний доор байрлах камеруудаас бүрддэг.

Ажиллах зарчим нь гэрлийн хугарлын үзэгдэл дээр тулгуурладаг. Хурууг призм дээр тавих үед призмийн доор байрлах олон тооны гэрэл үүсгэгчид ажиллаж нэг шулуун чиглэлийн гэрлүүд тодорхой тохируулсан өнцгөөр хурууны гадаргуудад хүрээнд гэрлийн хугарлаар буцаж эргэдэг.

Гарын хээний папиляр шугамнуудын хоорондын ховилд очсон гэрэл өнцгийн хувьд бага градусаар хугарч буцахдаа доор байрлуулсан камер дээр тусаж тэнд цагаан дүрс үүсгэнэ. Харин папиляр шугам дээр очсон гэрлүүдийн урсгалууд их өнцгөөр хугарч буцахдаа доор байрлуулсан камерийн хажуугаар өнгөрч камер дээр папиляр шугам дээр туссан гэрэл очоогүй тул тэнд хар өнгийн дүрс үүснэ.

Энэ дүрсүүд программ дээр боловсруулагдаж дэлгэцэнд гарын хээний урвуу дүрс үүссэн нь харагддаг. Энэ дүрс маш нарийн нарийвчлалттай хэмжээтэй, гажилтгүй гаргах тул амьд гэж нэрлэдэг.

Гарын хээний дардас бол гарын мөрнүүдийг кодлох ажиллагаа гэдэг нь гарын мөрний ерөнхий болон хувийн онцлог шинжүүдийг тодорхойлох ажиллагаа юм. Гарын хээний дардсыг түүнтэй харьцуулалт хийж болох гарын мөрөнд зориулж кодолдог тул ерөнхий онцлог шинжүүдийг давхардуулан кодлох өөрийн гэсэн тусгай дүрэмтэй байдаг.

Энэ нь Папилон фирм олон улсын батлагдсан стандартыг программ зохиохдоо мөрддөгтэй холбоотой.

Папилон системд гарын мөрний ерөнхий шинжийг:

Завиток

Битүү

Сложный завиток

Хүнд хэлбэрийн битүү

Петля /Левое, Правое/ Гогцоо /Баруун, Зүүн/

Дуга Нум

Шатровая дуга Майхан хээ

Неопределенный Тодорхой бус гэж ангилдаг.

Хувийн онцлог шинжийг программын хувьд окончание, тройник гэсэн тэмдэглэгээгээр тэмдэглэдэг.

Мөн төв, дельта, системийн координат, скелетон, виктор, гребень, кривизна, допуск, поток гэсэн ойлголтууд байдаг.

Төв гэж хээний хамгийн дотор талын тойрог үүсэж эргэж буцаж урсан папилляр шугамны толгой хэсгийн хэлнэ.

Дельта гэж гарын хээний төв урсгал, баруун эсвэл зүүн латераль урсгал, базис буюу суурь урсгал гурвын дундах голч цэгийг хэлдэг.

Системийн координат нь гарын хээний босоо хөндлөн чиглэлийг заадаг тэмдэглэгээ бөгөөд хайлтанд онцгой үүрэгтэй. Координатын хөндлөн чиглэл флексор шугамтай параллел байх ёстой.

Виктор гэж төвийн тэмдэглэгээн дээр сууриладаг папилляр шугамын урсгал чигийг заадаг тэмдэглэгээ юм.

Скелетон /араг яс/: Папилляр шугамыг томруулж харахад түүний хэмжээ нарийсч өргөсгөж байдаг бөгөөд түүний голчоор явсан шугамыг скелетон гэж нэрлэдэг.

Гребень: Гарын хээний папилляр шугамнуудын хоорондын зай төв болон өндгөн хэсэгтэй нарийссан захын болон суурь хэсэгтэй өргөсдөг бөгөөд гарын хээний папилляр шугамны дундаж зайтай байгаа хэсэг дэх папилляр шугамнуудын скелетоны хоорондын зайг гребень гэж нэрлэдэг. Гребень бол хэмжих нэгж юм.

Кривизна /тахир, муруй/ папилляр шугамны мурийлт.

Допуск төв бол дельта тавьж болох зөвшөөрөгдсөн зай. Тойрог хэлбэрээр хээний төрлөөс шалтгаалж янз бүр байдаг.

Поток гэж нь папилляр шугамын урсгалыг ойлгодог.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар шинжээч томилсон тогтоолдоо шинжилгээнд хүргүүлсэн гарын мөрнүүд санд байгаа сэжигтнүүдийн гарын хээтэй тохирох эсэх гэсэн асуулт тавьдаг.

Папилен сисМС МС М темийн санд байгаа гарын хээний дардсуудыг уголовная буюу гэмт хэрэгтний, добровольная буюу сайн дураараа гарын хээгээ санд оруулсан, специальная буюу тусгай гэсэн ангиллуудаар хадгалдаг бөгөөд ОХУ-д хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шинжээч нарын гарын хээний дардсыг санд заавал оруулдаг. Эндээс эрх зүйн хувьд сэжигтнээр тооцож тогтоол үйлдээгүй байж гарын хээний дардас нь санд байгаа хүмүүсийг сэжигтэн гэж тогтоолд дурьдах нь алдаа юм.

Санал:

1. Эрдэмтэн судлаачид гарын мөрний ерөнхий болон хувийн шинжүүдийн ангиллуудыг янз бүрээр тодорхойлж өөрсдийн нэр томъёоллоор нэрлэж байгаа учир ШШҮХ-ийн ГХШХ-ийн шинжээчдийн шинжилгээндээ хэрэглэж байгаа тогтсон тодорхойлолт, нэршил, нэр томъёоны гарын авлага гарган дагаж мөрдөх.
2. Орчин үеийн шинжлэх ухааны ололт болсон техник тоног төхөөрөмжүүдэд хэрэглэж байгаа нэр томъёог нэг мөр ойлгох, тодорхой нэршлүүдийг Монгол хэлэнд зөв хөрвүүлэх.
3. Олон улсын стандарт ISO 9001 2000 чанарын шаардлага хангаж, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Папилен системд хэрэглэгдэж байгаа гарын мөрнүүдийн ерөнхий онцлог шинжүүдийн ангиллыг шинжилгээнд ашиглах, сангийн ангиллыг иргэдэд зөв ойлгуулах ажлыг зохион байгуулах.

МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ /Professional ethics/

Сэнгэцохиогийн Бямбаа

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, цагдаагийн хурандаа

Барилгын бэхлэгээний төмөр толгой дээрээс нь унаж, нэг гараа чүд өргөж, бусдаас тусламж хүсэх энэ хууг олон хүн хүрээлэн зогсоно. Тэд маш их бухимдсан байна. Наад хүн чинь үхлээ ш дээ аваад яваач ээ...гэх тэдний бухимдлыг Осол болсноос хойш 20 гаруй мин болж ирсэн түргэн тусламжийн эмчийн “манай харъяаных биш ээ” гэсэн үг тэдний бухимдлыг улам их хүргэлээ. Эмчийн ёс зүй, төрийн хуулийг чандлан сахиж, Эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндийн төлөө эрдэм чадал, энэрэх сэтгэлээ харамгүй зориулахаа тангарагласан эмч хүний амнаас ийм үг гарлаа гэж үү...

Эртний энэтхэгт эмч хүнд “эрүүл чийрэг, нямбай, даруу, тэвчээртэй, тайрсан сахалтай, хумсаа авсан, үнэртэн шингээсэн, цагаан хувцастай байх ёстой. Түүний үг хэл намуун өвчтөнийг дэмжсэн өнгө аястай байх ёстой, өрөвчхөн ариун сэтгэлтэй, тогтуун тайван зан араншинтай, сайныг бүтээх байнгын эрмэлзлэлтэй байх ёстой.”¹ Хэдийгээр эрт үе биш ч эдүгээ үед ч Эмнэлгийн мэргэжилтэн эмчлүүлэгчдэд чин сэтгэлээсээ хандаж, тэдний сайн сайхны төлөө өөрөөсөө хамаарах бүхнийг хийх үүрэгтэй байдаг. /Эрүүл мэндийн сайдын 2002 оны 172 тоот тушаалын гуравдугаар хавсралт Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгчтэй харьцах горим./

Гэвч сүүлийн үед эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй холбоотой албан үүрэгтэй хайнга хандаснаас мэргэжлийн алдаа гаргах, өвчтөн болон тэдний ар гэрийнхнээс шан харамж авдаг зэрэг ёс суртахуунгүй үйлдэл энэ салбарт оршоор байгаа нь иргэдийг эрүүл мэндийн салбарт итгэх итгэлгүй болж, цаашилбал гадны өндөр хөгжилтэй улс оронд их хэмжээний зардал гаргаж эмчлүүлэх хандлага нэмэгдэж байна. Энэ нь салбарын хөгжилд төдийгүй улс орны хөгжилд сөрөгөөр нөлөөлж байна.

Иймээс бид ёс суртахууныг объектоо болгон судалдаг ёс зүйн шинжлэх ухаан. Цаашилбал мэргэжлийн ёс зүйн асуудлыг анхаарч судлах шаардлагатай байна.

Ёс зүй гэж юу бэ? What is Ethics

Ёс зүй гэдэг нь ёс суртахууныг судалдаг шинжлэх ухаан. Харин ёс суртахуун гэдэг нь хүний зан суртахуун буюу зан үйл гэж ойлгож болно. Зан үйлийг хүн төрлөхтөн урт удаан хугацааны туршид ямарч албадлагагүйгээр өөрсдөө тогтоож, түүгээрээ нийгмийн харилцааг журамлан зохицуулж ирсэн байдаг.

Иймдээ ч зарим тохиолдолд ёс зүйн нь төрөөс тогтоосон эрхзүйн хэм хэмжээнээс илүүтэйгээр хүчтэй байж чаддаг.

Ёс зүй ёс суртахууны хэм хэмжээгээр илэрдэг. Эрхзүй хэм хэмжээ хуулиар илэрдэг. Ёс зүй, эрх зүй хоёр нь урвуу хамааралтай ойлголт. Нийгэмд ёс суртахууны үүрэг, ач холбогдол багасах тусам хуулийн үүрэг нэмэгддэг, нийгэмд ёс суртахуун ноёлох хэрээр хуулийн үүрэг ач холбогдол багасдаг гэдэг ойлголт харьцангуй боловч бас бүрэн үгүйсгэх аргагүй юм.²

Ёс суртахууны хэм хэмжээг хүн төрөлхтөн нийтээр дагаж мөрдөх ёстойгоос гадна тодорхой албан тушаал, ажил мэргэжлийн хүмүүсийн хувьд эрхэлж байгаа ажил үүргийн онцлогоос хамаарч ёс суртахууны тусгай хэм хэмжээг баримтлах шаардлагатай. Үүнээс үүдэн албан хаагчийн ёс зүй, мэргэжлийн ёс зүй ойлголт бий болсон.

Мэргэжлийн ёс зүй гэж юу бэ ?/What are professional ethics?/

Эрт үеэс эдүгээ хүртэл дэлхий дахинд эмчийн ёс зүйн түүхэн хөгжилд тодорхой үүрэг роль гүйцэтгэсээр ирсэн баримт бичиг бол эртний Грекийн А.Гипократын /МЭӨ 470-377/тангараг юм.

¹Ц.Батбаяр “Ёс зүйн сурах бичиг” УБ -2007он 132-р тал

² Х. Оюунбаатар “Цагдаагийн албан хаагчийн ёс зүй” илтгэл “Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй”УБ 2007он 374-р тал

Уг тангараг дахь “Эхлээд бүү хор хүргэ” гэсэн үзэл санаа нь эмч нарын тангарагийн үзэлд нэвт шингэсэнбөгөөд түүний сургаалууд нь “**Мэргэжлийн ёс зүй**”-нүндсийгтавьсан байна. Мэргэжлийн ёсзүй нь мэргэжлийн үйл ажиллагааны өвөрмөц онцлог, шинэ, шинэ мэргэжил бий болж, хөгжих болсонтой холбоотойгоор үүсэн бий болжээ.

Салбар салбарын эрдэмтэн судлаачид мэргэжлийн ёс зүйг өөр өөрийнхөөрөө тодорхойлдог.

Мэргэжлийн ёс зүй бол хүн ёсны үүднээс заавал сахин мөрдөх шаардлагатай, бараг хууль ёсны гэж хэлж болох дүрэм журмын нийлбэр юм.³

Мэргэжлийн ёс зүй гэдэг нь хүн ёсны ерөнхий зарчмуудыг тухайн ажил, мэргэжлийн үйл ажиллагааны нөхцөлд тохируулан тодосгож нарийвчлан мөрдөн хэрэгжүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл мэргэжлийн ёс суртахууны тодорхой илэрлүүдийг судалдаг салбар шинжлэх ухааныг мэргэжлийн ёс зүй гэнэ.⁴

Мэргэжлийн онцлогтой уялдан илрэх ёс зүйн өвөрмөц хэм хэмжээ, шаардлага, үүрэг хариуцлагыг мэргэжлийн ёс зүй гэдэг.⁵

Хууль зүйн сайд Х.Тэмүүжин Албан болон мэргэжлийн ёс зүй гэж бусдын нэрийн өмнөөс, тэдний эрх ашгийг хангах үйл ажиллагаа явуулахаар эрх/эрх мэдэл/ олж авсан этгээд эрх олгосон бүтцийн сонирхлыг өөрийн болон бусад хөндлөнгийн сонирхлын дээгүүр тавьж, зан суртлаа албаны /мэргэжлийн/ үйл ажиллагаандаа мөрдлөг болгохыг ойлгоно.

Доктор М.Золзаяа Мэргэжлийн ёс зүй гэдэг нь мэргэжлийн онцлогоор нөхцөлдсөн ёс суртахууны хэм хэмжээ зарчмууд ба биеэ авч явах байдлыг илэрхийлж байна.

Доктор Д.Тунгалаг Мэргэжлийн зан суртахуун нь хүн ёсны ерөнхий зарчмуудыг тухайн мэргэжлийн үйл ажиллагааны нөхцөлд тохируулан тодосгож хэрэглэх бөгөөд мэргэжлийн ёс суртахууны тодорхой илэрлүүдийг судалдаг салбар шинжлэх ухаан гэж тодорхойлжээ.

Мэргэжлийн ёс суртахууны ойлголтууд

Ёс зүйн түгээмэл ойлголт, зарчим хэм хэмжээ нь ямарч мэргэжлийн ёс суртахууны тулгуур ойлголт болдог. Өөрөөр хэлбэл ёс суртахууны нийтлэг хэм хэмжээ нь аль ч мэргэжилд зайлшгүй баримтлах шаардлага болдог.⁶ Тухайлбал үүрэг хариуцлага,үнэнч шударга байдал,нэр төр, нинжин сэтгэл гм.

1.Мэргэжлийн үүрэг. /Professional role/ Энэ нь тухайн ажил мэргэжлийг гүйцэтгэж байгаа ажилтны ажлын онцлогийг илтгэн харуулах мэргэжлийн ёс суртахууны чухал ойлголт юм. Үүнд ажил үүргээ бүрэн ухамсарлаж, түүндээ хариуцлагатай хандах, мэргэжлийн онцлогтой холбоотой тавигдах шаардлагыг биелүүлэх, зохих шугам, байх ёстой байр сууриныхаа эзэн нь байх;

2.Мэргэжлийн хариуцлага./Professional responsibility/

Тухайн мэргэжлийн хүн өөрийн санаатай ч бай санамсаргүй ч бай хэлсэн зүйл, хийсэн үйлдэл, гаргасан шийдвэр чинь бусдыг ямар нэг байдлаар хохироосон бол үүнийхээ төлөө нийгмийн өмнө хүлээх хариуцлага. Албан тушаал зэр дэв дээшлэх тусам гаргасан шийдвэрийнхээ төлөө хүлээх нийгмийн хариуцлага нь улам нэмэгдэж байдаг.

3.Мэргэжлийн нэр хүнд./Professional reputation/Тухайн мэргэжлийг төлөөлж буй хүмүүсийн үйл ажиллагаа, ёс суртахууны соёлд нийгмээс өгч байгаа үнэлгээ юм. Мэргэжилтэн иргэний болон албаны эрх үүрэг, нийгмийн үнэлэмжээ ухамсарласны үр дүнд мэргэжлийн нэр хүндээ сахин хамгаална.

4.Мэргэжлийн үнэ цэнэ./Professional value/ Мэргэжлийн ач холбогдлыг ухамсарлан ойлгох нь янз бүрийн мэргэжлийн хүмүүсийнмэргэжлийн үнэ цэнийг нийгмийн зүгээс хэмжих, тухайн мэргэжилтэнөөрийнхөө үйл ажиллагаагаа үнэлэх үндэс болдог. Товчхондоо бол мэргэжлийн үнэ цэнэ нь мэргэжил, мэргэжилтэнд нийгмээс өгөх үнэлгээ, мэргэжилтний өөрийнх нь үнэлэмж юм.

Мэргэжлийн ёс зүй нь мэргэжил, хариуцсан ажилдаа үнэнч байх, ажил үүргээ чанартай гүйцэтгэх, хувийн эрх ашгийг огоорох, мэргэжлийнхээ нэр хүндийг хамгаалах, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага гүнээ ухамсарлах, үүргээ чанд биелүүлэх журмын тогтолцоо юм.

Мэргэжлийн ёс суртахууны өнөөгийн байдал

Монгол хүүхэд Харвордын их сургуульд 100% тэтгэлэгээр сурч байна. Махариши Менежментийн Их сургуулийн Компьютерийн шинжлэх ухааны мастерын хөтөлбөрт суралцаж буй

³Ц.Батбаяр “Ёс зүйн сурах бичиг” УБ -2007он 132-р тал

⁴Ш. Дуламсүрэн “Хуульчийн мэргэжлийн ёс зүй” УБ 2007он 79-р тал

⁵Х. Дамдинсүрэн “Анагаах ухааны ёс зүй” илтгэлээс “Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй” УБ 2007он 170-р тал.

⁶Д.Тунгалаг “Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй” УБ 2007он 9 дэхь тал

2 монгол залуу Америкийн оюутны програмчлалын олимпиадад 5, 7-р байр эзэллээ. Монгол хүү дэлхийн шатрын аврага боллоо. Олимпын аврага төрлөө. ГМ Монгол оюун ухаан, монгол хүч хөдөлмөр дэлхийд гайхагддаг. Өнөөдөр монголд мундаг хуульч, сайн эмч, сайн багш, сайн бизнесмен олон байдаг. Тэд бүгд мэргэжилдээ сайн. Гэвч яагаад улс орон минь хөгжихгүй байна. Бидний хөгжилд юу садаа болоод байна.

Хэдий чинээ өндөр мэдлэг боловсролтой ч ёс суртахууны мэдлэг, төлөвшил дутагдвал төдийчинээ ажлын амжилт, хувь хүний болон мэргэжлийн нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг.

Монголчууд бид нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино, нэг тэмээний хорголд мянган тэмээ хальтирдаг гэж ярьдаг. Нэг албан хаагч, нэг мэргэжилтний ёс суртахуунгүй байдал нь мэргэжлийн бүхэл бүтэн албан байгууллага, салбарын нэр хүндийг унагадаг. Нэр хугарах өдрийнх нэр олох насных гэдэг

Эмч хүнийг гарт эрдэнэт хүний амь, хуульч хүний шийдвэрт хувь хүний амьдрал хувь заяаны шийдэл бүхлээрээ багтаж байдаг. Үүгээрээ ч энэ хоёр мэргэжлийн хүмүүс олон түмний анхаарлын төвд байж, олон түмэн ч тэдэнд амь нас, амьдрал, хувь заяагаа даатгадаг.

Зөвхөн хуульч, эмч гэлтгүй ер нь хүнийг судалгаа, үйлчилгээ, танин мэдэхүйн объект болгодог мэргэжлүүдэд **мэргэжлийн ёс зүй** хурц тод илэрдэг. Тухайлбал: Сэтгүүлч, багш, менежер зэрэг мэргэжлүүдийг ч дурьдаж болно.

Хов живийг эх сурвалжаа болгож бусдыг гүтгэн доромжлох, баримт мэдээллийг гуйвуулах нь сэтгүүлч мэргэжлийн ёс зүйн ноцтой зөрчил, буруу онш тавих, бусдаас шан харамж авах, бусдын биед туршилт хийх зэрэг нь эмчийн ёс зүйн зөрчил, хэрэглэгчийг хуурч мэхлэх, амиа хичээх нь менежерийн ёс зүйн зөрчил, хит нэг талыг барьж, бусдын үнэн зөв мэдээлэлд итгэхгүй дан хардах, сэрдэх талаас хандаж, хэргийн оролцогчыг аашилж, загнах, зандрах зэрэг нь прокурор, шүүгч, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчийн гаргадаг нийтлэг ёс зүйн зөрчил.

Гэвч үүнийг бид хэвийн, угаас ингэж байдаг мэтээр хүлээн авч байдаг нь нэг талаас энэ мэргэжлийн хүмүүс ёс суртахууны хүмүүжил, мэргэжлийн ёс зүйн төлөвшил муу байгаа нөгөө талаас тухайн байгууллагын зүгээс энэ төрлийн мэргэжлийн хүмүүст хүлээлгэж буй ёс зүйн хариуцлага асуудлыг олон нийтэд мэдээлэхгүй хаалттай байгаатай шууд холбоотой юм.

Мэргэжлийн ёс зүйн зарчмууд нь байгууллагын ажилтанд тодорхой шийд гаргах, ямар нэгэн алхам хийх, харилцан үйлдэл явуулахад хамгийн гол ёс зүйн суурь болдог.

Үүнд байгууллагын сонирхолд нийцээгүй алхам хийхгүй байх, өөрийн ажил үүргийн хариуцлагаа ухамсарлах, засран сайжирч байх, ёс зүйн хувьд тогтвортой байх, үнэнч байх, бусдын болон өөрийн эрхийг хүндэтгэх зэрэг орно. Гэвч мэргэжилтний баримтлах зарчим нь тодорхой боловч түүнийг хэрэгжүүлэх нөхцөл нь тодорхой бус байгаагаас мэргэжлийн ёс зүйн зөрчил их гардаг тул зарчмыг шинэчлэн боловсруулж, түүнд дүн шинжилгээ хийж сайжруулж байх шаардлагатай.

Мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал

Авилга, хээл хахууль, албан тушаалын болон нэр төрийн төлөөх тэмцэл нь орчин үед нилээд түгээмэл шинжтэй болсон нь мэргэжлийн ёс зүйн тулгамдсан асуудал юм.

Мэргэжлийн ёс зүйн чиглэлийг хөгжүүлэх нь нийгмийн харилцааг боловсронгуй болгох, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Мэргэжлийн ёс зүйн зарчмууд нь байгууллагын ажилтанд тодорхой шийд гаргах, ямар нэгэн алхам хийх, харилцан үйлдэл явуулахад хамгийн гол ёс зүйн суурь болдог. Үүнд байгууллагын сонирхолд нийцээгүй алхам хийхгүй байх, өөрийн ажил үүргийн хариуцлагаа ухамсарлах, засран сайжирч байх, ёс зүйн хувьд тогтвортой байх, үнэнч байх, бусдын болон өөрийн эрхийг хүндэтгэх зэрэг орно.

Гэвч мэргэжилтний баримтлах зарчим нь тодорхой боловч түүнийг хэрэгжүүлэх нөхцөл нь тодорхой бус байгаагаас мэргэжлийн ёс зүйн зөрчил их гардаг тул зарчмыг шинэчлэн боловсруулж, түүнд дүн шинжилгээ хийж сайжруулж байх шаардлагатай байна.

ОНЦ БАЙДЛЫН ИНСТИТУД ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ БАЙР СУУРИНААС

Чойжоованчигийн Бадамдорж

ОХУ-ын Санкт-Петербург хотын ДХЯ-ны
Их сургуулийн адъюнкт, цагдаагийн хошууч

Аннотация: Энэхүү өгүүлэлд олон эрх зүйд онц байдлын институтын хэрхэн бүрэлдэн бий болсон талаар бичсэн болно. Онц байдлын үед хүний үндсэн эрхийн олон улсын стандарт хэм хэмжээг авч үзсэн болно.

Annotation: The article focuses on the formation of the Institute of the emergency in the international law. Considered international standards of fundamental human rights during states of emergency.

Түлхүүр үг: Онц байдал, олон улсын эрх зүй, хүний эрх.

Key words: Emergency, international law, human rights.

Онцгой нөхцөл байдал бий болж түүний эсрэг яаралтай (онцгой) арга хэмжээ авах хэрэгцээ, иргэдийн эрх, эрх чөлөөг ноцтойгоор хязгаарлах эрх зүйн шинжтэй тийм арга хэмжээ нь онц байдлын институтыг бий болгосон.

Энэхүү институт нь тухайн улсын болон олон улсын хэмжээнд үүсч бий болж байсан. Тэр дундаа түний хөгжил нь далайцаараа тодорхой улс гүрний хэмжээнд олон улсын практикийг бараг 100 гаруй жилээр түрүүлсэн байна. Онц байдалд зориулсан парламентын анхны актууд XIX дүгээр зууны дунд болон 2 дугаар хагасд: Францад –1848 он, Пруссд – 1857 он, Австри-Венгерт – 1869 он, Испанид – 1870 он, Орост 1880 онуудад тус тус мөрдөгдөж эхэлсэн байна.

Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хамгаалах конвенцийг баталсан нь (1950.11.04 Ром хотод батлагдсан)⁷ олон улсын хэмжээнд онц байдлын ёс журам (институт)-ыг бий болгох анхны алхам болсон.

Конвенцийн 15 дугаар зүйлд “тухайн үндэстэнд заналхийлсэн дайн болон бусад онцгой нөхцөл байдлын улмаас гэрээнд оролцогч талууд энэхүү Конвенцид хүлээсэн үүргээсээ татгалзах арга хэмжээг, бий болсон нөхцөл байдлын хэмжээнд уялдуулан авах ба энэхүү авсан арга хэмжээ нь бусад олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүрэгтэй нь зөрчилдөхгүй байна” гэж тогтоож өгсөн байна.

Конвенцэд, хязгаарлалтад хамаарахгүй хэд хэдэн эрхийг зааж өгсөн байна: амьд явах эрх (хууль ёсны цэргийн ажиллагааны улмаас хүмүүсийн амь нас эрсэдсэнээс бусад тохиолдолд), эрүүдэн шүүх, боолчлох албадан хөдөлмөр хийлгэхийг хориглох (оршин суугчдын амь нас тайван амьдралд заналхийлсэн гамшиг болон онц байдлын үед зайлшгүй ажилласанаас бусад), шийтгэлийг зөвхөн хуулийн үндсэн дээр оногдуулах. Үүнээс гадна энэхүү Конвенцид гэрээнд оролцогч тал хүлээсэн үүргээсээ татгалзаж байгаагаа, авах арга хэмжээ түүний шалтгаан мөн түүнчлэн энэхүү арга хэмжээг зогсоох болон конвенцийг бүрэн эргэж мөрдөж эхлэх хугацааг Европын холбооны ерөнхий нарийн бичгийн даргад заавал мэдэгдэж байх нөхцлийг зааж өгсөн.

Үүнээс арваад жилийн дараа ийм агуулга бүхий хэм хэмжээ Иргэний болон улс төрийн эрхийн тухай ОУ-ын Пактад тусгалаа олсон байна (НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1966 оны 12 сарын 16 нд баталсан)⁸.

Онцлог нь хэд хэдэн шаардлагаас бүрдэж байсан. “Онц байдал” нь гэрээнд оролцогч талын үүргээсээ татгалзах нөхцөл гэж пакт шууд зааж өгсөн. Онц байдлыг албан ёсоор зарлах ёстой. Үүргээсээ татгалзах хэмжээг тогтоож өгсөн- «хурцадмал байдлаас шалтгаалан». Хязгаарлалтанд хамаарахгүй эрх эрх чөлөөний жагсаалт өргөжсөн. тухайлбал:

- Ялгаварлан гадуурхах байдлыг бий болгохгүй байх,
- Хувийн эрх чөлөө,
- Эрх зүйн чадамж хүлээн зөвшөөрөх эрх,

⁷ОХУ-ын Хууль тогтоомжуудын эмхэтгэл. 2001. №2. Х. 163.

⁸Международная защита прав и свобод человека. Сборник документов.- М.: Юридическая литература, 1990. С. 32-53.

- Шашин шүтэх, эс шүтэх
- Чөлөөтэй сэтгэх эрх чөлөө.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээний актад Онц байдлын институтыг тодорхой өгүүлсэн байдаг. Түүнээс гадна олон улсад албан ёсны статусгүй ч гэсэн танигдсан өөр баримт бичгүүд ч байдаг.

Тэдгээр баримт бичгүүдэд:

- Онцгой байдлын үед хүний үндсэн эрхийн талаарх хамгийн бага үндсэн хэм хэмжээнүүд /Минимальные стандарты норм об основных правах человека при исключительном положении/ (1984 онд Парис хотод болсон Олон улсын хуульчдын холбооны бага хурлаар баталсан)⁹,
- Онц байдлын хууль тогтоомжууд хэрэгжих үед иргэдийн иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах зарчим (1982 оны НҮБ-ын Эдийн засаг Нийгмийн зөвлөлийн хураалдаан дээр томьёлсон)¹⁰,
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан хүний эрхийг багасгах болон хязгаарлах журамтай холбоотой Сиракузын зарчмууд (1984 онд НҮБ-ын Сиракузы хотод явагдсан хуралдааны үр дүнгээс батлагдсан)¹¹.

Судлаачийн үүднээс авч үзэхэд “Онцгой байдлын үед хүний үндсэн эрхийн талаарх хамгийн бага үндсэн хэм хэмжээнүүд” нь тайлбар шаардагдахгүй бөгөөд эдгээр баримт бичгүүд нь онц байдлын институтын бараг бүх талыг илэрхийлсэнээс гадна түүний агуулга нь дараах ойлголтонд хүргэж байна. Тухайлбал:

Онц байдлыг бий болсон нөхцөл байдлаас шалтгаалан улсын бүх нутаг дэвсгэрт эсхүл түүний зарим хэсэгт албан ёсоор зарлагддаг бөгөөд, тухайн үндэстэнд заналхийлсэн бодит нөхцөл байдал, улс, нийгэмд нь бий болсон тохиолдолд зөвтгөх боломжтой юм.

Онц байдлыг зохицуулж байгаа бүх хэм хэмжээнүүд нь онц байдал зарлахаас өмнө тухайн улсын хууль тогтоомжуудад урьдчилан бэхжүүлсэн байх ёстой.

Улс бүрийн бүтцэд онц байдал зарлах журам тодорхой байх ёстой. Хэрэв гүйцэтгэх засаглалд онц байдал тогтоож зарлах эрх мэдэл өгвөл түүнийг нь хамгийн богино хугацаанд батлан хэрэгжүүлэх ёстой.

Онц байдал зарласан хугацаа нь хэвийн нөхцөл байдлыг сэргээх тэр хугацаанаас хэзээ ч хэтрэхгүй байх, онц байдлын үргэлжлэх дээд хугацаа нь (цэргийн эзлэн түрэмгийллээс бусад тохиолдолд) Үндсэн хуулиар хуульчлагдсан байх ёстой.

Хууль тогтоох засаглал нь онц байдлыг хүчингүй болгох болон түүний үйлчлэх хугацааг өөрчлөх нэгэн адил эрхтэй байх ёстой. Онц байдлын хугацааг сунгах болгонд анхны тогтоосон хугацаа дуусахаас өмнө хууль тогтоох байгууллага баталж мөн тунхаглана.

Түүнчлэн хязгаарлах арга хэмжээнүүдийг хэрэглэж байгааг үл харгалзан онц байдлын хугацаанд хууль тогтоох засаглалын чиг үүрэг хэвээрээ байна. Хэрэв ээлжит сонгуулийн хугацаа болсон бол нөхцөл байдлын хэвийн болж Үндсэн хуулинд заасны дагуу сонгуулийг зохион байгуулах боломжтой болсон тэр үе хүртэл хугацааг шилжүүлнэ.

Онц байдал нь тухайн улсыг Улс төр болон иргэний эрхийн тухай ОУ-ын пактын 6-8 зүйлийн (1, 2 дугаар хэсэг), 11, 15, 16, болон 18 зүйлүүдэд зааснаас ухрах үндэслэл болохгүй. («харьцангуй эрх, эрх чөлөө»-нд халдахыг зөвшөөрөхгүй байх зарчим)

Шүүхийн дээд байгууллагууд нь (үндсэн хуулийн хяналтын байгууллагууд) онц байдлын хууль тогтоомж нь тухайн улсын Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх, онц байдал тогтоож байгаа акт болон хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь үндэсний хууль тогтоомжуудад нийцэж байгаа эсэхийг шийдэхийн тулд зохих эрх хэмжээтэй байх ёстой. Дээрхи дурдагдсан байгууллагууд нь иргэдийн “харьцангуй эрх”-ийн хүрээ рүү халдаахгүй байхыг хангах болон эрх, эрх чөлөөг хязгаарлахдаа авч байгаа арга хэмжээний хувьд тэнцвэрт байдлын зарчмыг мөрдөнө.

Үндсэн хуулийн хяналтын байгууллага нь хууль зүйн хүчин чадлаа алдсан Үндсэн хуулийн болон онц байдлын хууль тогтоомжийн шаардлагыг хангахгүй ямар нэгэн актын тухайд түүний хэрэгжилтийн талаар онцгой арга хэмжээ зарлах өргөн эрх хэмжээтэй байх ёстой. (хууль тогтоох болон гүйцэтгэх шинж чанартай)

⁹Subrata R.C. The rule of law in a state of emergency: the Paris minimum standards of human rights norms in state of emergency. 1989.

¹⁰Questiaux N. Study of the Implications for human rights of Recent Developments Concerning Known as State of Siege of Emergency. N.Y.: United Nations Economic and Social Council, 1982. P. 15-19.

¹¹Вестник МГУ. Серия 11. Право. 1992. № 4. С. 59-69.

Харин онц байдлыг хангаж байгаа актууд нь онц байдлыг зогсоход энэ тухай тусгайлан зарлалгүйгээр нэгэн зэрэг хүчин чадлаа алдана.

Онц байдлыг хүчингүй болгоход бүх хүчингүй болгосон (хязгаарлагдсан) эрх, эрх чөлөө автоматаар сэргээгддэг, ямар ч онцгой арга хэмжээ хадгалагдан үлдэх ёсгүй¹².

Олон улсын хэмжээнд онц байдлын институтыг нарийвлан судлах боломжгүй байсан боловч хэд хэдэн зөрчилдөөнөөс зайлсхийсэн. Тэрний нэг нь “үүссэн онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлж байгаа иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах үйл ажиллагаа нь, хамгийн бага стандарт болон бусад ийм төрлийн баримт бичгүүдийн шаардлагад нийцсэн байх ёстой” гэсэн байр суурьтай холбоотой. Бидний үзэж байгаагаар энэ бол төөрөгдөл юм, учир нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд зан суртахуун эсвэл бусад иргэдийн эрх эрх чөлөөг хамгаалах зорилгоор хэд хэдэн эрх, эрх чөлөөг хуулиар хязгаарлах боломж нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах конвенц болон Улс төр, иргэний эрхийн тухай ОУ-ын пактад заасныг тооцоолоогүй.

Онц байдал тогтоохгүйгээр онцгой арга хэмжээг хэрэглэх практик нь зарим гадаад улс орнуудад өргөн түгээмэл шинжэй байдаг бөгөөд, энэ нь олон улсын институтэд харшлахгүй харин бүр эсрэгээр бий болсон аюул болон нөхцөл байдлыг тогтворжуулах үр дүнтэй ба зөвтгөгдсөн хариу үйлдэл гэж үздэг.

Судлаачийн хувьд авч үзэхэд Их Британи улсын терроризмын эсрэг авч байгаа арга хэмжээ нь маш үзүүштэй жишээ юм. Жишээлбэл 1984 онд Их Британид Хойд Ирландад бий болсон хурцадмал нөхцөл байдалтай холбоотойгоор “Терроризмыг таслан зогсоох” хуулийг баталсан (түр арга хэмжээ) энэхүү хууль нь иргэдийн хэд хэдэн эрхийг хязгаарлсан онцгой шинж чанарыг агуулж байсан бөгөөд, өөрөөр хэлбэл ердийн хэрэглэгддэг хэм хэмжээнээс татгалзсан явдал байв.

Эдгээр хязгаарлалтууд нь террорист халдлага үйлдэх, бэлтгэх болон түүнд өдөөн хатгасанд(турхирсанд) холбогдолтой хэмээн сэжиглэгдсэн этгээдүүдийг зөвхөн тодорхой гаргасан эрх зүйн зөрчлийнх нь төлөө шүүхэд шилжүүлэх зорилгоор бус, мөн мэдээлэл авах үүднээс өөрөөр хэлбэл ял тулгалгүйгээр саатуулж баривчлахад хэрэглэдэг байсан байна. Хуулиар зөвшөөрөгдсөн 48 цагийн саатуулах хугацааг тэдгээр этгээдүүдийн хувьд 5 хүртэл хоногоор сунгаж болдог байна.

Энгийн үед дээрхи асуудлуудыг хэлэлцэж шийддэг шүүхийн журмаас ялгаатай нь Хойд Ирландын асуудал хариуцсан төрийн нарийн бичгийн дарга энэ талын шийдвэрийг гаргадаг байсан.

Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хамгаалах конвенцийн 15 дугаар зүйлд заасан журмын дагуу олон улсын үүргээсээ татгалзаж байгаа тухайгаа Их Британи улс зарлахгүйгээр 1988 оны 12 дугаар сарын 23-ныг хүртэл уг хууль нь үйлчилж байсан. Түүний хажуугаар, 1988 оны 12 дугаар сарын 29 нд «Броуган болон бусад нэгдсэн хаант улсын эсрэг»¹³ хэргийг Хүний эрхийн Европын шүүх хянаж үзэхдээ Хойд Ирландад бий болсон онцгой нөхцөл байдал болон террорист чиг хандлагатай гэмт хэргүүдийг мөрдөх ажиллагааны хүнд байдлыг харгалзан үзэж, саатуулж баривчлах хугацааг сунгасан арга хэмжээг хууль ёсны дагуу гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.

Мөн түүнчлэн шүүх тухайн үүссэн нөхцөл байдлын үед ял тулгалгүйгээр баривчлах (саатуулах) нь Конвенцийн 5 дугаар зүйлийн 1«с» хэсгийг зөрчсөн болохгүй, хэрэв ийм саатуулах ажиллагааг шударгаар өөрөөр хэлбэл хэрэг шалгах явцыг урагшлуулах болон хангалттай нотлох баримт цуглуулах зорилгоор хийгдсэн бол хэмээн зааж өгчээ.

«Мюррей нэгдсэн хаант улсын эсрэг»¹⁴ хэргийн тогтоолд Европын хүний эрхийн шүүх, Конвенцийн 5 дугаар зүйлийн 1«с» хэсгийг зохион байгуулалттай терроризмын эсрэг үйл ажиллагааны үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч, төр ба цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл үүсгэхэд хэрэглэж болохгүй хэмээн тодотгож өгчээ.

Мөн энэ шийдвэрт, 1978 онд терроризмд холбоотой хэмээн сэжиглэгдсэн этгээдүүдэд “Хойд Ирландын тухай” хуулийн дагуу Их Британиас хэрэгжүүлсэн (онцгой арга хэмжээ) хувийн мэдээллийг цуглуулах болон нэгжлэг хэлбэрээр явуулж байсан арга хэмжээг хууль ёсных гэж дүгнээд, зохион байгуулалттай терроризмын аюулаас хууль журам болон хамгаалалтын хүрээнд засгийн газрын хариуцлагын тухай мөн түүнчлэн терроризмын эсрэг үйл ажиллагааны зохион байгуулалтын хүндрэлүүдийн талаар Европын хүний эрхийн шүүх сануулсан. Шүүхийн тэмдэглэснээр энэ 2 хүчин зүйл нь, төрөөс террорист гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор

¹²Subrata R.C. The rule of law in a state of emergence: the Paris minimum standards of human rights norms in state of emergency. 1989. Цит. По Соловьев А.И. конституционно-правовое регулирование режима чрезвычайного положения в Российской Федерации: Дис. ...канд. юрид. наук. М., 2001.

¹³«Броуган и другие против Соединённого Королевства» (Страсбург, 29 ноября 1988 года)// СПС «Консультант плюс: Международные правовые акты».

¹⁴«Мюррей против Соединённого Королевства»(Страсбург, 28 октября 1994 года)// СПС «Консультант Плюс: Международные правовые акты».

идэвхтэй арга хэмжээ авах боломж болон гэр бүл хувийн халдашгүй байдалтай холбоотой зарим хувийн эрхээ хэрэгжүүлэх 2-ын хооронд байх шударга тэнцвэртэй байдалд нөлөөлдөг гэж үзжээ.

Иймд Олон улсад онцгой арга хэмжээ хэрэглэхтэй холбоотой эрх зүйн хоёр институт байдаг байна: Онц байдлын институт ба Үндэсний аюулгүй байдлын институт. Үүний зааг ялгааг тодорхойлоход нилээд хүндрэлтэй. Гадаад орнууд түүн дотроо ардчилал хөгжсөн улсуудын хүний эрхийг хамгаалах олон улсын стандартаас ухраж, онцгой арга хэмжээг батлах нилээн баян туршлагатай. Тодорхой нөхцөл байдал бүрт ийм арга хэмжээнүүдийн хууль ёсны эсэх талаарх сүүлчийн үг юуны өмнө шүүн таслах эрхтэй олон улсын байгууллагад олгогддог.

Үүний сацуугаар ялгааг ойлгохын тулд онц байдлын институтын зорилгыг нарийвчлан судлах хэрэгтэй.

Танилцуулагдаж байгаагаар дээрхи дурдагдсан хүний эрхийн салбар дахь олон улсын стандартыг боловсруулах түлхэц нь онц байдлын институтын үндсийг бүрдүүлдэг байна, энэ салбар дахь тусгаар улсуудын бодлого нилээд эргэлзээтэй болж ирсэн. Төлөвлөгдөж байснаар, улс орнуудын хүний эрх эрх чөлөөний хүрээнд олон улсын үүргээсээ татгалзаж үүнтэй холбоотой зарлагдаж байгаа онц байдлын дэглэм нь удаан үргэлжлэхгүй шинж чанартай онцгой арга хэмжээ байдаг.

Гэвч бодит байдал дээр онц байдал олон жилээр үргэлжилж байсан. Жишээлбэл: Зимбабве улсад зарласан онц байдал 1965-аас 1990 он хүртэл, Шри-Ланкад онц байдал эхлээд 1971-1977 дараа нь 1977-1983 онуудад үүнээс хойш ахин 5 удаа тогтоогдож байсан харин 1983 онд зарласан онц байдал 1991 он хүртэл хүчинтэй байсан. Мароккогийн хүн ам онц байдлын нөхцөлд 1965-аас 1970 онд, Сьерра-Леон-ых 1970-аас 1978 онуудад, 80-д онуудад Перугийн 170 мужаас гучаас илүүд хувьд нь онц байдал тогтоож байсан. Чилийн ард түмэн онц байдлын нөхцөлд 15 жил (1973 оны 9 сараас 1988 оны 8 сар хүртэл), Парагвай – 33 жил (1954 оны 5 сараас 1987 оны 4 сар хүртэл хэлбэрийн төдий сонгууль явуулахын тулд 4 жил тутамд нэг өдрийн завсарлагаатайгаар). Колумбад 1958-1981 он хүртэл 23 жил онц байдал хэрэгжсэн.¹⁵

Жилээр сунжирсан онц байдал ба түүнээс гарч байгаа бүх эрхийн хязгаарлалтууд нь дарангуйлан захирах дэглэм тогтсоныг илэрхийлэх болсон, харин Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хамгаалах конвенцийн 15 дугаар зүйл болон Иргэний ба улс төрийн эрхийн олон улсын пактын 4 зүйлд заасан хэм хэмжээ нь үүний хуулийн ёсны үндсийг бий болгож өгдөг.

Ийм нөхцөл байдалд онц байдлын дэглэмийн шалгуурыг нарийвчлан боловсруулах шаардлагатай болсон. Тухайлбал онц байдлын дэглэм тогтоож онцгой арга хэмжээ хэрэглэснийг зөвтгөх нөхцөл байдлыг тодорхойлохыг ойлгох.

Энэ нөхцөл байдал нь: *улсүндэстний амьдралд бодит аюул учруулсан онцгой шинжийг агуулах ёстой*. Сиракузын зарчим дараахь аюулуудыг тодорхойлж өгсөн байна. Үүнд:

а) бүх хүн амын ба улсын нийт нутаг дэвсгэр болон түний тодорхой хэсэгт;

б) хүн амын бүрэн бүтэн байдал, улс төрийн бие даасан байдал эсхүл улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, нэг бол улс төрийн болон иргэний эрхийг хамгаалж хангахад шаардагдах хууль журмуудын хэвийн ажиллах эсхүл оршин тогтноход заналхийлсэн.

Үндэстний амьдралд ноцтой болон зайлшгүй аюул учруулахааргүй дотоодын зөрчил болон эмх замбараагүй байдал мөн түүнчлэн эдийн засгийн хүндрэлүүд нь пактын 4 дүгээр зүйлд заасан татгалзах үндэслэл болохгүй.

Хүний эрхийн Европын шүүхийн шийдвэрлэсэн «Лоулесс Ирланди эсрэг»¹⁶ хэрэгт үндэстний амьдралд заналхийлэх бодит аюул гэдэг ойлголтыг: улсыг бүрдүүлж байгаа зохион байгуулалттай бүлэглэлийн амьдралд аюул учруулах хүн амыг бүхэлд нь хөндсөн хямралт байдал эсвэл зайлшгүй онцгой аюул гэж тодорхойлсон.

Энэ тухайд онцгой нөхцөл байдлын далайц нь улсын бүх нутаг дэвсгэрт түүнийг түгээхийг ойлгож болохгүйг тодотгож өгөх хэрэгтэй. Онц байдал тогтоох үндэслэлд орон нутгийн чанартай явдал байж болно, гол шалгуур нь түүний үр дүнд үүсэх аюул нь нийт үндэстний/улсын эрх ашгийг хөндсөн шинжтэй байх ёстой.

Үндэстний аж амьдралд заналхийлэх аюул нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх ба удирдлагын ердийн дэг журмыг бодитойгоор өөрчлөх арга хэмжээ авахыг шаарддаг. Үндэсний аюулгүй байдлыг хангах институтээс онц байдлын институтын бас нэг онцлог үүнтэй холбоотой.

Онцгой нөхцөл байдал бий болоход тохирсон хариу үйлдэлд - төрийн тэргүүний (гүйцэтгэх засаглалын тэргүүн) дэг журмыг сэргээхэд чиглэсэн яаралтай арга хэмжээ авах

¹⁵Домрин А.Н. Государственно-правовой институт чрезвычайного положения. По-становка проблемы. // Конституционный вестник. 1992. № 13 (ноябрь).

¹⁶Case of Lawless v.Ireland (Strasbourg, 1 July 1961) // <http://hudoc.echr.coe.int/sites/eng/pages/search.aspx?i=001-103914>

боломжийгойлгоно.Энэ эрх мэдлийг хязгаарлавал онцгой нөхцөл байдлын эсрэг хийж байгаа шаардлагатай шуурхай хариу үйлдэл нь үр днд хүрэхгүй ба энэ нь нөхцөл байдлыг удирдлагагүй байдалд шилжих боломжийг олгож, ноцтой заримдаа бүр гамшигийн хэмжээний хор уршигийг дагуулахад хүргэж болзошгүй юм.

Чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, хувийн бодлоо илэрхийлэх, санхүүгийн үйл ажиллагаа явуулах эрх чөлөө, гэр бүлийн болон хувийн халдашгүй байдал, чөлөөтэй хөдөлмөрлөх эрх гэх мэт эдгээр хөндөгдөж байгаа хүний үндсэн эрх эрх чөлөөнд хязгаарлалт хийхийн тулд Төрийн тэргүүний эрх мэдэл бүрэн хангалттай байх ёстой.

Нийгмийн дэг журам болон аюулгүй байдлыг хангахын тулд явуулж байгаа арга хэмжээнд хууль хамгаалах байгууллагуудаас гадна цэргийн хүчийг оролцуулах хэрэгтэй, харин оролцож байгаа хүчний удирдлага, нөхцөл байдлыг хянах, нэгдсэн удирдлагыг хангахын тулд нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагын эрх хэмжээг хязгаарлаж удирдлагын түр байгууллагыг бий болгох шаардлагатай. Эдгээр асуудлуудын шийдвэр шуурхай хэрэгждэг байх нь мөн төрийн тэргүүний онцгой бүрэн эрхийн нэгэнд хамаардаг байх ёстой.

Онц байдлыг тогтоохыг Төрийн тэргүүн ганцаар хэрэгжүүлдэг ба ийм шийдвэр гаргах үндсэн шалгуур нь онцгой нөхцөл байдлын зайлшгүй бий болсон талаарх түүний үзэл бодол байдаг. Мөн түүнчлэн дээрхи нөхцөл байдалд хийж эхэлж байгаа тодорхой арга хэмжээний жагсаалтыг төрийн тэргүүн тодорхойлдог.

Ийм учраас **Онц байдал** – гэж онцгой нөхцөл байдлыг арилгах эсвэл зайлуулах зорилгоор төрийн тэргүүн ганцаар өөрийнхөө үзэмжээр хүний хувийн, нийгэм эдийн засгийн, улс төрийн эрхийг хязгаарлах арга хэмжээнүүдийн нийлбэр юм.

Төрийн эрх хэмжээг өргөтгөх нь нэг талаар бодит шаардлагатай ч, нөгөө талаар түүнийг зүй бусаар ашиглах аюултай. Хэрэв “Онцгой нөхцөл байдлын үед хүний үндсэн эрхийн хамгийн бага үндсэн хэм хэмжээ”-нд эргэж анхаарлаа хандуулбал ихэнх иш татсан заалтууд нь онц байдлын үед гүйцэтгэх засаглалын дураараа дургих бололцоо эсвэл түүний боломжийг багасгасан хэрэгслийг агуулсан байна. Энэ нь хууль тогтоох байгууллагын бүрэн эрхийн хугацаанд эрх хэмжээг нь зогсоохыг хориглох болон хууль тогтоох байгууллагын зүгээс онц байдал зарласан шийдвэрийг баталгаажуулах, авч хэрэгжүүлэх онцгой арга хэмжээний жагсаалтыг хуулиар бэхжүүлэхшаардлага юм.

ЗАРИМ ГАДААД ОРНЫ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН САХИЛГА ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ОНЦЛОГ

Алагаагийн Амарсайхан

ХСИС-ийн, Цагдаагийн сургуулийн, ГАТ-ийн
ахлах багш, докторант, цагдаагийн хошууч

Турк улсад бүх төрлийн гэмт хэрэг үйлдэгддэг, тэр тусмаа зохион байгуулалтай гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлдэг. / Жишээ нь: Хар тамхи, хууль бус цагаачлал, хүний наймаа, терроризм/ Энэ утгаараа дээрх олон төрлийн хүнд гэмт хэргүүдтэй тэмцэх цагдаагийн алба хаагчийн сахилга ёс зүйд өндөр түвшинд ач холбогдол өгдөг. Тийм учраас сахилга ёс зүйн шийтгэлүүд нь нилээн хүнд хэлбэртээ ордог байна.

БНТУ-ын цагдаагийн байгууллагын сахилга ёс зүйн дүрмийн 1-р бүлэгт дүрмийн агуулга сахилгын шийтгэлүүдийг тусгасан ба 2-р зүйлд цагдаагийн алба хаагчид дараах сахилгын шийтгэлийг оногдуулна.

1. Сануулах арга хэмжээ. Ажилдаа анхааралтай байх талаар бичгээр мэдэгдэнэ.
2. Донгодох. Ажилдаа зөрчил гаргасан талаар бичгээр мэдэгдэж анхааралтай байх талаар сануулна
3. Сарын цалинг хасах
4. Баг хугацаагаар цолны хугацааг зогсоох. Цол ахих хугацааг 4, 6, 10 сараар зогсооно
5. Урт хугацаагаар цолны хугацааг зогсоох. Цол ахих хугацааг 12, 16, 20, 24 сараар зогсооно.
6. Цагдаагийн албанаас халах. Зөвхөн цагдаагийн албанд ажиллахгүй байх
7. Төрийн албанаас халах. Төрийн аль ч салбарт ажиллахгүй байх

Сануулах арга хэмжээг доорх зөрчил гаргасан тохиолдолд оногдуулдаг.

1. Буу, албаны тусгай хэрэгсэл болон дүрэмт хувцасыг цэвэр цэмцгэр эдэлж, өмсөж, хэрэглээгүй
2. Үсээ засуулаагүй, сахлаа хусаагүй

Донгодох арга хэмжээг дараах зөрчил гаргасан тохиолдолд оногдуулна.

1. Үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа ёс бус авир гаргасан
2. Зайлшгүй шалтгаанаас бусад тохиолдолд удирдлага алагсаж харьцсан
3. Удирдлага доор ажиллаж байгаа алба хаагчдынхаа сургалтанд анхаарал тавиагүй.
4. Жижүүрийн үүргээс буусны дараа удирдлагадаа ирж мэдэгдээгүй.
5. Үүрэг гүйцэтгэж байх болох бусад үед адилхан албан тушаалтай алба хаагчидтай ёс бус харьцах

Сарын цалин хасах шийтгэлийн төрөлд:

1. 3 өдрийн ажлын цалинг хасах
2. Ёс зүйн дүрмийг санаатайгаар зөрчин үсээ ургуулах, болон хууз тавих
3. Үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа нэг нэгэнтэйгээ сугдалцаж явах, өндөр дуугаар ярьж бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах
4. Дүрэмт хувцасыг зориулалтын бусаар өмсөх
5. 4-10 өдрийн ажлын цалинг хасах
6. Хувийн дугаараа дүрэмт хувцсан дээрээ зүйхгүй байх
7. Албаны тээврийн хэрэгслийг үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа хувьдаа ашиглах
8. Албаны чухал баримт бичгийг анхаарал болгоомжгүйгээр урах
9. Удирдлагаасаа зөвшөөрөл авалгүйгээр 24 цагаас илүү 2 хүртэл өдөр шалтгаангүйгээр ажил таслах
10. 11-15 өдрийн цалинг хасах
11. Шалтгаангүйгээр 2 өдрөөс илүү 3 өдөр хүртэл ажил таслах

Богино хугацаагаар цол ахих хугацааг зогсоохдоо 3 хэсэгт ангилан авч үздэг байна. Үүнд:

А. 4 сарын хугацаатай зогсоох

- Удирдлагадаа болон алба хаагчидад ажлын талаар худал ярих
- Цагдаагийн албан байранд, болон иргэдийг хэл амаар доромжлох
- Хяналтын үүргээ биелүүлээгүй бол
- Удирдлагадаа мэдэгдэлгүйгээр хяналт шалгалтын хугацааг дуусгалгүйгээр, 2 сар хүлээлгүйгээр гэрлэх
- Шалтгаангүйгээр 3-5 хоног ажил таслах
- Үүрэг гүйцэтгэж байх хугацаанд ахлах болон удирдлагадаа хүндэтгэлгүй хандах

Б. 6 сарын хугацаатай зогсоох

- Албаны авто тээврийн хэрэгслийг үүрэг гүйцэтгэж дууссаны дараа байгууллагадаа хүлээлгэж өгөхгүй бол
- Удирдлагын зөвшөөрөлгүйгээр бусдыг уруу татан бар цэнгээний газар руу явах
- Шууд санаатайгаар доод албан тушаалтнаасаа болон иргэдээс бэлэг, зээл авах
- Албанд ашиглагдаж байгаа хөдөлгөөнт холбооны хэрэгслээр /станц/ ярихдаа бүдүүлэг үг хэрэглэх, этгээд дуу авиа гаргах
- Албаны авто машин, станц, болон бусад хэрэгслийг эвдэж хэмхлэх

В. 10 сарын хугацаатай зогсоох

- Дүрэмт хувцас, болон хангалтыг санаатай устгах
- Хэвлэл мэдээллээр ярилцлага өгөх эрхгүй алба хаагчид мэдээлэл, ярилцлага өгсөн тохиолдол

Урт хугацаагаар цол ахихыг зогсоохдоо 4 хэсэгт ангилан авч үздэг байна. Үүнд:

А. 12 сарын хугацаатай зогсоох:

- Ард иргэдийг болон Цагдаагийн байгууллагын байранд байгаа иргэнийг зодох
- Удирдлага болон ахлах цолтой алба тушаалтныг үг яриа, бичиг болон байгаа байдлаараа үл тоомсорлосон харьцаа гаргах
- Хөрөнгө оролгын мэдүүлгээ мэдүүлээгүй, хөрөнгө орлогод нь өөрчлөлт орсон тохиолдолд 1 сарын дотор удирдлагадаа мэдэгдээгүй

Б. 16 сарын хугацаатай зогсоох

- Үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа нууцлал аюулгүй байдлаа алдагдах хэмжээний байдал илэрсэн тохиолдолд

В. 20 сарын хугацаатай зогсоох

- Шалтгаангүйгээр ажлаа 5-9 хоног таслах
- Улсын хөрөнгө болох автомашин, галт зэвсэгийг ашиглах болон хангалтыг эд зүйлийг бусдад дамлан худалдаалах

Г. 24 сарын хугацаатай зогсоох

- Үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа унтах
- Ажлын хариуцлагагүйгээс гэмт хэрэгт холбогдогчыг таслан сэргийлэх арга хэмжээ аваагүйгээс алдах
- Үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа болон бусад үед удирдлагынхаа үйл ажиллагааг эсэргүүцсэн хандлагатай үг хэлэх болон бичиг бичих
- Доод албан тушаалтнаа зодох
- Ёс бус авирлах
- Ахлах албан тушаалтан болон удирдлагаа зодохыг завдах болон хэл амаар доромжлох

Цагдаагийн байгууллагаас халах шийтгэлийн төрлүүдэд дараах зөрчлүүд ордог байна. Үүнд:

1. Үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа бусдыг шашин шүтлэг, нас хүйс, арьс өнгөөр ялгаварлан гадуурахсан үйл хөдлөл гаргасан
2. Бусдыг ажил хаях талаар уриалга гаргах, турхирах, төрийн албан ердийн үйл ажиллагааг алдагдуулах
3. Өгсөн тушаалыг биелүүлэхгүй байх талаар бусдад нөлөөлөх, өдөөн хатгах
4. Ахлах албан тушаалтан болон удирдлаа зодох, заналхийлэх
5. Эрүүгийн гэмт хэрэг үйлдэхийг завдах, бусдыг гүтгэх болон худал мэдүүлэг өгөх
6. Өөрт олгогдсон эрхээ буруугаар ашиглах
7. Хуяглан хамгаалж аваачиж байгаа гэмт хэрэгтэнг санаатайгаар тавьж явуулах
8. Нууцын бичиг баримт, мэдээллийг бусдад задруулах

9. Дүрэмт хувцастай эмсийн хүрээлэн, бар цэнгээний газар руу явах
10. Биеэ үнэлэгчтэй хувийн харыдаа тогтоосон нь тогтоогдвол
11. Алба байгууллагад болон үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа архи уух
12. Үүрэг гүйцэтгэхээр ирэхдээ согтуу бол
13. Мансууруулах бодис хэрэглэх, зөөвөрлөх, нуух, орчин бүрдүүлсэн тохиолдолд
14. Мөрийтэй тоглоом тоглох, тоглуулах нөхцөл бүрдүүлэх
15. Хил нэвтрэх болон гарах хориотрий иргэдийг нэвтрүүлэх, гаргах
16. Төрийн алба хаагчийн хуульд заасан хориотой зүйлийг хийх
17. Улс төрийн намд элсэх болон тэдгээрийг дэмжсэн үйл хөдөлгөөн хийх
18. Төрийн бус байгууллага холбоодуудаас зохиогдож байгаа хурал зөвлөгөөнд хувиараа оролцох

Төрийн албанаас халах

1. Төрийн албанаас халах үйл ажиллагаа нь төрийн албаны хуулиар зохицуулагдана.

Эдгээрийг судлан үзэхэд манай цагдаагийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон үйлчилгээний стандартад дээрх дүрмийн зарим нэг зүйл хэсгийг тусган оруулах зайлшгүй шаардлага нь хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, зарж борлуулах, мөнгө угаах болон улс төрийн намын үйл ажиллагааг дэмжих зэрэг төрийн тусгай алба хаагчийн хуулиар хорглосон үйл ажиллагаа хавтгайрах хандлага тулгараад байна. Үүнд:

1. Албан үүргээ гүйцэтгэхээр ирэхдээ согтуурсан буюу мансуурсан бол
2. Мансууруулах бодис хэрэглэх, зөөвөрлөх, нуух, орчин бүрдүүлсэн тохиолдолд
3. Мөрийтэй тоглоомыг нууцаар тоглох, тоглуулах нөхцөл бүрдүүлэх
4. Улс төрийн намд далд байдлаар элсэх болон тэдгээрийг дэмжсэн үйл хөдөлгөөн хийх

Төрийн бус байгууллага холбоодуудаас зохиогдож байгаа хурал зөвлөгөөнд хувиараа оролцох тэдгээрийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж буй албан хаагч, байгууллага дээр хүчээр сурталчлах зэрэг асуудлуудыг тусгах.

Мөн цагдаагийн албан хаагчийн гаргасан сахилга ёс зүйн зөрчилд тохирсон сахилгын шийтгэлд цолыг богино болон удаан хугацаагаар зогсоох шийтгэлүүдийг оруулж өгвөл манай цагдаагийн алба хаагчдын иргэдтэй зөв харьцах цаашлаад цагдаагийн албаны нэр хүнд иргэдийн дунд нэр хүндтэй иргэд цагдааг дэмжих сэтгэлгээнд шилжинэ гэдэгт итгэлтэй байна.

ХҮНИЙ ЦУС, ЭД ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Рагчаасүрэнгийн Баярмагнай

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, гүйцэтгэх ажлын
тэнхимийн багш, докторант, цагдаагийн ахмад

Орчин үеийн шинжлэх ухааны ололт амжилтууд нь анагаах ухааны садлбарт шинэ боломжуудыг нээж байна. Энэ нь олон тооны эдгээхэд хүнд өвчнүүдийг эмчлэх үр дүнтэй аргуудыг практикт нэвтрүүлэх боломж олгож байгаа билээ. Тэдний нэг нь хүний цус, эд эрхтэн шилжүүлэн суулгалт юм. Хүний цус, эд эрхтэнийг шилжүүлэн суулгах нь хүний амь насыг аврах, эрүүл мэндийг нь нөхөн сэргээх туйлын үр дүнтэй арга юм.

Хүний цус, эд эрхтэнийг шилжүүлэн суулгах нь эрүүл мэндийн үйл ажиллагааны хамгийн үр дүнтэй, томоохон бөгөөд ихээхэн эрэлттэй чиглэлүүдийн нэг юм.

Эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын эерэг үр дүнгүүд нь эд эрхтэнээ шилжүүлэн суулгуулахыг хүсэгчдийн тоог их хэмжээгээр нэмэгдүүлжээ. Бүх өндөр хөгжилтэй улс орнуудад хүний цус, эд эрхтэн шилжүүлэн суулгалтын эрүүл мэндийн төвүүд байгуулагдсан байна. Ийм төвүүдийн үр дүнтэй үйл ажиллагааны зорилгоор донор эрхтэнүүдийн тухай болон хэрэгтэй хүлээн авагчдын мэдээллийн сангууд үүсгэгдсээр байна.

Олон улс орнууд, түүний дотор Монгол Улсын эрүүл мэндийн практикт хүний цус, эд эрхтэн шилжүүлэн суулгалт нь эмнэлгийн туршилтын хүрээнээс гарч хүнд өвчнүүдийг эмчлэх аргуудын нэг болжээ. Хүний эд, эрхтэнг шилжүүлэн суулгах мэс заслууд нь хүнийг эрүүл бүтэн амьдралд буцаан оруулдаг нь тухайн хүнд төдийгүй нийгэмд ч багагүй чухал зүйл юм.

Гэвч эерэг зүйлсийн зэрэгцээ хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгалтыг хэрэглэх нь олон тооны эрх зүйн болон ёс зүйн асуудлуудыг төрүүлсэн бөгөөд тэдгээрийг өнөөдөр хүртэл шийдэж чадаагүй байна.

Эрхтэн шилжүүлэн суулгалтын хамгийн чухал ёс зүйн асуудал нь нөгөө хүний эд, эрхтэнийг салган авах замаар өвчтэй хүнийг аврах буюу амьдрах хугацааг уртасгахад оршдог. Хэдийгээр эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын эх үүсвэр нь нас барсан хүний цогцосноос салган авсан эд, эрхтэн байж болох ч энэ тохиолдолд ч эрх зүйн болон ёс зүйн асуудлууд бүрэн хэмжээгээр арилдаггүй.

Хүний эд, эрхтэнийг шилжүүлэн суулгалтын эрх зүйн асуудлууд маш олон бөгөөд тэд эрхтэн шилжүүлэн суулгалтын төрөл (туршилтын буюу эмчилгээний), эрхтэн шилжүүлэн суулгалтын эх үүсвэр (амьд донор буюу эсвэл цогцос) зэргээс хамааран ангилагддаг.

Хууль зүйн шинжлэх ухааны хувьд донорын ашиг сонирхол маш чухал ач холбогдолтой байдаг. Учир нь чухамхүү түүнд хохирол учирдаг. Хэрвээ шилжүүлэн суулгаж байгаа эрхтэнийг тухайн хүнээс өөрөөс нь авч байгаа буюу өөрөөр хэлбэл донор нэгэн зэрэг хүлээн авагч болж байгаа бол эрх зүйн асуудал энд огт байхгүй. Донор, хүлээн авагч хоёр давхцахгүй байх тохиолдолд асуудал үүсдэг.

Хүний эд, эрхтэнийг шилжүүлэн суулгалтын ёс зүйн болон эрх зүйн асуудлууд нь төрийн ерөнхий шинж чанартай юм. Эрхтэн шилжүүлэн суулгалтын асуудлуудыг хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлын нэгэн адил олон улсын олон тооны байгууллагуудын зүгээс онцгой сонирхол хандуулдаг.

Нэг улс орны боломжоор тэдгээрийг шийдвэрлэх боломжгүй юм. Үндэстэн дамжсан гэмт бүлэглэлүүд янз бүрийн улс орнуудын нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг үйлдэж байгаа баримтууд нь ерөнхий эрүүгийн гэмт хэргүүдийн олон төрөл нэвтэрсэн, түүний дотор улс гүрнүүдийн хилээс гадагш эд, эрхтэн шилжүүлэн суулгах гэмт хэрэг ихэсч байгааг гэрчилж байна¹⁷.

¹⁷ Лукьянов Ф. Почка бродит по Европе ... Отдельно от хозяина / Ф. Лукьянова // Российская газета. 2000. - 2 декабря. -х. 7; Богданов, В. Смертельный конвейер / В. Богданов // Российская газета. -2004.-5 октября.-С. 7 Дмитриева О. Продал почку стал инвалидом / О. Дмитриева // Российская газета. - 2003. - 12 июля. -х. 25.

Гэмт хэрэг, тэр дундаа зохион байгуулалттай гэмт хэрэг нь хил хязгаарыг мэддэггүй бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдэгдсэн олон тооны баримтуудаар батлагдсан зүйл билээ. Хүний эд, эрхтэнийг шилжүүлэн суулгах салбарын гэмт хэрэг нь дэлхийн олон улсын хамтын нийгэмлэгт бүхэлд нь аюултай юм.

“Өөрийн улс орны аюулгүй байдлыг хангахын тулд улс орон бүрийн ашиг сонирхлыг ижил хэмжээгээр зөрчиж байгаа бүхэнд хамаатай тэр л үйлдлүүдийг тодорхойлох ёстой. Энэ нь гэмт хэрэгтнүүдэд нэлээд хэмжээгээр саад үүсгэж чадна. Энэ замд бүрэн амжилт гаргах боломж мэдээж эргэлзээтэй ч дэлхийн хамтын нийгэмлэгийн эрүүгийн гэмт хэрэгт тавих хяналтыг хүчтэй байх хэрэгтэй”¹⁸ гэж В.Н.Кудрявцев оновчтой зөв тэмдэглэжээ.

Иймээс улс орнууд хяналт тавихдаа НҮБ-ын зөвлөмжүүдийг ашиглаж хамтын ажиллагааг хөгжүүлэх хэрэгтэй гэж К.А. Беляшев, А.Г. Ходаков нарын тэмдэглэсэнтэй санал нийлэх хэрэгтэй юм. Ийм арга хэмжээг хэрэгжүүлэх үед хүний эрхийг дээд үнэ цэнэ гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнтэй холбоотойгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) 1945 оны 6-р сарын 26-ны дүрмийн 1-р зүйлд арьс өнгө, хүйс, хэл шашнаар ялгалгүйгээр хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг сайшаан дэмжиж хөгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх нь НҮБ-ын нэг гол зорилго болно гэж бэхжүүлжээ¹⁹.

НҮБ-ын хүний эрхийг хамгаалах чухал ололтуудын нэг нь 1948 оны 12-р сарын 10-ны өдөр Ерөнхий Ассамблей (Чуулган) Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан явдал юм. Ассамблей энэхүү хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэлхийн бүх улс түмэн, бүх улс гүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзвэл зохих нийтлэг зорилт болгон дэвшүүлсэн билээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3-р зүйлд хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй²⁰ гэж заасан байдаг. Эдгээр эрхүүд нь олон улсын бусад олон актуудад бэхжүүлэгдсэн байна (Иргэний болон улс төрийн эрхийн тухай 1996 оны 12-р сарын 16-ны олон улсын пакт, 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйл²¹, 1950 оны 11-р сарын 4-ний Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Конвенци, 3 дугаар зүйл²²). Үүнээс гадна 1950 оны 11-р сарын 4-ний Конвенцид хэн ч эрүүдэн шүүлт, хүнлэг бус, гутаан доромжилж хандах, гэсгээн цээрлүүлэхэд өртөх ёсгүй гэж²³ тэмдэглэсэн байдаг.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад аливаа хүн өөрийн чөлөөт зөвшөөрөлгүйгээр эрүүл мэндийн буюу шинжлэх ухааны туршлагад орох ёсгүй гэж бэхжүүлсэн байдаг²⁴. Энэ заалт нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт нь аливаа туршлагад орж байгаа хүн өөрөө чөлөөт зөвшөөрлөө илэрхийлэх тохиолдолд энэ туршилтад орж болохыг зөвшөөрч байгааг харуулж байна. Ийнхүү Пакт нь эрүүл мэндийн буюу шинжлэх ухааны туршлагад орох тухайн хүний чөлөөтэй хувьчлан илэрхийлсэн зөвшөөрлийг хуулийн ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч байна.

Туршилтын хуульд нийцсэн чанартай байх багагүй чухал нөхцөл бол эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтыг явуулахаас өмнө заавал зөвшөөрөл авах явдал юм. Тэгэхээр туршлагыг явуулж байх үедээ зөвшөөрөл авах, эсвэл туршилтад орсон хүн түүнийг явуулсны дараа сайшаах нь эдгээр үйлдлүүдийг хууль бус гэдгийг гэрчилж байна.

Өөрийн ээлжиндээ 1966 оны 12-р сарын 16-ны Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактад хүн бүр хамгийн дээд боломжит бие сэтгэцийн эрүүл мэндийн түвшинд байх эрхтэйг баталж хүлээн зөвшөөрсөн байдаг (зүйл 12)²⁵. Анагаах ухааны хувьд энэ заалт нь эмнэлгийн үйлчилгээний түвшин хүний бие болон сэтгэлийн эрүүл мэндийн дээд зэргийн түвшинг хангахад чиглэгдсэн байх ёстойг харуулж байна.

Тавьсан зорилгыг зөвхөн өндөр хөгжсөн эмнэлгийн технологийг хэрэглэн мэргэжлийн стандартыг баримталж чанартай эмнэлгийн тусламжийг үзүүлэхэд л боломжтой. Энэ заалт нь эд, эрхтэн шилжүүлэн суулгах үед эмчилгээний бусад аргуудтай харьцуулагдах үр дүнгийн асуудлыг зөвхөн шийдвэрлээд энэ аргыг давууд тооцохыг гэрчилж байна.

Хүний эд, эрхтэнийг шилжүүлэн суулгах үед хүний эрхийг хөндсөн олон улсын актуудын ихэнх хэсэг нь нийтлэг ерөнхий шинж чанартай байдаг. Тухайн актуудыг шинжлэх үед тэдний

¹⁸ Кудрявцев, В.Н. Международное уголовное право / В.Н. Кудрявцев. М.: Наука, 1999.-

¹⁹ 26. Беляшев, К. А. Международное публичное право: сборник документов. Том 1 / К.А. Беляшев, А.Г. Ходаков. М.: БЕК, 1996. X.2. 16-1

²⁰ Российская газета, 1998. 12р сарын 10. X. 12

²¹ ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн сэтгүүл. 1976. № 17 (1831). Зүйл 291

²² Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн эмхэтгэл. 1998. № 20. Зүйл 2143

²³ Женевская конвенция о защите гражданского населения во время войны- IV, 1949, статья 31

²⁴ Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн эмхэтгэл. 1998. № 20. 7 дугаар зүйл

²⁵ ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн сэтгүүл. 1976. № 17 (1831). Зүйл 291 // 17-1 ишлэл

хоорондын холбоо ба дотоод уялдаа холбоо ажиглагддаг. Нийтлэг олон улсын актууд нь эд, эрхтэн шилжүүлэн суулгах үеийн хүний эрхийг тодорхой заадаггүй бөгөөд тэд ийм зорилгыг ч тавьдаггүй. Эд, эрхтэн шилжүүлэн суулгах салбарын харилцааг зохицуулдаг тусгай олон улсын актууд энэ зорилтыг биелүүлэх ёстой байна (1947 оны Нюрнбергийн кодекс²⁶, 1964 оны Дэлхийн Анагаах Ухааны Нийгэмлэг эрүүл мэндийн холбооны Хельсинкийн тунхаглал²⁷, ДАУН (ДЭМБ) -ийн 1948 оны Женевын тунхаглал²⁸, ДАУН-ийн 1975 оны Токиогийн тунхаглал²⁹, Эмчлүүлэгчийн эрхийн тухай Лиссабоны 1981 оны тунхаглал³⁰, Терминал (эцсийн буюу нас барахын өмнөх) нөхцөл байдлын тухай Венецийн тунхаглал³¹, Хүний эрхтэнийг шилжүүлэн суулгах тухай 1987 оны тунхаглал³², Хүний эд, эрхтэнийг шилжүүлэн суулгах асуудлаар гаргасан тогтоол, 1994 он³³, Биологи анагаах ухааныг хэрэглэхтэй холбоотойгоор хүний эрхэм нэр төртэй байх эрхийг хамгаалах конвенци, 1996 он³⁴)

Тусгай шинж чанартай олон улсын баримт бичгүүд нь зөвхөн донорын төдийгүй мөн хүлээн авагчийн эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлуудыг зохицуулдаг. Тэд эмчилгээний болон туршилтын эрхтэн шилжүүлэлтийг явуулахдаа субъектуудын мөрдвөл зохих олон тооны зарчим болон нөхцөлүүдийг заасан байна.

Олон улсын хэм хэмжээнүүд эд, эрхтэн шилжүүлэн суулгалтыг эмчилгээний арга гэж үзэх зарчим нөхцөлүүд ба эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын салбарт туршилт явуулах зарчим нөхцөлүүд гэж ангилдаг. Тэдгээрийг хийх явуулах өвөрмөц чанарын улмаас олон улсын хэм хэмжээнүүд тухайн төрлийн эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын үедмөрдвөл зохих нэмэлт заалтуудыг оруулсан байна.

Хүний цус, эд эрхтэнийг шилжүүлэн суулгах салбарт эмнэлгийн туршилт явуулах ихэнх зарчим болон нөхцөлүүд нь 1947 оны Нюрнбергийн Кодекс болон ДАУН-ийн (ДЭМХ) 1964 оны Хельсинкийн тунхаглалд агуулагддаг бөгөөд тэдгээрийн удиртгалд тэднийг мөрдөн сахих шаардлагатайг заасан байдаг.

Хүний цус, эд эрхтэнийг шилжүүлэн суулгах туршилт явуулах үед Дэлхийн Анагаах Ухааны Нийгэмлэгийн Хельсинкийн тунхаглалыг мөрдөх тухай шууд заалт мөн 1987 оны хүний эд эхтэнийг шилжүүлэн суулгах тухай тунхаглалд ч агуулагддаг.

Нюрнбергийн кодекс болон ДАУН-ийн Хельсинкийн тунхаглалын заалтууд дээр үндэслэн хүн дээр био эмнэлгийн судалгааг явуулах үндсэн зарчмуудыг тодруулж болно. Энэ зарчмууд нь:

Шинжлэх ухааны үндэслэлтэй байх зарчим

Эмчийн хувийн хариуцлагын зарчим

Таатай үр дүн ба судлагдаж байгаа хүний хосолсон эрсдэлийн хувь тэнцүү урьдчилсан шинж чанарын зарчим

Явуулж буй туршилтын хортой нөлөөллөөс судлагдаж байгаа хүний эрхийг хамгаалах зарчим

Судалгаа болон түүний үр дүнг олон нийтэд ил үнэн хүргэх зарчим

Судалгааны үед сайн дурын урьдчилсан, ухамсарласан, мэдээлэл авч, хариу зөвшөөрсөн байх зарчим

Шинжлэх ухаан болон нийгмийн ашиг сонирхол дээр судлагдаж байгаа хүний ашиг сонирхол давамгайлах зарчим

Шинжлэх ухааны үндэслэлтэй байх зарчим нь ДАУН-ийн Хельсинкийн тунхаглалын 1.1.-д бэхжүүлэгдсэн байдаг³⁵.

Энэ заалтад хүн объектойд био анагаах ухааны судалгаа нь бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны зарчмуудад нийцэж хангалттай хэмжээтэй лабораторийн болон амьтан дээр хийсэн судалгаатай, мөн шинжлэх ухааны зохиол бүтээлийн бүх талын мэдлэг дээр суурилсан байх ёстой.

Хүмүүс дээр био эмнэлгийн судалгаа явуулах эрхийг Хельсинкийн тунхаглал нь зөвхөн эрх бүхий клиникийн эмч эрдэм шинжилгээний ажилтан ажиглагчийн удирдлага доор мэргэжсэн

²⁶<http://<<Mediaweb>> medicine@onег.ru>

²⁷<http://www.med-pravo.ru/international/Helsinki%201.htm>

²⁸<http://www.med-pravo.ru/Ethics/seventh.htm>

²⁹<http://www.med-pravo.ru/international/Tokyo.htm>

³⁰http://www.medburg.ru/rus/documents_oms/vta

³¹<http://www.med-pravo.ru/international/Terminal.htm>

³²http://www.med-pravo.ru/international/Transpl_Decl.htm

³³http://www.med-pravo.ru/international/Transpl_Resol.htm

³⁴Московский журнал международного права. 1999. №3. С.300-309.

³⁵ДАУН-ийн Хельсинкийн тунхаглалын 1.1.-д бэхжүүлэгдсэн байдаг

шинжлэх ухааны ажилтан гүйцэтгэх ёстой (п.1.3.). Ийм шаардлагыг Нюрнбергийн кодекс ч мөн тавьдаг (зүйл 3.8.).

Тунхаглалд судалгаа явуулах зайлшгүй нөхцөлийг ч мөн заадаг. 1-рт, объект нь хүн болох судалгаа бүрийг явуулах журмыг маш нарийн тодорхой томъёолсон байх ёстой (Тунхаглалын 1.3.). 2-рт, хянан судлах, үнэлэх, залруулга хийхийн тулд тусгай хөндлөнгийн хороо комисст туршилтын протокол тэмдэглэлийг шилжүүлсэн байх ёстой (Тунхаглалын 1.5).

Хэдийгээр судалгааны объектуудад мэдээлэгдсэн зөвшөөрлийг авдаг боловч судалгааны объектын амь ас эрүүл мэндийн төлөө хүлээх хариуцлагыг үргэлж эмчид онооно (Тунхаглалын 1.3.). Харин Нюрнбергийн кодексод зөвхөн эмчид төдийгүй туршилтыг санаачлагч болон удирдагчид хариуцлага оноож байна (п.1). Үүнд л эмчийн хувийн хариуцлагын зарчим оршиж байгаа юм.

Таатай үр дүн ба судлагдаж байгаа хүний эрсдэлийн хосолсон хувь тэнцүү байх зарчмыг бэхжүүлэхдээ Тунхаглал нь судалгааны зорилго ба судлуулагчид ногдож байгаа хосолсон эрсдэлийн зэрэг тохирохгүй, хувь тэнцүү бус тохиолдолд судалгаа явуулахыг хориглож байна (1.4, 1.7). Түүгээр зогсохгүй Тунхаглалд магадлалт урьдчилан тааварлагдаагүй эрсдэлийг урьдчилан нягт нарийн үнэлж, энэ эрсдэлийг судалгааны хүлээгдэж байгаа сайн үр дүнтэй нарийн харьцуулах шаардлагатайг заажээ. (п.1.5).

Нюрнбергийн кодекс дурдсан заалтыг нэмж, туршилт нь судалгааны бусад арга замаар хүрэх боломжгүй тийм эерэг сайн үр дүнг нийгэмд авчирч байх ёстой гэж тодорхойлжээ. Туршилтыг явуулахтай холбоотой эрсдэл нь тухайн туршилтын чиглэсэн асуудлын хүмүүнлэг чухал чанараас хэзээ ч давж гарах ёсгүй (п. 2.6).

Явуулж буй туршилтын хортой нөлөөллөөс судлуулагчийн эрхийг хамгаалах зарчмыг хэрэгжүүлэхдээ Хельсинкийн Тунхаглал нь хувийн эрх чөлөө, дотоод хувийн мэдрэхүйг хүндлэх, туршигдагчийн биеийн болон оюуны эрүүл мэнд бүрэн бүтэн байдалд судалгааны үзүүлэх нөлөөллийг хамгийн багад хүргэхэд чиглэгдсэн сэрэмжлэх, болгоомжлох урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авахыг үүрэг болгож байна (п.1.6).

Судалгаа болон түүний үр дүнг олон нийгэд үнэнээр ил тодоор хүргэх зарчим нь гаргаж авсан судалгааны нарийн үнэн зөв үр дүнг хэвлүүлэн нийтлүүлэх эмчийн үүрэгт оршино. Хельсинкийн Тунхаглалын зарчимд нийцээгүй туршилтын өгөгдлүүдийг хэвлэхгүй (п. 1.8)

Дараачийн бөгөөд хамгийн чухал зарчим бол судалгааны үед сайн дурын урьдчилсан, ухамсарласан, мэдээлэл авч, хариу зөвшөөрсөн байх зарчим юм ³⁶ (Тунхаглалын 1.9, 1.10, Нюрнбергийн кодексын п.1). Энэ зарчим нь судалгааг зөвхөн зөвшөөрөл авсны дараа явуулах ёстойг гэрчилж байгаа бөгөөд гэхдээ Тунхаглалд хувийн зөвшөөрлийг заавал авах заалтуудыг агуулахгүй байгаад анхаарал хандуулах хэрэгтэй.

Үүнийг бид яагаад тодруулан хэлж байна вэ гэвэл хууль ёсны төлөөлөгч (туршигдагч эрх зүйн чадамжгүй бол)³⁷ буюу хариуцлагатай эцэг эх (туршигдагч насанд хүрээгүй бол) зөвшөөрсөн нөхцөлд эрх зүйн чадамжгүй, насанд хүрээгүй хүмүүс дээр судалгаа явуулах боломжийг Хельсинкийн Тунхаглал зөвшөөрч байна.

Зөвшөөрөл сайн дурын, ухамсарлагдсан, мэдээлэл авсан байхын тулд судалгааны зорилго болон аргууд, хүлээгдэж буй эерэг үр дүн, магадлалт эрсдэл, мөн судалгаатай холбоотой магадлалт хэцүү эвгүй байдлууд туршигдагчид мэдэгдэж байх ёстой³⁸ (ДАУН-ийн Хельсинкийн Тунхаглалын п. 1.9, Нюрнбергийн кодексын п.1).

Зөвшөөрлийг судалгаанд оролцоогүй, судалгаатай холбоотой албан ёсны харилцаанаас ог хамааралгүй эмч авах ёстойг Тунхаглалд тусгайлан заасан байна. Энэ заалтаар Тунхаглал нь судалгаанд орох судлуулах зөвшөөрлийг авахад оролцох эмч хувийн сонирхол агуулж байх явдлыг үгүйсгэж байна.

Туршигдагч зөвшөөрөл өгөхөөс татгалзах, мөн урьд нь өгсөн зөвшөөрлөө дурын мөчид цуцалж болохыг Тунхаглалд онцгойлон заажээ ³⁹ (Дэлхийн Анагаах Ухааны Нийгэмлэгийн Хельсинкийн тунхаглалын 1.9, Хүний эрх ба био анагаах ухааны тухай Конвенцийн 5-р зүйл). Үүний зэрэгцээ ийм судалгааг явуулж байгаа эмчийн санаачилгаар ч эрхтэн шилжүүлэн суулгалтын

³⁶1964 оны Дэлхийн Анагаах Ухааны Нийгэмлэг эрүүл мэндийн холбооны Хельсинкийн тунхаглалын 1.9, 1.10

³⁷Монгол Улсын Иргэний хууль. 2002. 18 дугаар зүйлд 7 хүртэлх насны этгээд, сэтгэцийн өвчнийн улмаас өөрийн үйлдэлийн учир холбогдолыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно.

³⁸1964 оны Дэлхийн Анагаах Ухааны Нийгэмлэг эрүүл мэндийн холбооны Хельсинкийн тунхаглалын 1.9

³⁹Дэлхийн Анагаах Ухааны Нийгэмлэгийн Хельсинкийн тунхаглал. 1964. 1.9, Хүний эрх ба био анагаах ухааны тухай Конвенцийн 5-р зүйл

салбарын судалгааг зогсоож болох бөгөөд хэрвээ магадлалт эрсдэл нь таатай үр дүнгээс илүү байгаа нь тогтоогдвол ийм тохиолдолд ч эмч нар судалгааг зогсоох үүрэгтэй байна⁴⁰.

Тунхаглал сүүлчийн зарчмаар шинжлэх ухаан болон нийгмийн ашиг сонирхол дээр судлагдаж байгаа хүний ашиг сонирхол давамгайлах зарчмыг тогтоож байна (п. 3.4).

Энэхүү зарчим нь туршилт шинжлэх ухаан, нийгмийн хувьд хичнээн чухал байгаагаас үл хамааран туршигдагчийн ашиг сонирхол хамгийн чухал анхдагч гэдгийг баталж байна. Зөвхөн ийм зарчимд л эмчлүүлэгчийн эрх, эрх чөлөөний хамгаалалтын баталгаажуулж болох учраас эрхтэн шилжүүлэн суулгах үед энэ зарчим тодорхойлогч, хамгийн гол зарчим байх ёстой.

Дурдсан зарчмууд нь 1996 онд Европын Холбооны сайд нарын Хороогоор батлагдсан Хүний эрх ба био анагаах ухааны тухай Конвенцид ч тусгалаа олсон байдаг.

Гэвч Хүний эрх ба био анагаах ухааны тухай Конвенци нь эрхтэн шилжүүлэн суулгах салбарт туршилт явуулах бусад заалтуудыг агуулдаг. Тухайлбал Конвенцид заавал бичгэн зөвшөөрөл авах ёстойг (зүйл 16) заасан бол Тунхаглалд бичгэн зөвшөөрөл авбал илүү сайн гэж дурдсан (п. 1.9). Мэдээж хэрэг зөвшөөрлийн бичгэн хэлбэр нь зөвхөн туршигдагчийн төдийгүй мөн тухайн судалгааг явуулж байгаа хүмүүсийн эрхийг ч илүү хангах болно.

Дурдсан эерэг заалтууд нь хамтдаа хүний амь нас, эрүүл мэндийн баталгаажсан эрхийн бүрэлдэхүүн хэсэг юм.

Эмнэлгийн туршилт явуулахыг зохицуулдаг олон улсын хэм хэмжээнүүдэд хүний эд, эрхтэнийг шилжүүлэн суулгах салбарт явагдах туршилтуудыг зохицуулсан эерэг заалтуудаас гадна мөн ноцтой дутагдлууд оршдог. Жишээлбэл, Дэлхийн Анагаах Ухааны Нийгэмлэгийн Хельсинкийн тунхаглал нь сайн дурын, ухамсарлагдаж, мэдэж зөвшөөрсөн зөвшөөрлийн зэрэгцээ эмнэлгийн туршилтын үед хүний бие мах бодод нэвтрэх бусад ажиллагааг, тухайлбал; судалгааны протокол тэмдэглэлд мэдэгдсэн онцгой шалтгаан байх үед эмчлүүлэгчийн зөвшөөрлийг авахгүй зайлсхийх эрхийг эмчид олгосон байдаг (п.2.5).

Хүнийг туршилтад орохоос зөвшөөрөл авах үүргийг үл хэрэгсэхийн тулд хангалттай байх ямар ч онцгой шалтгаан байхгүй гэж бид үзэж байна.

Тунхаглал нь мөн онцгой шалтгаануудыг дурдаж жагсаагаагүй байна. Энэ нь ийм онцгой шалтгаанууд тухайлбал; шинжлэх ухаан, нийгэм, улс орны ашиг сонирхол, сонирхол зэргийг хамааруулж болно гэсэн үг юм. Түүгээр зогсохгүй аливаа шалтгааныг онцгой эсэхийг судлаач өөрөө шийдэж байгаа буюу өөрөөр хэлбэл энэ шалтгаанууд нь субъектив болж таарч байна.

Үүнээс гадна ДАУН-ийн Хельсинкийн Тунхаглал болон Хүний эрх ба био анагаах ухааны тухай Конвенцид насанд хүрээгүй хүмүүс, эрх зүйн чадамжгүй хүмүүсийн төлөөлөгчид, засаг захиргааны байгууллага, хуулиар тодорхойлогдсон хүмүүсээс урьдчилан зөвшөөрөл авснаар тэдний (насанд хүрээгүй хүмүүс, эрх зүйн чадамжгүй хүмүүсийн) оролцоотой туршилтыг явуулах боломжийг зөвшөөрч байна. (Тунхаглалын п. 1.9, Конвенцийн 6, 17-р зүйл). Түүгээр үл барам Конвенцид судалгааны хүлээгдэж байгаа үр дүн нь тухайн хүний эрүүл мэндэд шууд ашиг авчрахгүй байхад хүртэл тухайн этгээдүүдийн оролцоотой туршилт явуулах боломжийг оруулж байна.

Ийм судалгааны зорилго нь хүний эрүүл мэндийн байдал, түүний өвчин, эрүүл мэндийн хямралын тухай шинжлэх ухааны мэдлэгийг өргөсгөхөд дэмжлэг хувь нэмэр оруулах, мөн түүнчлэн тухайн хүнд болон бусад хүмүүст ашигтай үр дүнг гарган авах явдал байна (17.2). Конвенцид бидний үзэж байгаагаар шинжлэх ухааны зорилгоор судалгаанд ороход зөвшөөрөл өгөх чадваргүй хүмүүс дээр туршилт явуулахыг зөвтөгөх оролдлого хийгдсэн мэт санагдаж байна. Энэ зөвшөөрөл нь туршигдагчийн ашиг сонирхол шинжлэх ухаан болон нийгмийн ашиг сонирхол дээр давамгайлж байх зарчимд (Тунхаглалын п. 3.4, Конвенцийн 2-р зүйл) зөрчилдөж байна.

Түүгээр зогсохгүй, ДАУН-ийн Хельсинкийн Тунхаглал асран хамгаалагчид болон хариуцлагатай эцэг эхчүүдэд (төлөөлөгч) эрх зүйн чадамжгүй буюу насанд хүрээгүй хүүхдийн өмнөөс судалгааг зөвшөөрөл өгөх эрхийг олгохдоо судалгааны зорилго ба аргын тухай хүлээгдэж буй эерэг үр дүнгийн тухай магадлалт эрсдэл болон судалгаатай холбоотой хэцүү хүнд эвгүй байдал гарч болох тухай тэдэнд мэдээлэх эмч нарын үүргийг заагаагүй байна.

Бидний үзэж байгаагаар, нийгмийн хамгийн эмзэг гишүүд болох сэтгэцийн өвчтэй болон насанд хүрээгүй хүмүүс зөвхөн тэднийг анагаах эдгээхэд туршилт чиглээгүй бол бусад тохиолдолд эмнэлгийн туршилтад орох ёсгүй гэж үзэж байна.

Ийм хоригийг нэлээд хэдэн шалтгаанаар тогтоож болно. Үүнд:

⁴⁰Дэлхийн Анагаах Ухааны Нийгэмлэгийн Хельсинкийн тунхаглал. 1964. 1.7 дугаар зүйл

1-рт, төлөөлөгч өөр хүний амь нас эрүүл мэндийг захирч байгаа нь туршигдагчийн хувийн халдашгүй дархан байдлыг хөндөж байгаа учраас тухайн этгээдийн туршилтад орохыг зөвшөөрөл хуулийн хүчгүй.

2-рт, төлөөлөгчид зөвшөөрлийг баталж байгаа үед ийм үйлдлийн жинхэнэ шалтгаан, зорилгыг тогтоох бараг боломжгүй. Магадгүй тэдний зарим нь туршилтад оруулахыг зөвшөөрөхдөө үнэхээр зөвхөн төлөөлүүлж байгаа хүнийхээ амь насыг аврах, эрүүлжүүлэх зорилгыг удирдлага болгож болно. Гэвч эрх зүйн чадамжгүй буюу насанд хүрээгүй хүний өмнөөс зөвшөөрлийг батлах зорилго нь шан харамж авах буюу өөр ашиг олох зорилго байж болох нь эд, эрхтэн шилжүүлэн суулгах салбарын харилцаанд сөрөг нөлөө үзүүлж болно.

3-рт, хүн бүрийн амьд явах, эрүүл байх, биеийн халдашгүй дархан байдлын тунхаглагдсан эрх нь зүгээр нэг тунхаглалын бус харин бодит үйлчилдэг эрх байх ёстой.

Тунхаглалд туршилтад орж байгаа хүний зөвшөөрөлгүйгээр туршилтыг явуулах боломжийг заасан болон Конвенцид эрх зүйн чадамжгүй буюу насанд хүрээгүй хүний өмнөөс тэдний төлөөлөгчид, хуулиар тодорхойлогдсон байгууллага, хүмүүс зөвшөөрөл өгөх боломжийг заасан нь тухайн хүнээс туршилтад орох зөвшөөрлийг заавал авах ёстой гэсэн зарчмын хөдөлбөргүй байдлыг үгүйсгэж байна.

Туршилтын эд, эрхтэн шилжүүлэн суулгалтыг явуулах журмыг заасан олон улсын хэм хэмжээнүүдийн явуулсан судалгаа нь олон тооны заалтуудын зөрчилтэй эсрэг тэсрэг байдлыг баталж харуулж байна.

Үүнээс өмнө бид олон улсын хэм хэмжээнүүд нь зөвхөн туршилтын эд, эрхтэн шилжүүлэн суулгахад хамаарах зарчим нөхцөлүүдийг төдийгүй мөн эмчилгээний эд, эрхтэн шилжүүлэн суулгах зарчим ба нөхцөлүүдийг агуулдаг тухай дурдаж байсан билээ.

Эмчилгээний аргын үүргээр эд, эрхтэн шилжүүлэн суулгах үед үүсэх харилцааг зохицуулах олон улсын хэм хэмжээнүүд нь туршилтын эд, эрхтэн шилжүүлэн суулгалтаас хамаагүй олон юм.

Эмчилгээний эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын салбарт харилцааг зохицуулдаг олон улсын хэм хэмжээнүүдэд ДАУН-ийн Женевийн 1948 оны тунхаглал, ДАУН-ийн Токиогийн 1975 оны тунхаглал, Өвчтөний эрхийн тухай Лиссабоны 1981 оны тунхаглал, терминал байдлын тухай 1983 оны Венецийн тунхаглал, хүний эд эрхтэнийг шилжүүлэн суулгах асуудлаар гаргасан 1994 оны тогтоол, биологи болон анагаах ухааныг хэрэглэхтэй холбоотой хүний эрхэм чанар нэр төрийг хамгаалах Конвенци, Хүний эрх болон био анагаах ухааны тухай 1996 оны Конвенци зэрэг багтана.

Олон улсын практикаас харахад хүн худалдаалах гэмт хэргийн нэг хэлбэр болох эд эрхтнийг нь авч, дамлан худалдаалах гэмт хэрэг нь:

1. Хуурч мэхлэн хил давуулан эд эрхтнийг авч дамлан худалдаалах
2. Хуурамч гэрлэлтээр халхавчлан эд эрхтэнг авч дамлан худалдаалах
3. Үрчлэлтээр халхавчлан эд эрхтэнг авч дамлан худалдаалах
4. Үхлийн явцад эд эрхтэнг ашиглах
5. Эд эрхтэнг ашиглах зорилгоор хүнийг санаатай алах
6. Хүчээр эд эрхтнээ гэрээслэх гэрээслэл бичүүлэх, эсхүл төрөл садангийн хүмүүстэй үгсэн тохиролцож, хохирогчийн эд эрхтэнг донор болгох зөвшөөрөл бичгээр гаргуулан, хүнийг санаатай алж, эд эрхтний донор болгох⁴¹ гэсэн хэлбэрүүдээр үйлдэгдэж байна.

Дурдсан олон улсын хэм хэмжээнүүдийн шинжилгээ нь эмчилгээний эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын дараахи зарчмуудыг тодруулах боломж олгож байна. Үүнд:

Донор ба хүлээн авагчийн эрхийг сахин хангах зарчим

Мэргэжлийн үүрэг болон стандартуудыг мөрдөх зарчим

Донор ба хүлээн авагчийн эрх шинжлэх ухаан болон нийгмийн ашиг сонирхол дээр давамгайлах зарчим

Эмчлүүлэгчийн (донор ба хүлээн авагчийн) урьдчилсан, мэдээлэл авсан, сайн дурын,

ухамсарласан, хариу зөвшөөрлийн зарчим

Шинжлэх ухааны үндэслэлтэй байх зарчим

Өвчтөний эмчилгээг хийх үед эмчийн хамааралгүй бие даасан байдлын зарчим

Хүний эд эрхтэнийг худалдаалахгүй байх зарчим

Дурдсан зарчмууд нь тусгай шинж чанартай олон улсын актуудад бэхжүүлэгдсэн эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын хуульд нийцсэн байдлын нөхцөлүүдэд тусгалаа олжээ.

Эмчлүүлэгчийн (донор ба хүлээн авагчийн) эрхийг сахин хангах зарчим нэлээд хэдэн олон

⁴¹Монгол Улсын Донорын тухай хуулийн 11.3-т “Амьгүй донороос эд, эрхтэн авахдаа нас барагчийн өөрийн гэрээслэл, эсхл түүний төрөл, садангийн зөвшөөрлийг бичгээр авах буюу шаардлагатай бол хуулийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэнэ”.

улсын хэм хэмжээнүүдэд бэхжүүлэгдсэн байдаг. Тухайлбал хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай 1987 оны тунхаглалд донор ба хүлээн авагчийн эрххангагдах хүртэл эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг явуулах хариуцлагыг нэг ч эмч өөртөө хүлээн авахгүй гэж заасан байна (п. 1).

Хүний эрх болон био анагаах ухааны тухай Конвенци нь биологи болон анагаах ухааныг хэрэглэхтэй холбоотойгоор хүний эрхэм нэр төр ба бие хүнийг хамгаалах, хүн бүрт ялгаваргүйгээр түүний халдашгүй дархан байдал, бусад эрх болон үндсэн эрх чөлөөг баталгаажуулах оролцогч улс орнуудын үүргийг заасан байна (зүйл 1).

ДАУН-ийн Женевийн тунхаглал анагаах ухаан эрүүл мэндийн хамтын нийгэмлэгийн гишүүнээр элсч буй этгээдүүдийн тангаргийг агуулдаг бөгөөд түүнд эмчлүүлэгчийн эрүүл мэнд, эмч хүний нэн тэргүүний хөлс шагнал гэж заасан байдаг. Эмч хүн эмчлүүлэгчийнхээ нууцыг түүнийг нас барсан хойно ч хадгалж өөрийн эрхэм үүргээ чин шударга сэтгэл, нэр төртэйгөөр гүйцэтгэх ёстой.

Мэргэжлийн үүрэг болон стандартуудыг мөрдөх зарчим нь эмчлүүлэгчийнэрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэгддэг. Үүнийг баталж Хүний цус, эд эрхтэн шилжүүлэн суулгах тухай тунхаглалд магадлалт донорт эмнэлгийн тусламж үзүүлэхэд стандартыг бууруулахыг хориглон ийм үйлдэлд ямар ч зөвтгөх цагаатгах зүйл байхгүйг тэмдэглэдэг.Эмнэлгийн тусламж үзүүлэх түвшин нь эмчлүүлэгч донор ба хүлээн авагчийн алин болохоос хамаарах ёсгүй (Тунхаглалын п.2). Мөн үүний зэрэгцээ Хүний эрх болон био анагаах ухааны тухай Конвенцид эрүүл мэндэд хамаарах бүх оролцоо, түүний дотор шинжлэх ухааны судалгаа нь мэргэжлийн үүрэг, стандартуудыг мөрдөж гүйцэтгэгдэх ёстой гэж заасан байдаг (зүйл 4).

Туршилтын журмаар эд, эрхтэн шилжүүлэн суулгахтай ижилээр эмчилгээний шилжүүлэн суулгалтад ч донор ба хүлээн авагчийн эрх шинжлэх ухаан болон нийгмийн ашиг сонирхол дээр давамгайлах зарчмыг тунхагласан байдаг.

Энэ зарчмыг Хүний эрхтэн шилжүүлэн суулгах тухай тунхаглалын 5-р зүйлд: шинжлэх ухааны ашиг сонирхолт үйлчлэх эмчийн хүсэл хоёрдогч буюу туслах, эмчлүүлэгчийн ашиг сонирхол анхдагч буюу голлох ашиг сонирхол байх ёстой гэж бэхжүүлжээ.

Дурдсан зарчим нь ДАУН-ийн Токиогийн тунхаглал (зүйл 4), Терминал байдлын тухай Венецийн тунхаглал (зүйл 1), эмчлүүлэгчийн эрхийн тухай Лиссабоны тунхаглалын удиртгал болон Хүний эрх болон био анагаах ухааны тухай Конвенци (зүйл 2) зэрэг олон улсын баримт бичгүүдэд заагджээ. Үүнээс өөрөөр байх ёсгүй, учир нь энэ зарчим эд, эрхтэн шилжүүлэн суулгахын хуульд нийцэх (хууль ёсны) чанарын үндсэн чиглэлийг тодорхойлж байна. Иймээс шинжлэх ухаан болон нийгмийн ашиг сонирхол бус харин эмчлүүлэгчийг эмчлэх зорилго нэгдүгээр байранд байх ёстой.

Эмчлүүлэгчийн (донор ба хүлээн авагчийн) урьдчилсан, мэдээлэл авсан, сайн дурын, ухамсарласан, хариу зөвшөөрлийн зарчим нь эмчилгээний эд, эрхтэн шилжүүлэн суулгалтад туршилтын эд, эрхтэн шилжүүлэн суулгалтаас өөрөөр бэхжсэн байдаг. Тухайлбал 1987 онд Дэлхийн Эрүүл мэндийн 39-р Ассамблейд донор ба хүлээн авагчийн мэдээлэл авсан, сайн дурын, ухамсарласан зөвшөөрөлтэй байх үед л хүний эд эрхтэн шилжүүлэн суулгалт гүйцэтгэгдэнэ гэж заасан байна (п.5). Туршилтын эд, эрхтэн шилжүүлэн суулгалтаас ялгаатай нь зөвхөн эмчлүүлэгчийн өөрийнх нь зөвшөөрөл хуульд нийцсэн гэж Тунхаглал тооцож байгаад анхаарал хандуулъя. Энэ заалт нь мөн олон улсын бусад олон актуудад тусгалаа олжээ. (Лиссабоны Тунхаглал, п. “с”, Хүний эрх болон био анагаах ухааны тухай Конвенци, зүйл 5).

Шинжлэх ухааны үндэслэлтэй байх зарчмыг туршилтын эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын зарчмуудын шинжилгээг хийх үед бид тодорхойлсон билээ. Эмчилгээний эд, эрхтэн шилжүүлэн суулгалтыг явуулах үеийн шинжлэх ухааны үндэслэлийн цорын ганц онцлог нь эд, эрхтэн шилжүүлэн суулгалт ба эмчилгээний бусад аргуудын харьцуулсан урьдчилсан үнэлгээ юм (Хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай Тунхаглалын 7-р зүйл). Үүнээс гадна Био анагаах ухааны Конвенци нь нас барсан хүний тохирох эд, эрхтэн байхгүй тохиолдолд л амьд донороос эрхтэн буюу эдийг салган авахыг зөвшөөрдөг (зүйл 19).

Өвчтөний эмчилгээг хийх үед эмчийн хамааралгүй бие даасан байдлын зарчим нь нэлээд хэдэн талуудтай байна.

1-рт, эмч нь эмчилгээний аргыг сонгохдоо хэн нэгнээс хамааралгүй байх ёстой (Токиогийн тунхаглалын п.4, Терминал байдлын тухай Венецийн тунхаглалын 3.3.).

2-рт, өөрийн мэргэжлийн болон ёс зүйн шийдвэрүүддээ хөндлөнгийн нөлөөнөөс хамааралгүй эмчийн тусламжийг эмчлүүлэгч авах эрхтэй

3-рт, эмчилгээний аргыг сонгоход бие даасан хамааралгүй байх эрхийг эмчид олгосноор олон улсын хэм хэмжээ нь үүгээрээ эмчилгээг хийх үеийн эмчийн хувийн хариуцлагыг хангаж байна.

Хүний цус, эд эрхтэнийг худалдаалахгүй байх зарчим нь хүний цус, эд эрхтэнээр бизнес хийхийг хориглох тухай баталж гэрчилж байна (Хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай Тунхаглалын 8, Био анагаах ухааны тухай Конвенцийн 21-р зүйл). Гэвч энэ зарчим нь олон улсын актуудад харилцан адилгүйгээр бэхжүүлэгдсэн байдаг.

Тухайлбал: Хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах тухай Тунхаглал (п.8) хүний эд эрхтэний наймааг хатуу шүүдэг. Хүний эрх болон био анагаах ухааны тухай Конвенцид арай өөрөөр, хүний бие болон түүний хэсгүүд нь санхүүгийн ашгийн (нэрлэгдсэн утгаараа) эх үүсвэр байж болохгүй гэж заан бэхжүүлсэн байдаг.

Ийм хэлбэрээр бэхжүүлэх нь хүний эд буюу эрхтэнийг салган авах, хадгалах, шилжүүлэн дамжуулахад гарах зардлыг нөхөхтэй холбоотой төлбөр авахыг хориглох хоригийг тавиагүй байна.

Дурдсан тохиолдлуудад санхүүгийн ашиг нэрлэгдсэн утгаараа биш юм. Ийм томъёоллыг үндэсний хууль тогтоомжид батлах нь зөвшөөрөгдөшгүй зүйл, учир нь гадна талаасаа хүний эд эрхтэнийг хууль ёсоор худалдаалж байгаа мэт харагдах болно. Харамсалтай нь энэ бол эмчилгээний эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын салбарт харилцааг зохицуулахад гарсан цорын ганц дутагдал бус юм.

Био анагаах ухааны тухай Конвенцид нөхөн сэргээх эд эрхтэнээ өгөх зөвшөөрлийг өгөх чадваргүй хүнээс эд эрхтэнийг салган авах боломжтой гэж зөвшөөрдөг. Донор эсэргүүцэн татгалзахгүй байхыг ийнхүү салган авах нэг нөхцөлөөр Конвенцид заасан. Эндээс хэрвээ хүн эрхтэнээ салган авахыг зөвшөөрөх чадваргүй бол ингэж салган авахыг эсэргүүцэж яаж чадах вэ гэсэн асуудал бүрэн үндэслэлтэй урган гарч байна.

Хүний цус, эд эрхтэн шилжүүлэн суулгалтын хууль ёсны байдлын зарчмууд ба нөхцөлүүдийг бэхжүүлэхдээ олон улсын хэм хэмжээнүүд нь амьд донороос эрхтэн буюу эдийг салган авах хязгаарын асуудлыг заасан байдаг.

Олон улсын хэм хэмжээнүүдийг шинжлээд эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын салбарт амьдрал дээр бодитоор хэрэгжүүлж нэвтрүүлбэл хүний эрх, эрх чөлөөний найдвартай хамгаалалтыг хангаж чадах эерэг зүйлсүүдийг дурдаж болно. Гэвч тэдгээрийн зарим хэсэг нь зөвхөн тунхаглагдсан заалт болж үлджээ. Энэ нь нэлээд хэдэн шалтгаантай.

1. Олон улс орнууд, түүний дотор Монгол Улс дотоод хууль тогтоомждоо олон улсын баримт бичгүүдийн эерэг сайн заалтуудыг ашигладаггүй.

2. Олон улсын байгууллагууд, албан утшаалтнууд хүний эрх, эрх чөлөөний найдвартай хамгаалалтыг хангахад хангалттай үр дүнтэй ажиллаж чаддаггүй.

3. Хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгах асуудлыг зохицуулж байгаа олон улсын хэм хэмжээнүүдийн өөрсдийнх нь доторхи дотоод зөрчлүүд байдаг нь тухайн баримт бичигт гарын үсэг зурсан улс орнуудын дотоод хууль тогтоомжийг үргэлж сайн тал руу нь хөтөлж чаддаггүй.

Олон улсын хэм хэмжээнүүдэд гарын үсэг зурснаар олон улсын актуудын заалтуудыг улс орны дотоод хууль тогтоомждоо оруулан шилжүүлэх үүрэг үүсдэг. Монгол Улсад энэ нь хууль тогтоомжийг өөрчлөх, хүний цус, эд эрхтэн шилжүүлэн суулгалтын салбарт үйлдэгдсэн гэмт хэргийг уучлашгүйгээр буруу зүйлчлэх, гэмт хэрэг бус гэж үзэхэд хөтөлж байна.

Олон улсын хэм хэмжээнүүдийн дурдсан зөрчил дутагдлууд нь хүний эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын салбарт харилцааг зохицуулж байгаа олон улсын актуудад гарын үсэг зурахдаа Монгол Улсын зүгээс дэнсэлж тунгаан хандах шаардлагатайг гэрчилж байна. Учир нь эдгээр актуудын заримд Монгол Улсын эрх зүйн системийн хувьд нийцэшгүй, өөр үнэ цэнийн чиг хандлагыг агуулдаг.

Эмчилгээний эд, эрхтэн шилжүүлэн суулгалтын эрх зүйн зохицуулалтад ч сөрөг зүйлс их байна. Тухайлбал, эд эрхтэний худалдаа наймааны хоригт хүний эд буюу эрхтэнийг салган авах, хадгалах, шилжүүлэн дамжуулахад гарах зардлыг нөхөхтэй холбоотой төлбөр авах нь үйлчлэхгүй хамаарахгүй байна. Зөвшөөрлөө илэрхийлэх чадваргүй хүнээс эдийг салган авах нь хуульд нийцэхээр тооцогдсон байна.

НҮБ-ЫН ИРГЭНИЙ ЦАГДАА, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Балжиннямын Баянмөнх

ХСИС-ийн цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
ахлах багш, докторант, цагдаагийн ахмад

Монгол Улс 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагад гишүүнээр элссэнээр тус байгууллагын дүрэмд заасан “НҮБ-ын бүх гишүүн олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах, ... Аюулгүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулахад шаардагдах зэвсэгт хүч гаргах, тусламж үзүүлэх” үүрэг хүлээх болсон юм.

НҮБ-ын иргэний цагдаа нь НҮБ-ын ЭСА болон НҮБ-ын өөр бусад төрлийн ажиллагаанд ихээхэн чухал үүрэгтэй оролцдог.

Монгол Улсын Засгийн газраас олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцоогоо нэмэгдүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлж ирсний үр дүнд 2002 онд анхны 2 офицерыг илгээснээс хойш дэлхийн 3 тивийн 10 улсад явагдсан энхийг дэмжих 12 ажиллагаанд Зэвсэгт хүчин, Тагнуулын Ерөнхий газар, Хил хамгаалах Ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагын нийт 5187 албан хаагч үүргээ амжилттай гүйцэтгэсэн бөгөөд өнөөгийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Баруун Сахар, Судан, Афганистан гэсэн 4 улсад нийт 326 цэргийн албан хаагч үүрэг гүйцэтгэж байгаа болно.⁴²

Ажиллагаа бүрийн мандат өөр байдаг боловч НҮБ-ын иргэний цагдаа ерөнхийдөө дараахь үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- Орон нутгийн цагдаагийн байгууллагад хяналт тавих
 - Орон нутгийн цагдаагийн байгууллыг бий болгоход туслах дэмжих сургах
 - Орон нутгийн цагдаагийн байгууллын үйл ажиллагааг уялдуулах
- НҮБ-ын иргэний цагдаагаар хууль сахиулах
- Аюулгүй байдлын орчинг бий болгох
- Ард иргэд олон нийтийг хамгаалах
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
 - Хууль дүрмийн дагуу төвийг сахисан мөрдлөг хийх замаар гэмт хэрэгтэй тэмцэх

Ерөнхийдөө богино хугацаатай ажиллагаанд иргэний цагдаа нь ардчилсан байдлаар цагдаагийн үүргийг гүйцэтгэх, хүний эрхийг дээдлэх, олон улсын стандартын дагуу орон нутгийн цагдаагийн хүчнийг шинэчлэх сургах, дахин зохион байгуулах үүргийг хүлээдэг.

Гэвч тэд шаардлагатай тохиолдолд иргэний үймээний эсрэг хариу арга хэмжээ авах болон өөрийгөө хамгаалах чадвартай байдаг. Бүх ажиллагаанд НҮБ-ын иргэний цагдаа болон орон нутгийн цагдаагийн үүрэг нь НҮБ-ын тухайн ажиллагааны ерөнхий зорилгыг биелүүлэхэд чиглэгдсэн байх бөгөөд тухайн оронд байгаа цэргийн болон өөр бусад байгууллагуудын зорилгоос ангид нарийн тодорхойлогсон байдаг.

Зарим тохиолдолд НҮБ-ын иргэний цагдаа аюулгүй тайван орчинг бий болгохоор улс төр эдийн засгийн үйл ажиллагаанд саад болж буй гэмт хэргийн сүлжээтэй тэмцэх үүрэг авч болно.

⁴² НҮБ-ын Энхийг дэмжих болон олон улсын бусад ажиллагаанд Монгол Улсаас цэргийн баг оролцуулах ажиллагааны хүрээнд хийж байгаа ажил, цаашид авах арга хэмжээний талаар Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын хэлсэн үгнээс хэсэгчлэн авав.

НҮБ-ын иргэний цагдаагийн үндсэн үүргүүд. Ажиллагааны зорилгыг биелүүлэх нь нягт хамтын ажиллагааг шаарддаг. НҮБ-ын иргэний цагдаа нь тухайн бүс нутагт байгаа бусад байгууллагуудтай өөрсдийн үйл ажиллагааг нягт уялдуулж харилцан хамтран ажиллах ёстой.

Цэргийн анги салбарууд, олон улсын байгууллагууд болон төрийн бус байгууллагуудын хүсэлтээр үндсэн үүрэгт ажиллагаанаас ажиллагаанд үүссэн цагийн байдал өгөгдсөн мандатаас шалтгаалж өөр өөр байдаг.

Тухайлбал: Техникийн боломж, гэмт хэргийн эсрэг авах арга хэмжээ болон хэрэглэх зэвсэг өөр өөр байдаг. Гэвч дараахь нийтлэг үүргүүд байдаг

- **Зөвлөх:** Орон нутгын цагдаагийн байгуулга, тэдний өдөр тутмын үйл ажилгаанд зөвлөх.

Шударга орон нутгийн цагдаагийн байгуулгыг байгуулахад дэмжлэг үзүүлэх: Орон нутгийн ард иргэдийн дунд цагдаагийн байгуулгад итгэх итгэлийг бий болгохын тулд хамгийн түрүүнд шударга, төвийг сахисан орон нутгийн цагдаагийн хүчийг бий болгох юм. Дараагийн дугаарт орон нутгийн цагдаагийн байгуулга тайван аюулгүй орчинг бие дааж хангах чадвартай байх.

Сонгууль : Хүний эрхийн нэг хэсэг болсон сонгууль нь ардчилалыг тогтоох гол тулгуур байдаг. Тийм учраас НҮБ-ын иргэний цагдаа сонгуулийн ажиглалтын гарын авлага дээр заагдсан ардчилсан сонгуулийн үйл явцад сайн дураараа оролцох ёстой. Энэ нь ардчилсан сонгуулийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор сонгуулийг үйл явцыг хянах , сонгогчдын бүртгэл хийх, сонгуулийн хайрцгыг хамгаалах зэрэг бөгөөд энэ нь сонгуулийг шударга, тэнцвэртэй, чөлөөтэй, нууц, олон нийтийн байлгахад чиглэгдсэн байдаг.

Хүний эрхийг хангах: олон улсын хууль, гэрээ, олон улсын хүний эрхийн хуулиар бүх улсууд тэдгээрийн байгууллагууд тэр дундаа хууль сахиулах байгуулгын үндсэн үүрэг

Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд дэмлэг үзүүлэх: Олон улсын хүмүүнлэгийн байгууллагууд болон иргэний хөдөлгөөнүүдийн хүмүүнлэгийн тусламж үзүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

Хууль сахиулах: Хэрэв тухайн улс хүссэн бол орон нутгийн цагдаагийн бүх үүргийг шударга мэргэжлийн түвшинд үлгэр жишээ болохуйц гүйцэтгэнэ. Энд мөрдөн байцаалт явуулах, илтгэх, хяналт тавих, гэмт хэрэгтнүүдтэй харьцах, иргэдийн үймээн эмх замбараагүй байдлыг хянах.

Хянах: Орон нутгийн цагдаагийн байгуулгын бүхийл үйл ажиллагааг хянан зөвлөж алдаа дутагдал гарвал дээд газартаа илтгэнэ.

Сонгох, элсүүлэх, сургах: НҮБ-ын ажиллагааг амжилттай болгох нэг хүчин зүйл бол тухайн орон нутгийн цагдаагийн хүчнийг зөв сонгох явдал юм.

Эдгээр үүргүүдээс гадна НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нар ажиллагааны бүх шатны удирдлагын бүрэлдхүүнийг хүндэтгэх үүрэгтэй. НҮБ-ын иргэний цагдаагаар үүрэг гүйцэтгэх гэж байгаа тохиолдолд тухайн ажиллагаанд томилогдсон иргэнийн цагдаагийн комиссар буюу даргад шууд захирагдах үүрэгтэй.

Иргэний цагдаагийн алба хаагч нь зөвхөн НҮБ-ын үүргийг гүйцэтгэнэ. Үүрэг гүйцэтгэх хугацаанд өөрийн улсын засгийн газар болон НҮБ-аас бусад газраас үүрэг даалгавар авахгүй. Иргэний цагдаагийн алба хаагч төвийг сахисан байр сууринаас үүрэг гүйцэтгэх бөгөөд өөрийн үзэл бодлыг хойш тавина. Тийм учраас тухайн ажиллагааны бүсэд байгаа хувь хүн болон байгуулгатай холбоотой гэр бүл ойрын найз нөхдөө авчирч болохгүй. Учир нь энэхүү үйлдэл нь төвийг сахисан байдлыг алдагдуулах хор уршигтай.

Хөнгөлөлт чөлөөлөлт болон үүрэг хариуцлагууд. НҮБ-ын төлөөлөгчийн хувьд НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь цэргийн ажиглагчтай нэгэн адил зарим хуулийн болон олон улсын хөнгөлөлт чөлөөлөлт эдэлнэ. Энэхүү статус нь НҮБ-ын хөнгөлөлт чөлөөлөлтийн 6-р бүлэг \НҮБ-ын Ажиллагаан дахь мэргэжилтэн\ ээр тодорхойлогдно.Гэвч энэхүү олон улсын хөнгөлөлт нь ажиллагаа явагдаж буй улсын засгийн газар хамааралтай.

Цагдаагийн алба хаагч нь биеэ авч явах байдалдаа өөрийн улсын хууль, засгийн газрын дүрэм журмыг баримтална.

Хэрвээ Цагдаагийн алба хаагч зөрчил гаргавал зөвхөн өөрийнхөө улсын эрх бүхий албан тушаалтнаар хуулийн хүрээнд шийтгэл хүлээнэ. НҮБ-ын иргэний цагдаа нь дипломат эрх албан тушаалтантай нэгэн адил биеэ авч явах ёстой.

Ерөнхий шаардлагууд: НҮБ-ын ЭСА дээд зэргийн идэвхжсэн өөрийн ажилдаа туршлагтай шударга хичээнгүй, заавар дүрэм журамыг биелүүлдэг цагдаагийн алба хаагчийг ажилуулахыг шаарддаг.

Үүнд –Ажилгааны мандатын зорилгыг биелүүлэхийн тулд хүмүүстэй харьцахдаа болон аливаа нэг цагийн байдалд зорилготой, чиглэлтэй төвийг баримталсан байх ёстой. Хүмүүстэй харьцах гэмт хэрэгтэй тэмцэх бусадтай албаны шугамаар харьцах зэргээр мэргэжлийн үүднээс

хандаж орон нутгийн иргэдээс дэмжлэг авч тухайн орон нутагт аюулгүй байдлыг тогтоох чадвартай байх ёстой. НҮБ болон орон нутгийн иргэдийн дунд харилцан бие биенээ хүндэтгэсэн харилцааг бий болгох

Тусгай шаардлагууд: НҮБ-ын ажиллагаанд алба хаагчийн үүргийг амжилттай гүйцэтгэхийн тулд дараахь мэдлэг чадваруудыг эзэмшсэн байх ёстой.

Хэлний чадвар: НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагчаар сонгогдсон цагдаагийн алба хаагч нь ажиллагааны албан ёсны хэлээр чөлөөтэй ярьж чаддаг байх ёстой. Ихэнх тохиолдолд англи, франц, испани хэл албан ёсны хэл болдог ба араб, орос, хятад хэл албан ёсны хэл болдог.

Хууль эрх: Иргэний цагдаагийн алба хаагч нь ажиллагааны бүсийн засгийн газраас олон улсын зарим хуулийн болон хөнгөлөлт чөлөөлөлтийг эдэлдэг. Гэвч тухайн улсын хууль дүрмийг чанд сахиж ёстой. 6-р бүлгийн дагуу олон улсын хуулийн хөнгөлөлт эдэлдэг боловч өөрийн улсын хууль дүрмэнд захирагдна.

Зэвсэгтэй ажиллах чадвар: Зарим тохиолдолд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн зөвшөөрлөөр зэвсэг эзэмшиж болно. Энэ тохиолдолд зэвсэг хэрэглэх заавар гардаг ба зэвсэг хэрэглэх зөвшөөрлийг бий болгодог.

Хүнд нөхцөл байдлыг бууруулах чадвар: НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь аюултай нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох, хүндэрсэн нөхцөл байдлыг намжаах бүхий л арга хэмжээг авах хэрэгтэй байдаг. Өөрийн дипломат зан байдлаа ашиглаж гэрээ хэлэлцээр хийх зэргээр нөхцөл байдлыг намжаадаг. Хүнд нөхцөл байдлыг намжаах чадвар зөвхөн дээд албан тушаалтнуудад байх ёстой чадвар биш алба хаагч бүр эзэмшиж өдөр тутам ажилдаа ашиглах шаардлага гардаг. Жишээлбэл: Олон нийтийг хамарсан эсэргүүцлийн цуглаан, иргэдийн үймээнийг зохицуулахад ашигладаг.

Хувийн чадвар: НҮБ-ын иргэний цагдаагаар ажиллах хүн нь өөрийн орноос тэс өөр нөхцөл байдалтай улс оронд өөр үүрэг гүйцэтгэн гэдгээ мэдэж байх ёстой. Ихэнхдээ хүнд нөхцөл байдал, өндөр стресстэй, өөрийн төрөлх хэлээс өөр хэлээр харилцдаг учраас НҮБ болон цагдаагийн алба хаагч илгээж байгаа улс нь НҮБ-ын иргэний цагдаагаар сонгох алба хаагчаа маш няхуур сайн шалгаж тухайн үүрэг даалгаварыг биелүүлж чадах хүнийг сонгох ёстой. Мөн дээрээс нь тухайн цагдаагийн алба хаагч үүрэг гүйцэтгэх хугцаандаа НҮБ болон өөрийн улсын нүүр царай болж байдаг. Сонгогдсон цагдаагийн алба хаагч нь биеийн эрүүл мэнд, биеийн бэлтгэл сайтай, сэтгэл, сэтгэл зүйн бэлтгэл тэсвэртэй, хүмүүстэй харьцах харьцааны өндөр соёлтой, ажиллагааны газар оронд томилогдсон албан тушаалаа гүйцэтгэх чадвартай байх ёстой.

Бие бялдрын чадвар: НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь хүнд нөхцөлд удаан хугцаагаар үүрэг гүйцэтгэдэг учир бие бялдрын болон эрүүл мэндийн хувьд өндөр бэлтгэлтэй, эрүүл байх ёстой. НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагчийн гол үүргүүдийн нэг бол явган болон машинтай эргүүл хийдэг. Заримдаа хэдэн өдрөөр ч эргүүл хийх шаардлага гардаг бөгөөд тухайн үед орон нутгийн хоол хүнсийг хэрэглэж, байрлаж, эмнэлэг эрүүл мэндийн үйлчилгээг авах шаардлага гардаг тул өөрийн эрүүл мэндийг маш сайн анхаарах шаардлагатай юм.

Дээрх нөхцөл байдлыг хангахын тулд дараахь шаардлагуудыг хангах ёстой.

-Эрүүл мэндийн хувьд эрүүл байх

-Бие бялдрын тэсвэртэй, стрессийн хүчин зүйлээс гарах чадвартай байх

-Албан үүрэг гүйцэтгэх, ажиллагаанд оролцох үед эмнэлэгийн үйлчилгээ авах боломж хомс байдаг тул ямар нэг өвчин, харшилгүй байх ёстой.

Сэтгэл зүйн бэлтгэл: Энэ шаардлага нь бие бялдрын шалгууртай адил чухал шалгуурын нэг юм. НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь зан харьцааны хувьд төлөвшсөн, хүмүүстэй харьцах чадвар өндөр, сэтгэхүйн хувьд эрүүл байх ёстой.

Өндөр стресстэй хүнд нөхцөлд өөрийгөө зөв аваад явах чадвартай байх ёстой. НҮБ-ын цагдаагийн алба хаагчийн харьцаа, үйлдэл нь НҮБ-ын ажиллагааг амжилттай болгох болон унагахыг шийддэг учир үнэнч шударга, эр зоригтой, мэргэжлийн өндөр чадвартай байх ёстой.

НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь мэргэжлийн дараахь чадваруудыг эзэмшсэн байдаг:

-Асуудлыг шийдвэрлэхийн тулд нөхцөл байдлын гүнд орж ойлгож зөв шийдвэр гаргах

-Зорилго чиглэлтэй шударга, дундыг баримталсан байх

-Найрсаг харилцаатай зарим тохиолдолд хатуу чанга, уян хатан шударга байх

-Хувийн зохион байгуулалт сайтай тэвчээртэй байх ёстой.

-Нөхөрсөг нээлттэй өөр бусад улсын алба хаагч нартай найрсаг байх

-Бусдыг итгүүлэх чадвартай, дарамт шахалтыг тэсвэрлэдэг байх,

-Удирдан зохион байгуулах чадвартай байх

Боловсрол: НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь маш сайн сургагдсан, туршлагатай дээд зэргийн мэргэжлийн чадвартай байх ёстой. Дараахь шаардлагыг хангасан хангасан байх ёстой

-Өөрийн улсын төлөөлөгч байна

-Ажилгааны хэлийг бүрэн эзэмшсэн байна

-Тухайн улсын сөргөлдөгчид болон Цагдаагийн албатай харилцах чадвартай

-Томилогдсон албан тушаалд гүйцэтгэх үүргийн чадвартай

-Сөргөлдөгч талуудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг ойлгох сэтгэхүйн чадвартай

-Гэмт хэрэг зөрчлийг шалгах үед мөрдөн байцаалт явуулж шударга шийдвэр гаргах төвийг сахисан чадвартай

-Жолооны чадвар НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь НҮБ-ын ашиглаж буй тээврийн хэрэгсэлүүд болон тэр дундаа дөрвөн дугуйндаа хөтлөгчтэй авто машиныг жолоодох эрхийн үнэмлэхтэй байх

-НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь өдөр тутмын ажиллагаандаа компьютер болон бусад техникийг ашиглах чадвартай байх

Соёлын мэдлэг: НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь өөрийн улсын соёл болон хүлээн авагч улсын соёлыг мэдэж ялгааг сайн ойлгох ёстой. Мөн түүнчлэн өөр бусад улсаас ирсэн хамтран зүтгэгч НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нарийнхаа соёлыг мэдэж хүндэтгэж харьцах ёстой. Маш олон тохиолдолд алба хаагч шашин, соёлыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай болдог. Гэвч НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь НҮБ-ын төлөөлөгч гэдгээ мэдэрч өөрийн үүргээ шударгаар гүйцэтгэх ёстой. Үүрэг гүйцэтгэж буй улсын, орон нутгийн соёл, уламжлалт хандлагыг хүндэтгэж байгаагаа үргэлж харуулж байх ёстой.

Хувийн зуршил үйлдэл: НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь өөрийн улсад хэвийн үзэгдэл байдаг зуршил нь өөр улсад эсрэг муу утгатай байх тохиолдол гардаг учир өөрийн дадал зуршилд анхаарах ёстой. Жишээлбэл: Будда, лалын шашинтай улсад хүүхдийн толгойд хүрч илэх нь маш муу утгыг агуулж байдаг. Маш олон оронд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн харилцаа, хүндэтгэл болон шашиндаа хүндэтгэлтэй ханддаг.

Тийм учраас НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь томилогдож очиж буй улсад байгаа өөрийн элчин сайдын яам болон бусад мэдээллийн эх сурвалжаас мэдээлэл авч судлах ёстой. Мөн ажилалгааны газар оронд үүрэг гүйцэтгээд ирсэн алба хаагчаасаа мэдээлэл авч соёл, шашин бусад мэдээллийг авах хэрэгтэй байдаг.

Үүрэг гүйцэтгэсэн улсаасаа шашны холбогдолтой эд зүйл, эдлэл авч гарах нь таныг гэмт хэрэг зөрчилд холбогдуулж болох юм. Ихэнх ахмад настнууд шашны холбогдолтой мэдээлэл өгөхдөө дуртай байдаг учраас мэдээлэл авахдаа ихэд хүндэтгэлтэй хандаж харьцах хэрэгтэй. Хэрэв шашин ёс заншилтай холбоотой алдаа гаргаад хүнд нөхцөл байдалд орвол маш соёлтойгоор, шударгаар уучлалт гуйж мэдээгүй байсанаа ойлгуулах хэрэгтэй.

Соёлын шоконд орсон үед даван туулах: Соёлын шоконд орох гэдэг нь аливаа хүн өөрийн дасан зохицсон газраасаа өөр газар ирж өөр соёлтой тулгарч ойлгохгүй хүнд байдалд орохыг хэлдэг.

Гэвч НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь өөрийн сургалт, дадлаг мэргэжлийн үүднээс дээрх бэрхшээлийг даван туулах чадвартай байх ёстой. Урьд нь ажилгаанд оролцож байсан алба хаагч дээрх хүндрэлийг амар хялбар давдаг. Ажилгааны өмнөх бэлтгэл дээр сайн бэлтгэх сайн судлах хэрэгтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах: НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь шийдвэр гаргагч буюу өндөр алба тушаалнуудад үргэлж нөлөөлдөг гэдгийг сайн ойлгож байх ёстой. Хэвлэл мэдээллийн ажилтнууд НҮБ-тай хамтран ажиллагчид шиг байнга хамт байдаг. Ийм учраас НҮБ-ын иргэний цагдаагийн алба хаагч нь дараахь зүйлийг анхаарах ёстой.

-Хэвлэл мэдээллийн ажилтнууд ирмэгц бүртгэж дээд албан тушаалтанд илтгэж байх хэрэгтэй.

-Хэвлэл мэдээлэлтэй харьцахаас өөр аргагүй байдалд орвол өөрийн үүрэг эрхийн хүрээнд л мэдээлэл өгөх хэрэгтэй. Өөр бусад зүйлийн талаар асуугаад байвал хэвлэл мэдээлэл хариуцсан албан тушаалтан луу явуулах хэрэгтэй. Зөвшөөрөлгүйгээр ямар нэг мэдэгдэл хийж болохгүй. НҮБ-ын явуулах гэж буй ажиллагаа, төлөвлөгөө ажиллагааны журмын талаар мэдээллийг сэтгүүлчид өгч болохгүй. Албан ёсны мэдээлэл өгөхөөс өмнө хэвлэл мэдээлэл хариуцсан албан тушаалтнаас зааварчлагаа авах хэрэгтэй.

-Ярихааса өмнө сайтар бодож чөлөөтэй, найрсаг байх хэрэгтэй. Хэрвээ сэтгүүлч дээд албан тушаалтны чинь талаар таагүй зүйл асуугаад байвал найрсгаар дээрх асуудалд хариулт өгөхгүйгээ мэдэгдэх ёстой.

-Үргэлж эерэг шударга мэдээлэлийг мэргэжлийн түвшинд өгөх ёстой.

-Орон нутгийн сөргөлдөгч талуудын талаар мэдээллийг өгч болохгүй. Мэдээллийг эсрэг тал ашиглах боломжтой байдаг.

Болох гэж буй үйл явдлын талаар өөрийн хувийн үзэл бодлыг илэрхийлж болохгүй. Хэрвээ асуултын хариултыг мэдэхгүй бол тааж хариулж болохгүй. Аль нэг талыг баримталсан мэдээлэл өгч болохгүй гэсэн зарчмуудыг баримталж ажиллана.

Дээрхи бүхнийг дүгнэж үзээд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. НҮБ-ын иргэний цагдаад тавигдах шаардлагын дагуу цагдаагийн алба хаагчдаар баг бүрдүүлж, ажиллагаанд оролцуулах бэлтгэлийг хангуулах
2. ЦЕГ-ын гадаад харилцааны хэлтсээр дамжуулан НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагааны газартай холбогдож иргэний цагдаагаар бэлтгэгдсэн алба хаагчдаас бүрдсэн багийг тодорхой ажиллагаанд бие даан оролцуулах нөхцөл боломжийг судлах
3. Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад цагдаагийн алба хаагчдын НҮБ-ын иргэний цагдаагаар ажиллуулах эрх зүйн орчинг бүрдүүлж өгөх
4. НҮБ-ын иргэний цагдаад тавигддаг шаардлагыг өөрийн орны хууль сахиулах их сургуулийн цагдаагийн сургуулийн сургалтанд тодорхой хэмжээгээр оруулж хэлбэршүүлэх

ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

Ганбаатарын Бямбадорж
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, ЦЭЗТ-ийн
багш, докторант, цагдаагийн ахмад

Нийтлэлийн агуулга:

Согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх ажиллагааны ойлголт, өнөөгийн байдал, тулгамдаж буй зарим асуудлыг нээн илрүүлж, цаашид эрүүлжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эрүүлжүүлэх үйл ажиллагааг сайжруулах үйл ажиллагааг нь хэрхэн зөв оновчтой болгох талаар авч үзсэн.

Түлхүүр үг: Эрүүлжүүлэх, албадах, согтууруулах ундаа, хэрэглэх, чадваргүй, удирдах, жолоодох.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17-р зүйлд Олон нийтийн газарт согтуугаар хэвийн бус яваа хүнийг тусгай байранд эрүүлжүүлэх, эсвэл хамгаалах хүнд нь хүлээлгэж өгнө⁴³ гэж заасан нь эрүүлжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн үндэсийг нь хуульчилжээ.

Эрүүлжүүлэх болон тухайн этгээдийг хүлээлгэн өгөхөд гарсан шууд зардлыг уул этгээд төлөх үүрэгтэй бөгөөд захиргааны хариуцлагын тухай хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсэгт: Зөрчил гаргасан этгээд согтууруулах ундаа хэрэглэж хэвийн бус байдалтай байвал түүний амь насыг хамгаалах, эрх зүйн зөрчил дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 24 цаг хүртэл хугацаагаар эрүүл ахуйн шаардлага хангасан тусгай байранд эрүүлжүүлж болно⁴⁴, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 11-р зүйлд “архидан согтууран өөрийнхөө үйлдэлийг удирдан жолоодох чадваргүй болсон этгээдийг шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллага эрүүл ахуйн шаардлага хангасан тусгай байранд эрүүлжүүлнэ”⁴⁵ гэж тус тус заажээ.

Түүнчлэн дээрхи үндэслэлүүдээс гадна өөр нэг онцлог үндэслэлийг зааж өгсөн байна. Тухайлбал: Архидан согтуурч өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй этгээд өөрөө хүсвэл түүнийг цагдаагийн байгууллага хяналтандаа авч эрүүлжүүлэх явдал юм.

Энэ тохиолдолд цагдаагийн байгууллагын захиргааны албадлагын арга хэмжээний нэг төрөл болох “эрүүлжүүлэх албадлага”-ын шинж үгүйсгэгдэж тухайн иргэнд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний нэг хэлбэр гэж үзэж болно.

Дээрхи хууль, эрхийн актуудад зааснаас үзвэл тухайн этгээд олон нийтийн газарт согтуугаар өөрийнхөө үйлдлийг удирдан жолоодох чадваргүй болсон буюу гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэн этгээд согтууруулах ундаа хэрэглэсэн байвал эрүүлжүүлэх үндэслэлтэй болох нь харагдаж байна.

Мөн эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд түүний зарим нэр томъёог нэг мөр ойлгон хэрэглэх шаардлагатай.

Хэвийн бус байдал гаргах гэдэг нь: Танхайрах зодоон цохион хийх, орилж хашгирах, чарлах, харааж зүхэх зэрэг идэвхитэй үйлдэл үг яриагаар илэрхийлэгдэх зөрчлүүдээс гадна, унаж тустлаа согтох, гудамж талбайд унах, хэвтэх үзвэр үйлчилгээний газар болон бусад олон нийтийн

⁴³ Цагдаагийн байгууллагын тухай хууль, УБ хот, 1993 он

⁴⁴ Захиргааны хариуцлагын тухай хууль, УБ хот, 1993 он

⁴⁵ Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, УБ хот, 2000 он

газарт унтах, ширээ сандал түшиж хэвтэх зэрэг идэвхигүй үйлдэл үйл ажиллагаа нэгэн адил хамаарна.

Архидан согтуурах явдалтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарласан УШД-ын 2000 оны 5-р сарын 8-ний өдрийн 151-р тогтоолд: **Өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй этгээд гэж:** Согтууруулах ундааг тохируулан хэрэглээгүйн улмаас биеэ авч явах чадваргүй болж гудамж талбай олон нийтийн газарт ухаангүй унасан эсвэл хаана байгаагаа болон очих газараа мэдэхгүй болсон, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж гэмт хэрэг үйлдэж болзошгүй болсон эсвэл өөрөө осол гэмтэл, гэмт хэрэгт өртөж болзошгүй хүнийг хэлнэ гэж тайлбарлажээ.

Харин Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5-р зүйлд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэх үндэслэлийг: Өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсоны улмаас гэр бүлийн буюу бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, хаана байгаагаа болон очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасан, энэ байдлаас болж гэмт хэрэг үйлдэх, захиргааны зөрчил гаргах, мөн өөрөө осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй болсныг үндэслэл болгон цагдаагийн алба хаагч тухайн этгээдийг хамгаалах, тусламж үзүүлэх зорилгоор эрүүлжүүлэх байранд хүргэнэ гэж заасан нь УШД-ын 2000 оны 5-р сарын 8-ний өдрийн 151-р тогтоолоор тайлбарласан “Өөрийн үйлдлийг удирдан жолоодох чадваргүй этгээдийг” тодорхойлсон тайлбарыг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд эрүүлжүүлэх үндэслэл болгон зааж өгсөн нь учир дутагдалтай байна.

Иймд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5-р зүйлд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэх үндэслэлийг нарийн тогтоож өгөх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Эрүүлжүүлэх ажиллагааны гол зорилго нь: Хууль зүйн талаасаа согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсний улмаас өөрийгөө удирдан жолоодох чадвараа алдах энэ байдлаасаа шалтгаалан гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэх, осол хэрэгт өртөх, осолдох амь нас эрүүл мэндээрээ хохирхоос урьдчилан сэргийлэхэд оршино.

Эрүүл мэндийн талаасаа: Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийн ухаан санааг сэргээх, согтууруулах ундааны үйлчлэл нөлөөлөлийг бууруулах, тухайн этгээдийн хордлогыг тайлах, ухаан санааг нь сэргээх үйл ажиллагаа гэж ойлгож болох юм.

Эрүүлжүүлэх ажиллагааг цагдаагийн байгууллага нь эрүүл ахуйн шаардлага хангасан тусгай зориулалтын байранд 24 цагаас дээшгүй хугацаагаар, ийм байр байхгүй газарт архидан согтуурч, нийгмийн хэв журмын зөрчил гаргаж байгаа этгээдийг амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулахгүйгээр эрүүлжүүлэх арга хэмжээ авах⁴⁶ гэж заасан нь эрүүлжүүлэх үйл ажиллагааг шаардлагын хэмжээнд явуулахад хүндрэл учруулсаар байна.

Дээрхи хуулийн заалтаас үзэхэд: Согтуугаар гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулахгүйгээр ямар ч байранд эрүүлжүүлж болохоор байна.

Гэтэл сум орон нутагт тухайн этгээдийн амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулахгүйгээр эрүүлжүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй байна. Учир нь хүнийг эрүүл болгох эрүүлжүүлэхийн тулд эмч, сувилагч заавал байх шаардлагатай гэтэл сум орон нутагт эрүүлжүүлэх байр, эрүүлжүүлэх байрны эмч байдаггүйгээс хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахгүйгээр эрүүлжүүлнэ гэдэг аз туршсан хэрэг болжээ.

Тухайлбал: Сумын цагдаагийн тасаг, хэсэгт эрүүлжүүлэх тусгай зориулалтын байр байхгүйгээс хэсгийн төлөөлөгч, цагдаа нар согтуугаар гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг албан өрөөндөө эрүүлжүүлдэг. Гэвч эрүүлжүүлэх байрны эмч байхгүй, цагдаагийн алба хаагч хүнийг эмчлэх, оношлох тусгай мэдлэг байхгүй учир тухайн этгээд нас барах, архины хордлогод орох зэрэг нь эргээд цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа болон хувирч ихэнх тохиолдолд цагдаагийн алба хаагч үүргээ биелүүлснийхээ төлөө эрүүгийн хариуцлага хүлээж гэмт хэрэгтэн болж байгаа зэргийг харгалзан үзэж сум орон нутагт эрүүлжүүлэх үйл ажиллагааг сумын эмнэлэгт шилжүүлж сумын эмч, сувилагч нарын удирдлаган дор эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын байранд хэрэгжүүлж энэхүү үүссэн нөхцөл байдлыг даруй арилгах шаардлагатай байна.

Өнөөгийн байдлаар цагдаагийн байгууллага эрүүлжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь өнгөц харахад болж байгаа мэт боловч мөн чанартаа өнөөгийн шаардлагыг хангаж чадахгүй байгаа нь дээр дурьдсан нөхцөл байдлаар нотлогдож байна.

⁴⁶ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, УБ хот, 1997 он.

Архидан согтуурч гэмт хэрэг зөрчил үйлдсэн этгээдийг эрүүлжүүлэх талаар хэд хэдэн хууль тогтоомжид заасан боловч эрүүлжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гомдол санал хүсэлт цөөнгүй ирдэгийг бид мэднэ. Зарим иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дулимаг байгаагаас эрүүлжүүлэх үйл ажиллагааг захиргааны шийтгэлтэй андуурах явдал ч байсаар байна.

Цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байгаа бас нэг зүйл нь алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлтэнд “Эрүүлжүүлсэн хүний тоо гэсэн” заалт байсныг зарим цагдаагийн газар хэлтэс ажил дүгнэх үзүүлэлтээсээ хассан боловч зарим төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, тасаг, хэсэг нь энэхүү үзүүлэлтээр одоог болтол ажлаа дүгнэж байгаа нь хууль зүйн үндэслэлгүйгээр хүнийг эрүүлжүүлэх, тооны хойноос хэт хөөцөлдөх зэргээр хүний эрхийг зөрчиж байна.

Цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх байрууд нь хоногт 20-оос 25 хүн хүлээн авах хүчин чадалтай боловч ихэнх тохиолдолд 30-аас дээш хүн хүлээн авч байна.

Мөн эрүүлжүүлэх байранд 1 хүнд 2 метр кв талбай оногдох ёстой боловч, одоогийн байдлаар ачаалал ихтэй үед 2-оос 3 хүнд 1-ээс 1,5 метр кв талбай оногдож байна. Үүнийг нэг талаас нь авч үзвэл архидан согтуурах явдал газар авсан нөгөө талаас хүний эрх, эрх чөлөө зөрчсөн үйлдэл дасал болсон. Үүнийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авахад хаа хаанаа анхаарал хандуулахгүй байгаатай холбон үзэж болно.

Цагдаагийн байгууллагаас эрүүлжүүлэх үйл ажиллагааны талаарх ойлголтыг тал бүрээс нь авч үзэж энэ ажиллагаанд цагдаагийн байгууллага ямар үүрэг оролцоотой байх, гарч болох сөрөг үр дагварыг судлаж энэхүү ажлыг ямар байгууллага хэрхэн яаж хэрэгжүүлэх талаар тодорхой саналыг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

“Эрүүлжүүлнэ” гэдэг нэрийнхээ утга агуулагаасаа болон хүнд үзүүлэх үйлчилгээ талаасаа ч цагдаагийн байгууллагын шууд гүйцэтгэх үүрэг биш гэдэг нь ойлгомжтой байна.

Харин энэхүү ажиллагааг эмнэлэгийн байгууллага тэр дундаа наркологийн болон хордлогын төвийн эмнэлэгийн нарийн мэргэжлийн эмч, ажилтнуудын хяналтан дор хийж гүйцэтгэх ёстой гэсэн судлаачидын дэвшүүлсэн санал оновчтой юм⁴⁷.

Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хуулийн 13-р зүйлийн 13.3 дахь хэсэгт “Зөрчил гаргасан этгээдийг түр саатуулах хугацаа 6 цагаас илүү байж болохгүй байдаг ч практикт архидан согтуурсан этгээдийг эрүүлжүүлэхийн өмнө хүний эрх, эрх чөлөөг хязгаарлан үндэслэлгүйгээр саатуулах явдал түгээмэл байна.

Энэ нь тухайн алба хаагчийн санаатай үйлдэл биш бөгөөд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд шууд хүргэх боломжгүй байдагтай холбоотой.

Өөрөөр хэлбэл: Төв орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, тасаг, хэсгийн жижүүр дээр гэмт хэрэг зөрчил үйлдсэн согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдүүдийг тухай бүр нь цагдаагийн газар, хэлтсийн эрүүлжүүлэх байранд түргэн шуурхай хүргэх боломжгүй байдаг.

Энэ нь цагдаагийн тасаг хэсэг дээр авто машин байдаггүйтэй холбоотой. Мөн архидан согтуурсан этгээдүүдийг эрүүлжүүлэх байранд хүргэх авто машины бензин шатахуун хүрэлцдэггүй, тогтоосон лимитийн хэмжээ нь бага байдаг зэрэг шалтгаанаас болж 24 цагийн хугацаанд 1-ээс 2 удаа тасаг, хэсэг дээр ирж, согтууруулах ундаа хэрэглэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдүүдийг эрүүлжүүлэх байранд хүргэж байна.

Энэ байдал нь цагдаагийн алба хаагч согтууруулах ундаа хэрэглэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдүүдийг удаан хугацаагаар тасаг, хэсгийн байранд саатуулах үндэс болж, цагдаагийн алба хаагчид хууль тогтоомж, хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс өөр аргагүй байдалд хүрч байна.

Мөн НЦГ-ын даргын тушаалаар батлагдсан эрүүлжүүлэх үйл ажиллагаа явуулахдаа үйлчлүүлэгчид арван нэгэн төрлийн үйлчилгээ үзүүлэхээр заасан бөгөөд түүний дотор багтах халуун цай, бантан, буцалсан ус өгөх, хувцаст чийгтэй цэвэрлэгээ хийх, усанд оруулах зэрэг үйлчилгээг үзүүлээгүй атлаа үйлчилгээний төлбөрийг бүрэн авч байгаа нь эрүүлжүүлэх үйлчилгээг зохих журмын дагуу бүрэн үзүүлэх явдал үгүйлэгдсээр байна.

Түүнчлэн эрүүлжүүлэх байранд хүргэгдэн ирсэн этгээдэд эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх, согтуурлын зэргийг нь тогтоох ёстой атал практикаас харахад төв орон нутгийн зарим газар, хэлтсийн эрүүлжүүлэх байранд одоог хүртэл согтуурлын зэргийг тогтоох багаж байхгүй байгаа нь гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэн этгээдийн согтуурлын зэргийг тогтоож түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага “ялыг” ялгамжтай оногдуулах, ял шийтгэлийг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тогтооход бэрхшээл учирч байгааг анхаарч согтуурлын зэргийг тогтоох ажлыг өөр арга хэрэгслээр тогтоох хэрэгцээ шаардлага бий болжээ.

⁴⁷ Хэсгийн байцаагч-2011 “Эрдэм шинжилгээний бага хуралын эмхтгэл”, УБ 2011 он. 4-р тал

Дээрхи бүхнийг дүгнэж үзвэл: Цагдаагийн байгууллагын өнөөгийн хэрэгжүүлж байгаа эрүүлжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн Хуулинд заасан хүний “эрүүл аюулгүй орчинд амьдрах”, “амьд явах, орчины бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах”, “эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах” зэрэг эрхийг зөрчих бодит нөхцөл бүрдсэн учир эрүүлжүүлэх үйл ажиллагааг эрүүл ахуйн шаардлага хангасан тусгай байранд хэрэгжүүлж, хүнийг эрүүл саруул болгох хордлого тайлах үйлчилгээ үзүүлэх чиглэлрүү нь хандуулж үйл ажиллагааг нь боловсронгуй болгох энэхүү үүргийг гүйцэтгэх байгууллагын үүрэг хариуцлагыг тодотгох ажлын зохион байгуулалтыг нь өөрчлөн эрүүлжүүлэх үйл ажиллагааг “эмнэлэгийн байгууллагад” шилжүүлж эрүүлжүүлэх болон согтуурах мансуурах донтой “өвчтэй” этгээдийг албадан эмчлэх үйл ажиллагааг нь шинэ шатанд гаргах шаардлагатай гэж бид үзэж байна.

Эрүүлжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах үүндээс дараах санал дэвшүүлж байна.

- Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүнийг эрүүлжүүлэх нь цагдаагийн байгууллагын үндсэн үүрэг биш учир эрүүлжүүлэх ажиллагааг эмнэлэгийн байгууллагад шилжүүлэн өгөх. Үүний хүрээнд “Эрүүл мэндийн тухай хууль”-д Согтсоны улмаас биеэ авч явах чадвараа алдсан, архины хордлогод орсон хүнийг эрүүл ахуйн шаардлага хангасан эмнэлэгийн байранд, хордлого тайлах төвд эрүүлжүүлнэ гэсэн заалт оруулах.
- ЦБТХ-н 17-р зүйл буюу “Эрүүлжүүлэх” гэсэн заалтыг өөрчлөн найруулж “Архины хордлого тайлах ажиллагаанд эмч эмнэлэгийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөл бололцоог хангах ажилд оролцоно гэж өөрчлөх. Эрүүлжүүлэх үүргийг эмнэлэгийн байгууллагад шилжүүлэн өгвөл эрүүлжүүлэх байранд хүргэгдэн ирсэн этгээдэд эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх, согтууралын зэргийг тогтоох үйлчилгээг шаардлага хангасан эмнэлэгийн орчин нөхцөлд хэрэгжүүлэх боломж бий болно.
- Согтууралын зэргийг цуснаас дээж авах байдлаар шалгах, эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн цусны дээжээр сан бүрдүүлэх, уг санг эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийн газраас олдсон цусан мөртэй харьцуулан шинжилгээ хийхэд ашиглах.
- Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийг архинд донтох өвчтэй эсэхийг оношлох, тэдэнд хордлого тайлах үйлчилгээ үзүүлэх.
- Цагдаагийн алба хаагч нарын ажил дүгнэх үзүүлэлтээс эрүүлжүүлсэн хүний тоо гэснийг бүрэн хасаж өөр үзүүлэлтээр ажлыг нь дүгнэдэг болгох.
- Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5-р зүйлд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэх үндэслэлийг нарийн тогтоож өгөх.
- Хөдөө сум орон нутагт эрүүлжүүлэх байр байхгүй учир эрүүлжүүлэх үйл ажиллагааг сумын эмнэлэгийн байранд эмч сувилагч нарын удирдлаган дор явуулах. Ингэснээр хөдөө орон нутагт хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын албан өрөөнд согтууруулах ундаа хэрэглэсэн этгээд нас барсан хүний тоо буурах, алба хаагч гэмт хэрэгт холбогдох, ял шийтгэгдэх явдал буурах бодит нөхцөл бүрдэнэ.
- Согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийн согтолтын зэргийг тухай бүр нь тогтоож зөрчлийн тэмдэглэл болон, үзлэг хийсэн тэмдэглэлд тусгаж хэвших зэрэг санал дэвшүүлж байна.

ХУУРАМЧ ГЭРЛЭЛТ, ҮРЧЛЭЛТЭЭР ХАЛХАВЧЛАН ҮЙЛДЭГДЭХ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨХ ЭРСДЭЛ, АНХААРАХ АСУУДАЛ

Сэнгээгийн Гантулга

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, ЭЭЗТ-ийн
ахлах багш, докторант, цагдаагийн ахлах дэслэгч

Түлхүүр үг: Хуурамч гэрлэлт, хуурамч үрчлэлт, гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлөх хүчин зүйл /factor/, гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий нөхцөл байдал.

Нэг. Гадаад улсын иргэдтэй гэрлэсэн эмэгтэйчүүдийн байдал:

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 16 дугаар зүйлд *“Эрэгтэй, эмэгтэй хүн чөлөөтэй, бүрэн харилцан зөвшилцсөний үндсэн дээр гэрлэж болно”*, Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенцийн¹¹ 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *“Хуульд заасны дагуу гэрлэлтийг эрх бүхий төлөөлөгчөөр бүртгүүлээгүй, гэрчийг байлцуулаагүй болон хоёр тал гэрлэлтийг чөлөөтэй, бүрэн хүлээн зөвшөөрч байгаагаа өөрийн биеэр илэрхийлээгүй нөхцөлд ямар ч гэрлэлт хууль ёсны хэмээн тооцогдохгүй”*, Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 11 дэх хэсэгт *“Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашиг, сонирхлыг төр хамгаална”*, Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн 6-р зүйлийн 1 дэх хэсэгт *“Энэ хуульд заасан харилцах шалтгаангүй, 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй хоёр буюу Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөнөөр гэрлэж болно”*⁴⁸ гэж тус тус заажээ. Эндээс үзэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүс хайр сэтгэлийн үндсэн дээр харилцан зөвшөөрсөн тохиолдолд гэрлэх нөхцөл хангагдахаар байна. Гэтэл монгол эмэгтэйчүүд огт уулзаагүй, хайр сэтгэлгүй гадаадын иргэнтэй төрөл бүрийн зорилгоор⁴⁹ гэр бүл зуучлалын гэх тодотголтой байгууллагуудаар зуучлуулан гэрлэж, харийн орныг зорьсоор байна.

Статистик мэдээнээс үзэхэд сүүлийн 14 жилд Монгол улсын иргэд гадаадын 79 орны 5400 иргэнтэй гэрлэсний 4062 буюу 75.2% нь БНСУ-ын иргэд байна. Энэ хугацаанд гадаадын иргэдтэй гэрлэсэн манай улсын иргэдийн тоо 21 дахин нэмэгдэж, тэдний 96 хувийг эмэгтэйчүүд, 82 хувийг 18-25 насны, 18 хувийг нь 30-35 насны эмэгтэйчүүд эзэлж байхад тэдэнтэй гадаадын 35-60 насны эрэгтэйчүүд гэрлэжээ.⁵⁰

УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газрын Бүртгэл мэдээллийн хэлтэс 1998 оноос гадаадын иргэдтэй гэрлэсэн Монгол Улсын иргэдийг бүртгэж эхэлсэн бөгөөд мөн онд 44 эмэгтэй гадаадын иргэдтэй гэрлэж байсан бол 2000 онд 79, 2004 онд 284, 2005 онд 685, 2006 онд 821, 2007 онд 976, 2008 онд 812, 2009 онд 533, 2010 онд 479, 2011 онд 391, 2012 онд 512 эмэгтэй гадаадын иргэдтэй гэрлэжээ.⁵¹ Эдгээр эмэгтэйчүүдийн олонх нь гэр бүл зуучлах товчоодоор зуучлуулан гадаадын иргэдтэй гэрлэсэн байна.

¹¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1962 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр баталж, 1964 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс хүчин төгөлдөр болж, Монгол Улс 1991 онд нэгдэн орсон.

⁴⁸ Төрийн мэдээлэл. УБ., 1999., №5

⁴⁹ Гадаад улсад суралцах, ажиллах, амьдрах зөвшөөрөл авах, өөрийгөө болон гэр бүлээ тэжээх, амар хялбар аргаар баян тансаг амьдрах гэх мэт.

⁵⁰ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. УБ., 2008., 36 дахь тал

⁵¹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. УБ.,

Энэ хугацаанд монгол эмэгтэйчүүдтэй гэрлэсэн гадаадын иргэдийг иргэний харъяалалаар нь авч үзвэл: **БНСУ-ын иргэдтэй 4062 эмэгтэй буюу 75.2% нь гэрлэсэн бол Япон улсын иргэдтэй 326 эмэгтэй, БНХАУ-ын иргэдтэй 262 эмэгтэй, ХБНГУ иргэдтэй 239 эмэгтэй, АНУ-ын иргэдтэй 12 эмэгтэй, Австрали улсын иргэдтэй 7, ОХУ-ын иргэдтэй 6, Франц улсын иргэдтэй 5, Итали улсын иргэдтэй 4, Малайз улсын иргэдтэй 2, Иран улсын иргэнтэй 1, ӨАБНУ-ын иргэнтэй 1, Камерун улсын иргэнтэй 1, Нигер улсын иргэнтэй 1, Сири улсын иргэнтэй 1, Пакистан улсын иргэнтэй 1 эмэгтэй, нийт 79 орны 5400 иргэнтэй гэрлэсэн байх бөгөөд ихэнх нь нөхрийнхөө нутаг руу явжээ.**

Гадаадын иргэдтэй гэрлэсэн монгол эмэгтэйчүүдийн дийлэнх нь БНСУ, Япон, БНХАУ, ХБНГУ, АНУ-ын иргэдтэй гэрлэсэн байгаагаас үзэхэд эдгээр эмэгтэйчүүд *“Гадаадын иргэдтэй гэр бүл болоход зуучилна”* гэсэн зарын дагуу гэмт этгээдүүдэд хууртагдан, дээрх улс орнуудад болон дэлхийн хаа нэгтээ хүчинд автан биеэ үнэлж, эд эрхтний донор болж, эсхүл боолчлогдож, өдөржин тариан талбай дээр толгой өөд татах завгүй хүчинд автан хөдөлмөрлөж байхыг үгүйсгэх аргагүй. Учир нь дээрх өндөр хөгжилтэй орнууд нь хөгжиж буй улс орнуудаас охид, эмэгтэйчүүдийг ихэвчлэн элсүүлж, худалдаалдаг болох нь НҮБ-ын тусгай илтгэгчийн илтгэл, төрийн болон төрийн бус байгууллагуудын хийсэн судалгаа, шүүхээс хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргүүд, хохирогчдын мэдүүлэг, ярилцлагаас харагдаж байна. Тухайлбал, гэр бүл зуучлалын нэгэн байгууллагаар зуучлуулж, БНСУ-ын иргэнтэй гэрлэсэн “С” охины яриа⁵².

“...Зуучлалын компани намайг “И” гэгч солонгос иргэнтэй танилцуулахдаа баян чинээлэг, хувьдаа хаустай, олон га газар эзэмшдэг, урьд нь гэрлэж байгаагүй гэж хэлсэн, харин энэ бүхэн эсрэгээрээ ядуу амьдралтай, хөдөө амьдардаг, жижигхэн байшинтай, ногоо тарьдаг талбайтай, урьд нь гэрлээд салсан, маш хэрцгий, архи их уудаг хүн байсан. Очсон өдрөөсөө л намайг загнаж харааж, өглөө 6 цагт босгон хоол, цайгаа хийлгэж, ногооны талбай дээрээ өглөөнөөс орой болтол ажиллуулж байсан. Ингээд гадаадын иргэдийг хамгаалах төвд бүх учраа хэлээд 4 хоносон. Гэтэл тус төв нөхөр рүү маань утасдаад таны эхнэр энд байна, их сэтгэл санааны дарамтанд орсон байдалтай, бас 3 сартай жирэмсэн байна гэж хэлсэн. Тэр намайг ирж аваад иүүд эмнэлэгт аваачсан. Эмч хүүхэд нь эрүүл өсч байна авахгүй гэж хэлж байхыг сонссон. Харин “И” эмчид мөнгө өгснөөр намайг наркозонд оруулж, 3 сартай хүүхдийг маань авсан. Ингээд тэнд би ажил хийж, Монгол руу ирэх зардлаа олж байж ирсэн. Намайг зуучилсан компани одоо болтол олдохгүй байна...”

Иран, Пакистан, Бангладеш, Малайз, Шинэ Зеланд, ӨАБНУ, Нигер, Сири, Непал, Хорват зэрэг улсуудын иргэдтэй гэрлэсэн монгол эмэгтэйчүүд албадан хөдөлмөрлөж, боолчлогдож байхыг үгүйсгэх аргагүй. Учир нь эдгээр улс орнуудад эмэгтэйчүүдийн нийгмийн үнэлэмж бага, тэдний эсрэг хүчирхийллийн үзүүлэлт өндөр, эмэгтэйчүүдийг эд бараатай адилтгаж худалдаж, өвлүүлж, бэлэглэж болдогтой холбоотой.

Монгол охид, эмэгтэйчүүдийг гадаадын иргэдтэй ялангуяа БНСУ-ын иргэдтэй гэрлэхэд зуучлах явдал газар авч, энэхүү үйл ажиллагаандаа интернет сүлжээг ашиглах болсон. Тухайлбал, www.hanawed.com, www.wedding-news.co.kr, www.gajawed.com, www.hopewedding.kr, www.mongol.hondamnara.com, www.wedinter119.co.kr, www.skywed.co.kr, www.innowed.co.kr зэрэг Солонгосын цахим хуудсуудад 16-47 насны нийт 194 монгол эмэгтэйн гэрэл зураг, танилцуулгын хамт байх бөгөөд эдгээр эмэгтэйчүүд БНСУ-ын иргэдтэй зуучлуулан гэрлэх хүсэлтэй гэсэн байна.

БНСУ-ын иргэдтэй гэрлэгсдийг нийт хүн амтай нь харьцуулбал: /2012 оны байдлаар/⁵³

Улсын нэр	Хүн амын тоо	БНСУ-ын иргэдтэй гэрлэгсдийн тоо	Нэг гэрлэлтэд ноогдож буй хүн ам
Монгол	2 865 000	4062	705
БНХАУ	1 318 000 000	14526	90733

2008., 35 дахь тал

⁵² Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. УБ., 2008., 36 дахь тал

⁵³ “Хүйсийн тэгш эрхийн төв” төрийн бус байгууллагын сургалтын материалаас

Вьетнам	85 100 000	6611	12872
Камбож	14 400 000	1804	7982
Япон	127 400 000	1665	76516

Монгол Улсын иргэдийн гадаадын иргэдтэй гэрлэсэн байдал, гэр бүл цуцлалт, хүүхэд үрчлэлтийн байдал⁵⁴

	Нийт гэрлэлт	Гэр бүл цуцлалт	Хүүхэд үрчлэлт
2002	186	4	10
2003	348	3	26
2004	284	13	25
2005	685	33	36
2006	821	43	34
2007	976	63	16
2008	812	52	24
2009	533	39	12
2010	479	42	3
2011	391	36	8
2012	512	51	12

Дээрх судалгаанаас үзэхэд нэг гэрлэлтэд ногдох хүн амын тоо дэлхийн зарим орнуудтай харьцуулахад бага байна. Иймд монгол эмэгтэйчүүд гадаадын иргэдтэй гэрлэж буй шалтгаан, нөхцлийг судалж тогтоох, хуурамч гэрлэлт, үрчлэлтээр халхавчлан үйлдэгддэг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх арга хэмжээг төрийн байгууллагууд төрийн бус байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Монгол улсын иргэд гадаадын иргэдтэй гэрлэх нь нэмэгдэхийн зэрэгцээ гэрлэлтээ цуцлуулах явдал мөн өсч байна. Үүний шалтгааныг гэр бүл судлаач, доктор, профессор Т.Намжил “Нөхөр болох хүнээ хараагүй, огт танихгүй байж гэрлэдэг, хэл, соёл, зан заншлын ялгаатай байдал” зэрэгтэй холбон тайлбарлажээ.

Солонгос дахь цагаач эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах байгууллагаас хийсэн судалгаагаар Солонгос эрчүүд гадны улсуудаас, тухайлбал Ази, Зүүн Өмнөд Азийн улсуудаас эхнэр авах явдал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн. Солонгос эртэй гэрлэж тус улсад ирж буй эмэгтэйчүүд хэл, соёл, амьдрал ахуйн урьдчилан төсөөлсөн, төсөөлөөгүй асуудалд орж, тус төвд ихээр ханддаг байна. Эдгээр эмэгтэйчүүдийн 37% нь төлбөрт зуучлалаар, 34.3% нь ойр дотны найз нөхдийн дэмжлэг зуучлалаар, 10% нь өөрсдөө, 7% шашны байгууллагаар дамжуулан Солонгос эртэй гэрлэсэн байжээ.

Тус байгууллагын захирал БНСУ-ын иргэн Кангийн мэдээлснээр “Эмэгтэйчүүд гэр бүл болоход зуучилсан байгууллагуудаа хууртагдан ирсэн байдаг.

Тухайлбал: Царайлаг залуу хүний зураг үзүүлэн амжилттай бизнесмэн, чинээлэг ганц бие хэмээн зуучилсан хүн нь нас хэвийсэн, ажил төрөлгүй, ядуу, зарим нь бүр өвчин эмгэгтэй байдаг.

Солонгост бэр болон ирж буй эмэгтэйчүүдийн 47% нь хадмуудтайгаа хамт амьдардаг. Энэ нь нөхөр ядуу, тусдаа гарах чадваргүйгээс шалтгаалдаг. Хөдөө газар, тариалан, ферм дээр амьдрах нь элбэг байдаг”. Солонгос дахь цагаач эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах байгууллагаас хийсэн

⁵⁴ Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн илтгэл. УБ., 2012

судалгаанд оролцогч гадаадын улсын бэр эмэгтэйчүүдийн 54% нь гэр бүл дотроо нөхөртэйгээ хир маргалддаг вэ? гэсэн асуултанд хариулахаас татгалзсан байна. Нөхөр нь насаар ахимаг байх тусмаа эхнэртээ гар хүрэх нь илүү байдаг нь судалгааны явцад ажиглагджээ.⁵⁵

Сонирхолтой нь гадны бэрүүдийн 60% нөхрөөсөө салах хүсэлгүй гэж хариулсан бол **16% нь салах өргөдлөө өгсөн, салахаас өөр аргагүй гэж хариулсан ба салах хүсэлтэй, гэр бүл цуцлуулах өргөдлөө өгсөн эмэгтэйчүүдийн дийлэнх нь Монгол, Тайланд эмэгтэйчүүд байсан байна.**

Солонгос дахь цагаач эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах байгууллагын судалгаагаар **“2015-2020 он гэхэд Солонгосын хөдөө орон нутагт гадны бэртэй гэр бүлүүд нийт гэр бүлийн 50% орчим хувийг эзлэх ба хэл соёл, зан заншил, амьдрал ахуйн ялгаанаас гарах асуудлууд байсаар байх болно”** гэжээ.⁵⁶

Гадаадын иргэдтэй гэрлэсэн манай улсын иргэд гэр бүлээ цуцлуулахад ихээхэн бэрхшээл тохиолддог. Тухайлбал, нөхрийн хүчирхийлэл, дарамтаас зугтаж болон гадаадад ажиллах, суралцах зөвшөөрөл авах зорилгоор тус улсын огт танихгүй иргэнтэй мөнгө өгч гэрлэсэн манай улсын иргэд эх орондоо ирээд гэрлэлтээ цуцлуулах талаарх хүсэлтийг холбогдоход байгууллагад тавихад эхнэр болон нөхрийн зөвшөөрөл байхгүй учир гэрлэлтийг цуцлах үндэслэлгүй, өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа учир дахин гэрлэхэд харшлах шалтгаан болдог.⁵⁷

Гадаадын иргэдтэй гэр бүл болоход зуучлах чиг үүрэг бүхий гэр бүл зуучлалын товчоод нь ямар нэг төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авдаггүй, аль нэг байгууллагад үйл ажиллагаагаа тайлагнадаггүй бөгөөд эдгээр байгууллагуудын үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчинг бүрдүүлэн өгөх, үйл ажиллагаанаас нь үүдэн гарах үр дагаварыг бүрэн хариуцдаг болгох шаардлагатай байна.

Эдгээр байгууллагуудаар зуучлуулан гадаадын иргэдтэй гэрлэсэн монгол эмэгтэйчүүд амь нас, эрүүл мэндээрээ хохирсон тохиолдол цөөнгүй гарсан боловч, зуучилсан этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгээгүй байна. Тухайлбал, “Х” гэгч эмэгтэй нэгэн гэр бүл зуучлах албаар зуучлуулан БНСУ-ын иргэн “К” гэгчтэй гэрлэж, удалгүй БНСУ руу явжээ. БНСУ-д ирснээс хойш нөхөр нь “Х”-г байнга зодож, харанхуй хонгилд хонуулдаг байжээ. Охин гэр рүүгээ утсаар ярихдаа:

- “Ээжээ намайг аваачээ! Энд үнэхээр хэцүү байна. Намайг Монголоос 12 мянган ам.доллараар худалдаж авсан учраас явуулахгүй гээд байна” гэж ярьжээ. Энэ талаар ээж нь гэр бүл зуучлах товчоонд удаа дараа хандахад:

- “Танай охин өөрөө буруутай, ааш муутайдаа тэгж байгаа. Тэгээд ч өөрөө дуртайдаа яваа биздээ. Бидэнд хамаагүй” гэдэг байсан бөгөөд харин ч цаад талд мэдэгдсэнээр охин ээжтэйгээ утсаар ярих боломжгүй болж, хэсэг хугацаанд сураг тасарчээ. 2008 оны 1 дүгээр сард охин гэрээсээ зугатаж, арай гэж Монголдоо иржээ.⁵⁸

Олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжуудаас үзэхэд гэрлэх нь насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэгдсэн, хэн нэгний оролцоогүйгээр, чөлөөтэй, ямар нэгэн төлбөргүйгээр, бие биенийгээ танин мэдэж ойлгосноор үүсэх харилцаа юм. Гэтэл нөхөр, эхнэр болох хоёр хүний хань ижлээ чөлөөтэй сонгон гэрлэх, хамтран амьдрах, үр удмаа үлдээх эрхэм нандин харилцааг хэн нэгэн ашиг хонжоо олох арга хэрэгсэл болгож байгааг зөвтгөх боломжгүй юм.

Гэрлэлтийг зуучлагчид болох албан ёсны зөвшөөрөлгүй хувь хүмүүс, компани нь охид, эмэгтэйчүүдийг элсүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгслээр “Санхүүгийн боломжтой гадаадын иргэдтэй гэрлүүлнэ” гэсэн боломж амласан зарыг тасралтгүй явуулж, зарын дагуу хандсан охид, эмэгтэйчүүдийг гадаадын иргэнтэй 1-2 удаа уулзалт хийлгэх байдлаар, эсхүл огт уулзуулалгүйгээр гэр бүлийг нь батлуулдаг байна.¹²

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол улсын (2001) хуульд гадаадын иргэдтэй гэрлэхэд зуучлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг ямар нэгэн байгууллага олгохоор тусгайлсан зохицуулаагүй байна. Иймд гадаадын иргэдтэй гэрлэхэд зуучлах үйлчилгээ үзүүлэх нэрийн дор ашиг олох үйл ажиллагааг эрхлэн эмэгтэйчүүдийн эрх ашгийг зөрчиж, хохироож байгаад дүгнэлт хийж, энэ төрлийн үйл ажиллагааг зохицуулсан эсхүл хориглосон хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байгааг дахин хэлмээр байна.

⁵⁵ Ж.Хос.”Солонгос дахь Монгол бэрүүдийн ихэнх нь нөхрөөсөө салах хүсэлтэй байдаг”./Болсон явдал.2009.08.30

⁵⁶ Ж.Хос.”Солонгос дахь Монгол бэрүүдийн ихэнх нь нөхрөөсөө салах хүсэлтэй байдаг”./Болсон явдал.2009.08.30

⁵⁷ Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

⁵⁸ “Хүйсийн тэгш эрхийн төв” төрийн бус байгууллагад хандсан эмэгтэйн ярианаас

¹² НҮБ-ын Хүүхдийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Дэлхийн Зөн- Монгол байгууллага. “Хүн худалдаалах гэмт хэрэг ба охид эмэгтэйчүүдийн бэлгийн мөлжлөг” сэдэвт судалгааны тайлан, УБ., 2007

Энэ нь манай улсын иргэд гадаадын иргэдтэй гэрлэх, эхнэр, нөхрөө өөрөө чөлөөтэй сонгох эрхийг нь хязгаарласан, хориглосон асуудал болохгүй бөгөөд харин тэдний гэрлэх эрхийг урвуулан ашиглаж, ашиг хонжоо олох арга хэрэгсэл болгож, хуурамч гэрлэлтээр халхавчлан охид, эмэгтэйчүүдийг хил давуулан худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Хоёр. Гадаад улсын иргэнд Монгол улсын харьяат хүүхдийг үрчлүүлж буй байдал:

Сүүлийн жилүүдэд гадаадын иргэд, ялангуяа анагаахын шинжлэх ухаан өндөр түвшинд хөгжсөн, эд эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийж буй тоон үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүлдэг АНУ, Франц, ХБНГУ-ын иргэд манай улсаас хүүхэд үрчилж авах,⁵⁹ хараа хяналтгүй, орон гэргүй тэнэмэл болон ядуу амьдралтай айл өрхийн хүүхдүүдийг халамжлан асрамжлах төвүүдийг өөрсдийн хөрөнгөөр санхүүжүүлэн олноор байгуулж⁶⁰ байгаагийн цаана нь халамж, асрамжийн газруудаар халхавчлан хил дамжуулан хүн худалдаалагчид гэмт үйл ажиллагаагаа явуулж байхыг үгүйсгэх аргагүй. Тухайлбал, Хүний Эрхийн Үндэсний Комисст иргэн “А” гаргасан өргөдөлдөө “Миний бие 4 жилийн оюутан байхдаа жирэмсэн болж, ар гэрийн гачигдал, эцэг, эхдээ хэлэхээс айсан, хөдөөнөөс ирсэн байсан зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан өөрийн төрүүлсэн хүүхдээ аргагүйн эрхэнд хүүхэд асрамжийн төвд өгсөн. Ингээд сургуулиа төгсч, нөхөртэй болоод дахин хүүхэд төрүүлэн асрамжийн төвөөс охиноо буцааж авах, уулзах талаар хэлэхэд уулзуулахгүй, нууц гээд мэдээлэл өгөхгүй байгаа тул хүүхдийн талаарх мэдээллийг олж өгөхөд тусална уу?”⁶¹ гэжээ.

Иргэний өргөдлийн дагуу хүүхдийн мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч танилцахад иргэн “А”-ийн охиныг түүний зөвшөөрөлгүйгээр гадаадын иргэнд үрчлүүлсэн байжээ. Энэ нь “Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай” НҮБ-ын конвенц¹³ /Гаагийн конвенц/, Гэр бүлийн тухай Монгол улсын хууль, Хууль зүй дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 100/32 дугаартай тушаалаар баталсан “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Монгол улсын харьяат хүүхэд үрчлэх талаар гадаадын иргэдийн хүсэлтийг хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянаж, гаргасан дүгнэлтийг үндэслэн Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар хүүхэд үрчлүүлэх асуудлыг эцэслэн шийдвэрлэдэг.⁶²

Тус газар гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол улсын харьяат хүүхдүүдэд хяналт тавих үүргийг хүлээдэг бөгөөд хүүхэд үрчилсэн эцэг, эхчүүд хүүхдийг 0-3 нас хүртэл хагас жил тутам, 4-8 настайд жил бүр, 9-16 настайд 2 жилд 1 удаа тухайн хүүхдийн жин, өндөр, сурлага, эрүүл мэнд зэрэг мэдээллүүдийг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газарт ирүүлж, мэдээллийг тухайн улсын орон нутгийн асуудал хариуцсан газраас баталгаажуулж тамгалдаг байна. Тус газар гадаадад үрчлэгдсэн Монгол улсын харьяат хүүхдүүддээ digital техник технологи өндөр хөгжсөн өнөө үед зөвхөн гэрэл зураг, тамгатай цаасаар хяналт тавьж байгаа нь учир дутагдалтай. Гадаад улсуудад үрчлэгдсэн хүүхдүүдийг насны хувьд авч үзвэл дийлэнх хувь нь 0-4 насны хүүхдүүд байдаг. Бага насны хүүхэд маш түргэн өсч, хувирч өөрчлөгддөг учир гэрэл зургаар хяналт таних боломжгүй. Төсөв, хөрөнгийн байдлаас шалтгаалан гадаадад үрчлэгдсэн хүүхдүүдийн аж байдалтай очиж танилцах боломж хязгаарлагдмал байдаг байна. Зарим улс орон гадаадад үрчлэгдсэн хүүхдийг тодорхой хугацаанд эх оронд нь авчирч, танилцуулах, үрчлэх зөвшөөрөл олгосон байгууллагад хүүхдийн ашиг сонирхол зөрчигдөөгүй болохыг бодитоор харуулахыг үүрэг болгодог. Гадаадын энэхүү орнуудын үрчлэгдсэн хүүхдүүддээ хяналт тавьж буй тогтолцоог нэвтрүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэн өгөх нь зүйтэй юм.

Дэлхий дахинд хүүхэд үрчлэх явдал өдөр ирэх тусам нэмэгдэж, АНУ 8000 гаруй хүүхэд, Испани улс 5700 гаруй хүүхэд үрчилснээс 2700 орчмыг БНХАУ-аас үрчилжээ. Үүнтэй уялдан БНХАУ Гадаадын иргэдэд хүүхэд үрчлэх тухай хуулиндаа өөрчлөлт оруулжээ. Энэхүү өөрчлөлтөөр

⁵⁹ 1999 оноос одоог хүртэлх хугацаанд Монгол улсын харьяат 239 хүүхэд гадаадын иргэдэд үрчлэгдсэн. /Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнийн мэдээлэл. 2013.05.15/ Манай улсаас хүүхэд үрчилж авсан үзүүлэлтээр АНУ, Герман, Франц улсууд тэргүүлж байна.

⁶⁰ Нийслэлд ажиллаж байгаа 55 асрамжийн төвийн 6 буюу 10.9% нь улсын төсвөөс, 49 буюу 89.1% нь гадаадын иргэн, байгууллагын санхүүгийн дэмжлэгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

⁶¹ ХЭҮК-т ирүүлсэн өргөдөл, № 2007/68

¹³ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1995 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

⁶² “Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-ын 12 дугаар зүйл: хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүүхэд үрчлэн авах тухай материалыг судлан үзэж боломжтой гэж үзвэл үрчлүүлж болох хүүхдийг сонгож, хүүхдийн эцэг, эхийн болон асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн газрын зөвшөөрлийг бусад бичиг баримтын хамт хүүхэд үрчлэхийг хүссэн хүнд илтгэнэ.

тус улсаас хүүхэд үрчлэх хүсэлт тавьсан гадаадын иргэд дараах шаардлагуудыг хангасан байх ёстой.⁶³ Үүнд:

- 30- 50 насны иргэн байх,
- Жилийн орлого 80.000 ам.доллараас дээш байх,
- Туранхай байх,
- Гей биш байх зэрэг болно.

Монгол улс БНХАУ-ын адилаар энэхүү харилцааг зохицуулах бие даасан хуулийг батлан гаргаж, журмаар зохицуулахаас нэн даруй тагталзах, хүүхэд үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэдэд тавих шаардлага, шалгуурыг өндөрсгөх, тодорхой болгох шаардлагатай.

Гадаадын иргэнд Монгол улсын харъяат хүүхдийг үрчлүүлэхдээ хүүхдийн эрх ашигт нийцэж байгаа эсэх, хүүхэд худалдагдах, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийг үрчлүүлэх болон үрчилсний дараах хяналт чухал юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д зааснаар “Монгол Улсын харъяат болох харьяатаас гарах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ” гэсэн заалт үрчлэгдэж байгаа хүүхдийн хувьд хэрхэн хэрэгждэг вэ? гэдэг асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Дээрх хоёр сайдын баталсан журмаар энэ асуудал Ерөнхийлөгчид огт хамаарахгүйгээр зөвхөн хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын хооронд шийдвэрлэгдэхээр зохицуулсан нь иргэдээ ялгаварлаж байна гэж үзэж болохоор байна.

Гэр бүлийн тухай хууль, Гадаадын иргэнд Монгол Улсын харъяат хүүхэд үрчлүүлэх журам зэргийг хянан үзэж, гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэхдээ үрчлэгчид ямар шаардлага, болзол тавигдахыг хуулиар нарийвчлан тогтоож, үрчлэгдсэн хүүхдийн нөхцөл байдалд хяналт тавих, эх оронд нь тодорхой хугацаанд зочлуулж, хүүхдийг эцэг эхтэй нь уулзуулах, хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад танилцуулах үүрэг зэргийг хуульчлах шаардлагатай байна.

Монгол улсад 1996 онд гэр орон, эцэг, эхийн хараа хяналтаас гадуур тэнүүлэн амьдардаг хүүхдийн тоо 4000 орчим байсан.⁶⁴ Одоогийн байдлаар эдгээр хүүхдүүдийн тоог нарийвчлан тогтоосон судалгаа хараахан байхгүй байна. 2008 оны 1-р сарын байдлаар улсын төсвөөс санхүүждэг 5, Олон улсын байгууллага, гадаадын иргэдийн санхүүжилтээр санхүүждэг 31 халамж, асрамжийн төвд 1161 хүүхэд /6 нь эхтэйгээ/ байрлаж байсан⁶⁵ бол 2010 оны 3-р сарын байдлаар зөвхөн нийслэлд улсын төсвийн санхүүжилтээр 6, Олон улсын байгууллага, гадаадын иргэдийн санхүүжилтээр 55 халамж, асрамжийн төв 1817 хүүхэдтэйгээр /6 нь эхийн хамт/ үйл ажиллагаа явуулж байгаа⁶⁶ нь олон улсын байгууллага, гадаадын иргэдийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж байгаа асрамж, халамжийн төвүүд 24-р буюу 27.9%-р өссөн, тус төвүүдэд байрлаж буй хүүхдүүдийн тоо даруй 656-р буюу 22%-иар тус тус өсчээ.

Нийслэлийн Статистикийн газрын бизнес регистрийн санд бүртгэлтэй 2717 төрийн бус байгууллагаас хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 107 байгууллага бүртгүүлсэн⁶⁷ байгаагаас үзвэл иргэдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, тэдний үйл ажиллагааг дэмжинэ гэсэн халхавчин дор хүн худалдаалах гэмт хэргийн элсүүлэгчид үйл ажиллагаагаа явуулж байхыг үгүйсгэх аргагүй. Иймд дээрх 31 хүүхдийн халамж, асрамжийн төвүүд, хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн болон бүртгүүлэлгүй энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага, тухайлбал, шашны хөдөлгөөн, цуглаануудыг зохион байгуулагчдыг байнгын хяналтанд авч ажиллах шаардлагатай.

Монгол улсын иргэд гадаадын иргэдтэй гэрлэх, монгол улсын харъяат хүүхдүүдийг гадаадын иргэдэд үрчлүүлэх явдал эрс нэмэгдсэн, манай улсын иргэдийн ихээр гэрлэж буй БНСУ, БНХАУ, Япон зэрэг улсуудад секс зах зээл эрчимтэй хөгжсөн, монгол хүүхдүүдийг үрчлэхээр хүсэлт гаргасан гадаадын иргэдэд тавих шалгуур болзол тодорхой буй, үрчлэгдсэн хүүхдүүдэд тавих хяналт хангалтгүй зэрэг нь хуурамч гэрлэлт, үрчлэлтээр халхавчлан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх эрсдлийг нэмэгдүүлж байна.

⁶³ MNB TV 2007.06.15-ны Цагийн хїрд мэдээллийн хетелбер 20.30

⁶⁴ Б.Болдбаатар.”Насанд хїрээгїй хїмїсийн гэмт явдлын шалтгаан судлалын асуудалд”.УБ.,2004.,41-р тал

⁶⁵ Нийслэлийн статистикийн газар. “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” 2008 оны 1 сарын тайлан мэдээ

⁶⁶ Хїхдийн Эрхийн Індэсний төвийн тэргїйн П.Цэвээн 2007.03.02-ны TV 9 21.10 “Монголын їрс эцэг, эхтэйгээ хамт” нээлттэй хэлэлцїїлэгт хїйсн мэдээлэл

⁶⁷ Нийслэлийн статистикийн газар. “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” 2008 оны 1 сарын тайлан мэдээ

Иймд судалгааны ажлын үр дүндээ үндэслэн дараах санал, дүгнэлтийг дэвшүүлж байна.Үүнд:

1. Гадаадын иргэдтэй гэрлэхэд зуучлах үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн актыг батлан гаргах, энэхүү үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр, тодорхой болзол шалгуурыг хангасан хуулийн этгээдэд олгодог тогтолцоонд шилжих, эсхүл энэхүү үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар хориглох,
2. Иргэдэд хуурамч гэрлэлт, үрчлэлтээр халхавчлан үйлдэгдэж болох гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ойлголт, мэдээлэл өгөх, энэхүү ажилд төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгийг авах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээгдэж буй “Гадаадын иргэдтэй гэр бүл болсноор сайхан амьдарна” гэсэн сөрөг сурталчилгаанаас давсан сурталчилгааг түгээх,
3. Гадаадын иргэдтэй гэрлэх, гэмт хэрэг үйлдэх, биеэ үнэлэх боломж, нөхцлийг бүрдүүлж буй хэвлэл мэдээллийн хэрэгслийг /цахим эх сурвалж, сонин, богино долгионы радио гэх мэт/ байнгын хяналтад авах, хариуцлагын тогтолцоог бий болгох,
4. Гадаадын иргэдэд Монгол хүүхдийг үрчлүүлэх асуудлыг журмаар бус УИХ-аас бие даасан хуулийг батлан гаргаж зохицуулах, Монгол Улсаас хүүхэд үрчилж авахаар хүсэлт гаргасан гадаадын иргэдэд тавих шалгуур, болзлыг хангаж буй эсэхэд тавих хяналтыг сайжруулах,
5. Гадаадын иргэдэд үрчлэгдсэн Монгол Улсын харъяат хүүхдүүд эрүүл аюулгүй орчинд өсч, хүмүүжиж буй эсэхэд тавих хяналтыг боловсронгуй болгох, түүнд хяналт тавих чиг үүрэг бүхий албан тушаалтнуудыг тухайн гадаадын улсуудад биечлэн явуулж хяналтыг тавьдаг олон улсын жишигт нийцүүлэх,
6. Гадаадын болон дотоодын санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн халамж асрамжийн төвүүдэд тавих мэргэжлийн байгууллагын хяналтыг боловсронгуй болгох, тухайн халамж, асрамжийн төвүүдэд хүмүүжиж буй хүүхдүүдийг гадаад хэл сургана, ардын урлаг сурталчилна зэргээр гадаадын улсууд руу авч явж буй байдал, буцааж эх оронд нь авчирч буй эсэхэд хяналт тавих,
7. Тухайн халамж асрамжийн төвүүдэд хүмүүжиж буй хүүхдүүдэд шашны сөрөг номлол эсэхэд хяналт тавих,
8. Төрсний гэрчилгээг зурагжуулах зэрэг болно.

ГАЛТ ЗЭВСЭГ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Ширэндэвийн Чулуун

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, ЦЭЗТ-ийн
ахлах багш, магистр, цагдаагийн хошууч

Цагдаагийн байгууллагаас галт зэвсэг, тусгай хэрэглэж ирсэн эрх зүйн зохицуулалт дор дурдсан байдлаар шинэчлэгдэн боловсронгуй болж ирсэн байна.

Монгол улсын цагдаагийн байгууллага түүхэн уламжлалын хувьд өргөн цар хүрээг хамардаг бөгөөд зарим судлаачдын доктор, профессор /Ph.D/ Д.Таванжин/ үзэж байгаагаар Монголын цагдаагийн түүх, түүний хөгжлийг нилээд эртнээс авч үзсэн байна.

Түүхэн хөгжлийнхөө хугацаанд цагдаагийн байгууллага зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зэвсэг тусгай хэрэгслийг чухал хэрэглүүр болгон ашиглаж ирсэн байна.

Зэвсэг, тусгай хэрэгслийг анх Чингис хааны үед их эзэн хааны алтан ургаас бүрддэг Их монгол улсын нийгмийн хэв журам сахиулах, харуул хамгаалалтын алба /хэвтүүл энэ нь шөнийн харуул хамгаалалт/, /босуул энэ нь өдрийн харуул хамгаалалт/ торгон цэрэг, хорчин гэх мэт төрийн цэрэг, цагдаагийн хэрэгцээнд ашиглаж байжээ.

Тухайлбал: Монголын нууц товчоонд бичигдэн үлдсэн байна. Чингисийн алтан ургаас бүрдсэн түүний хамгаалалтын алба зэр зэвсэгээ агсан өдрийг өдөр гэлгүй шөнийг шөнө гэлгүй хараа цавчилгүй хамгаалж байв.⁶⁸

Монголын цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа зэвсэг тусгай хэрэгсэл ашиглаж байсан уламжлалын талаар бусад түүхийн дурсгалт бичгүүдэд олонтой бичигдэж үлдсэн ажээ.

Монгол улс манжийн эзэмшлээс чөлөөлөгдсөн үеэс эхлэн цэрэг цагдаагийн үндэсний албатай болж тухайн үед төрийн цагдаагийн байгууллага зэвсэг, тусгай хэрэгсэл хэрхэн хэрэглэж байсан, ялангуяа цагдаагийн шинэ түүх эхэлсэн 1921 оны ардын хувьсгал ялснаар манай улсын нийгэм, улс төрийн тогтолцоо шинэчлэгдэж төрийн цагдаагийн байгууллага байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн үеийн цагдаагийн байгууллагаас эхлэн өнөөг хүртэл цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх асуудал нь цагдаагийн захиргааны үйл ажиллагааны арга, хэлбэрт хамаарч хөгжиж ирсэн талаархи түүхийн баримт материалуудыг судалсан юм.

Монгол улсын олноо өргөгдөсний 6 дугаар оны 12 дугаар сарын 30-нд /1916 он/ Богд хаан лүндэн буулгаж төрийн цагдаагийн алба байгуулан "Нийслэл хүрээний тойрон газруудыг цагдан сэргийлэх дүрэм хэмжээ"-г батлан гаргасан бөгөөд уг дүрмийн 3 дугаар зүйлд: "Нийслэл хүрээг цагдан сэргийлэх газрын алба хаагчдад өөр өөрийн тусгай албаны хувцас өмсөж, зэвсэг бариулан цагдан сэргийлнэ", мөн 12 дугаар зүйлд: "Цагдан сэргийлэгчид Нийслэл хүрээний газраа ... цуглагсдын дотор цаазласнаас зөрчиж хэрэлдэн шуугилдах ... муу самуун гэм гаргахад хүргэх аваас ... дарангуйлан зогсоосугай".⁶⁹

Ардын хувьсгал ялснаас хойшхи үеийн цагдаагийн байгууллагын зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг доорхи эрх зүйн актуудад дараах байдлаар тусгасан байна.

1921 оны 07 дугаар сарын 19-нд Засгийн газрын 6 дугаар хурлаар Цагдаагийн асуудлыг хэлэлцэж "Цагдан сэргийлэх байгууллагыг " Цэргийн яамны бүрэлдэхүүнд "Сэргийлэх цэрэг"

⁶⁸ Монголын нууц товчоо УБ 2004 он 198 дахь зүйл

⁶⁹ Д.Таванжин. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний хөгжилт УБ. 2000 он 12 дугаар тал

нэртэйгээр байгуулж зэвсэг хэрэглэх, жагсаал ёслолын цэрэгжүүлсэн сургууль хийлгэж байсан талаар баримт байгаа нь цагдаагийн байгууллагыг байгуулсан цагаас зэвсэг, тусгай хэрэгсэл хамт хөгжиж ирсний жишээ юм.

1923 оны 6 дугаар сард батлагдсан "Нийслэл хурээний цагдан сэргийлэх хорооны дүрэм хэмжээ" -ний 21 дүгээр зүйлд: Өдөр шөнийн цаг дор аливаа хүн учир явдал сэжиглэлтэйгээр явах буюу эсвэл буу зэвсэг ба сэжиг бүхий юм зүйлийг авч явахыг сайтар хянан байцааваас зохимой.

22 дугаар зүйлд: Аливаа харилцан хэрэлдэн шуугилдагчид буй аваас даруй ятган тарваас зохимой. Хэрэв хэрэгсэхгүй ноцолдон жанчилдахуй дор хүрвээс даруй барьж, цагдан сэргийлэх хороон дор хүргүүлэн хянан шийтгүүлвээс зохимой.

31 дүгээр зүйлд: Харьат хорооноос морьт явган цагдаа, цэргүүд манаа харуулын зэрэг ноогдсон албыг сайнаар гүйцэтгэж буй үгүйг цаг бүр хянан байцааваас зохимой гэж заажээ. Энэ нь цагдаагийн зэвсэг хэрэгсэл хэрэглэх заалтад хамаарахгүй ч зэвсгийн талаар заасан анхны заалт юм.

БНМАУ-ын 1926 оны 1 сарын 15-ны өдөр батлагдсан "Цагдан сэргийлэх газрын дүрэмд "... зэвсэг бүхий этгээд хууль цаазыг зөрчих, манаж буй объект уруу халдан довтлох үед өөр аргагүй бол цагдан сэргийлэхийн ажилтан зэвсэг хэрэглэхийг зөвшөөрөх " гэх мэт урд дүрэмд байхгүй заалтууд шинэ зүйл болон орсон байна.⁷⁰ Мөн уг дүрмийн 9-р бүлгийн 70-р зүйлд зааснаар: Цагдан сэргийлэгчид аливаа цагдан сэргийлэх явдлыг гүйцэтгэхдээ буу зэвсэг хөдөлгөн хэрэглэх боловч юуны өмнө зэвсэг хөдөлгөхгүйг ихэд бодолцвоос зохих тул хэрэв хэрхэх аргагүй онц чухал хэрэг учир тохиолдох аваас буу зэвсэг хэрэглэж болох үндэслэлүүдийг тусгайлан заажээ.⁷¹ Харин 1928 оны 1 сарын 28-ны өдөр батлагдсан "Цагдан сэргийлэх газрын дагаж явах дүрэм" -ийн 16 дугаар зүйлд: Харьат цагдаа, цэргийн албыг хаагчид дор винтов ба гар буу, сэлэм зэргийг Цэргийн явдлын яамнаа мэдүүлэн ойлгуулж хэрэглүүлбээс зохимой. Үүнд нэмэн тэмдэглэх нь:

Харьяат цагдаа цэргүүд албаны ил буу зэвсэг, хувцас хунар зүйлийг цаг үргэлж арчиж цэвэрлэх ба маш хямгатайгаар хэрэглэх явдлыг цэргийн дүрмийн ёсоор явуулмаас зохимой.

17 дугаар зүйлд: Харьат цагдаа цэргүүд дор улсын суртал ба цэргийн сургууль хийгээд мөн цэргийн хүмүүсийн сахин дагах дүрэм журам зэргийг эрх биш таниулан боловсруулбаас зохих учираа харьяат эрхлэгчдээс эрхлэн удирдах сургаж боловсруулсаар байваас зохимой гэж заасан нь зэвсэг тусгай хэрэгслийн талаар анхлан дүрэмд орсон чухал заалтуудын нэг юм.

Мөн энэ дүрмийн 9 дүгээр бүлэгт Буу зэвсэг хэрхэн хэрэглэх тухай

52 дугаар зүйлд: Цагдан сэргийлэгчид аливаа цагдан сэргийлэх явдлыг гүйцэтгэх дор буу зэвсгийг хөдөлгөхгүйг ихэд болгоомжилвоос зохихын тул хэрэв хэрхэх аргагүйн онц чухал хэрэг учир тохиолдох аваас буу зэвсэг хэрэглэж болох зүйлүүдийг жагсаасан нь :

Нэг. Аливаа буу зэвсэг бүхий хулгайч, дээрэмчин лүгээ тулалдаж барих,

Хоёр. Аливаа буу зэвсэггүй боловч олноор эсхүл ганц хүн хүчирхэн эсэргүүцэж хэрхэвчээр зогсоох аргагүй хүний амь бие дор аюул хорлол хүргэх этгээд тохиолдох

Гурав. Гяндангаас оргосон буюу хүнд ялтаныг барихуй дор тэд нар эсэргүүцэх буюу гүйцэхгүй дор хүргэх

Дөрөв. Олон хүн бүлэглэж, улсын хууль цаазыг зөрчих бөгөөд буу зэвсэг хэрэглэж эсэргүүцэх

Тав. Аливаа хүмүүс гянданд хоригдож буй ялтаныг суллаж гаргахыг хичээж, албаны манаач, цагдаа цэргүүд дор шууд тулж орох

53 дугаар зүйлд: Цагдан сэргийлэгчид үүнээс дээш заасан зүйлүүд дор буу зэвсэг хэрэглэхүй дор хэргийн байдлыг сайтар хянаж завдан бүхий дор урьдаар мэдээ болгон дээгүүр буудах ба шууд алахгүйгээр хүчин мөхөөхийг хичээвээс зохимой гэж заасан байна.

БНМАУ-ын 1934 оны 02-р сарын 02-ны өдөр батлагдсан "Цагдан сэргийлэхийн тухай дүрэм"-ийн 23-р зүйлд: Цагдан сэргийлэхийн гүйцэтгэх жагсаалын ба захирах тушаах хийгээд аж ахуйн ажилчид нь албан ажлыг цагийг албан тушаалын ялгаврын тэмдэг бүхий тогтмол жагсаалын хувцсыг өмсөхөөс гадна өөр өөрийн тушаал дор ноогдуулсан буу зэвсгийг зүүж явбаас зохино гэсэн нь тухайн үед алба хаагчид зэвсгийг албан үүргээ гүйцэтгэх үедээ ашиглаж байсан байна. 1955 оны 03-р сарын 29-ны өдөр батлагдсан БНМАУ-ын Дотоод явдлын яамны харьяа "Улсын цагдан сэргийлэхийн дүрэм"-ийн 16-р зүйлд: Улсын цагдан сэргийлэхийг зэвсэг, хувцас, эд хэрэглэгдэхүүн, шинжлэх ухаан техникийн хэрэгсэл зэрэг бусад эд хогшлоор хогшилоор хангах явдлыг Дотоод явдлын яамнаас төвлөрсөн журмаар гүйцэтгэнэ. Морь ба албаны нохойн тоо, тээврийн хэрэгсэл мөн

⁷⁰ Мөн тэнд 36 дугаар тал

⁷¹ Мөн тэнд 45 дугаар тал

зэвсэг техникийн болон бусад эд хогшлын жагсаалтыг Дотоод явдлын яамны сайдаас тогтооно.⁷² гэж тусгасан байна.

1963 оны 10-р сарын 25-нд батлагдсан БНМАУ-ын "Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм"-ийн 15-р зүйлд: Цагдаагийн алба хаагчийн зэвсэг хэрэглэх үндэслэл журмыг тодорхой заасан байна.⁷³ Үүнд:

Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан нарын албан үүргээ гүйцэтгэж байгаа үед нь бусдаас бүлэглэх буюу буу зэвсэг, бусад хэрэгслийг ашиглан, илтээр халдан довтолж, амь насанд аюул учруулахад хүрвэл нэг этгээдийн гэмт үйлдэл нөгөө этгээдийн амь насанд нь аюул учруулж байгаа бол

Баривчлагдсан /насанд хүрсэн/ этгээд харуул хамгаалалтаас оргож зугтаавал тус тус хэрэглэж болно.

Тайлбар: Дээр дурдсан бүх тохиолдолд зэвсэг хэрэглэх нь гэмт үйлдлийг гаргахгүй байлгах талаар бусад бүх бололцоот арга хэмжээг урьдчилан авсны дараа сая хэрэглэж болно. Халдан довтолох аюул нэгэнт өнгөрсөн буюу хэлмэгдэгч этгээдийн амь насанд бодит аюул болж чадахгүй болсны дараа, эсвэл халдан довтолсны хорт уршиг /үхэл/ тохиолдсоны дараа зэвсэг хэрэглэж болохгүй.

"Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм"-ийн 16-р зүйлд: Гэмт хэрэг үйлдсэн буюу нийтийн хэв журам зөрчсөн этгээд засгийн төлөөлөгч болон нийтийн хэв журам сахиулагч хүмүүсийн шаардлагыг биелүүлэхгүй харин онцгой догшин авирлаж, танхай балмад зан гарган аашилбал хуулийг үндэслэн номхотгох цамц, гав, бусад номхотгох аргыг хэрэглэж болно.

Улсын цагдан сэргийлэн байгууллага нь мөнгөн хөрөнгө, орон сууц, хувцас хунар, буу зэвсэг, галт хэрэгсэл, холбооны ба тээврийн хэрэгсэлээр Нийгмийн аюулаас хамгаалах яамнаас төвлөрсөн журмаар хангагдана гэж заагдсан байна.

1985 оны 03-р сарын 29-нд батлагдсан БНМАУ-ын "Цагдан сэргийлэх байгууллагын үндсэн үүрэг, эрхийн тухай" БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн зарлиг гарч түүнд цагдан сэргийлэх байгууллага, алба хаагч зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх талаар томоохон заалт орсон байна. Тодруулбал: БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1985 оны 96 дугаар зарлигийн 8-р зүйлд: Зөвхөн албадан саатуулж, цагдан хоригдож байгаа буюу захиргааны журмаар баривчлагдсан этгээд хэрцгий догшин авирлах, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнийг барих, хуяглан хүргэх, гэмт хэрэгтэн оргохыг завдах зэрэг онцгой тохиолдолд гав, номхотгох бусад хэрэгсэл хэрэглэх эрх эдэлнэ гэж заажээ.⁷⁴

Энэ нь зэвсэг тусгай хэрэгслийг онц чухал үед хэрэглэх тухай нарийн дэг журам, эрх зүйн зохицуулалттай байсныг гэрчилж байна. Номхотгох хэрэгслийн жагсаалт, тэдгээрийн хэрэглэх нөхцлийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс тодорхойлсон журмын дагуу тогтооно.

Мөн 1985 оны 96 дугаар зарлигийн 10-р зүйлд: Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан нь улс, нийгмийн хууль ёсны ашиг сонирхол, нийгмийн хэв журам, социалист өмч, иргэдийн амь бие, эрхийг гэмт халдлагаас хамгаалах албан үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай дор дурдсан онцгой тохиолдолд эцсийн арга хэмжээ болгож зэвсэг хэрэглэх эрхийг тодорхой тусгасан байна.⁷⁵ Үүнд:

Иргэдийн амь бие буюу эрүүл мэндэд шууд заналхийлсэн довтолгооноос түүнийг өөр арга хэрэгслээр хамгаалах боломжгүй бол

Онц чухал, бусад чухал объектод халдсан зэвсэгт довтолгоог таслан зогсоох

Цагдан сэргийлэх байгууллагын ажилтны амь биед шууд аюул учруулсан, түүнчлэн цагдан сэргийлэх байгууллагын хуяглан хамгаалалтад халдсан довтолгоог өөр аргаар таслан зогсоох боломжгүй бол

Зэвсэг хэрэглэн эсэргүүцэж байгаа буюу онц аюултай гэмт хэрэг үйлдсэн, мөн урьдчилсан мөрдөн байцаалт, шүүх, хорих газраас оргосон /эмэгтэй болон насанд хүрээгүй хүнээс бусад/ гэмт хэрэгтнийг өөр арга хэрэгслээр барих боломжгүй бол

Зэвсэг хэрэглэсэн тухай бүр протокол үйлдэж прокурорт нэн даруй мэдэгдэнэ.

Зэвсэг хэрэглэх журмыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс тодорхойлсон журмын дагуу тогтооно.

1985 оны 04-р сарын 26-нд батлагдсан БНМАУ-ын "Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм"-ийн 19-р зүйлд: Албадан саатуулагдаж, цагдан хоригдож байгаа буюу захиргааны журмаар

⁷² Мөн тэнд 82 дугаар тал

⁷³ Д.Таванжин. Монголын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан эрх зүйг зохицуулалт түүний хөгжилт: УБ:2000 он 92 дугаар тал

⁷⁴ Мөн тэнд 105 дугаар тал

⁷⁵ Мөн тэнд 105 дугаар тал

баривчлагдсан этгээд хэрцгий догшин авирлах, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнийг барих, хуяглан хүргэх, гэмт хэрэгтэн оргохыг завдах зэрэг онцгой тохиолдолд номхотгох тусгай хэрэгсэл хэрэглэнэ. Номхотгох тусгай хэрэгслийн жагсаалт, тэдгээрийг хэрэглэх журмыг Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайд, Улсын прокурорын зөвшөөрснөөр батална гэж заажээ.⁷⁶

Мөн БНМАУ-ын "Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм"-ийн 20-р зүйлд: Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан нь улс, нийгмийн хууль ёсны ашиг сонирхол, нийгмийн хэв журам, социалист өмч, иргэдийн амь бие, эрхийг гэмт этгээдийн халдлагаас хамгаалах албан үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай дор дурдсан онцгой тохиолдолд эцсийн арга хэмжээ болгож зэвсэг хэрэглэх эрхийг хуульчлан заасан байна.⁷⁷ Үүнд:

Иргэдийн амь бие буюу эрүүл мэндэд шууд заналхийлсэн довтолгооноос түүнийг өөр арга хэрэгслээр хамгаалах боломжгүй бол

Сайд нарын Зөвлөлөөс баталсан жагсаалтад заасан онц чухал, бусад чухал объектод халдсан зэвсэгт довтолгоог таслан зогсоох

Цагдан сэргийлэх байгууллагын ажилтны амь биед шууд аюул учруулсан, түүнчлэн цагдан сэргийлэх байгууллагын хуяглан хамгаалалтад халдсан довтолгоог өөр аргаар таслан зогсоох боломжгүй бол

Зэвсэг хэрэглэн эсэргүүцэж байгаа буюу онц аюултай гэмт хэрэг үйлдсэн, мөн урьдчилсан мөрдөн байцаалт, шүүх, хорих газраас оргосон /эмэгтэй болон насанд хүрээгүй хүнээс бусад/ гэмт хэрэгтнийг өөр арга хэрэгслээр барих боломжгүй бол

Зэвсэг хэрэглэх журмыг Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайд, Улсын прокурорын зөвшөөрснөөр тодорхойлон баталаж байжээ.

1990 оны 10 дугаар сарын 05-ны өдөр батлагдан гарсан БНМАУ-ын "Цагдан сэргийлэх, Засан хүмүүжүүлэх, хөдөлмөрийн байгууллагын ажилтны үүргээ биелүүлэх баталгааны тухай хууль"-ийн 3 дугаар зүйлд: Цагдан сэргийлэх засан хүмүүжүүлэх, хөдөлмөрийн байгууллагын ажилтан гэмт хэргийг зогсоох, иргэдийн болон өөрийн амь нас эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахын тулд бороохой, гав, хүлэг, усан хөөрөг, нулимс асгаруулагч зэрэг тусгай хэрэгсэл түүнчлэн зэвсэггүйгээр бие хамгаалах мэх хэрэглэх эрхтэй гэж заасан байна.⁷⁸

Цагдан сэргийлэх засан хүмүүжүүлэх, хөдөлмөрийн байгууллагын ажилтан үүргээ гүйцэтгэхдээ хэрэглэх тусгай хэрэгслийн жагсаалт, зааврыг БНМАУ-ын Ерөнхий прокурорын зөвшөөрснөөр УЦСЕГ-ын дарга баталж мөрдүүлнэ. Мөн Цагдан сэргийлэх засан хүмүүжүүлэх, хөдөлмөрийн байгууллага тэдгээрийн ажилтнаас бусдад тусгай хэрэгсэл мэхийг үндэслэлгүй буюу буруу хэрэглэсэн тухай гомдол мэдүүлгийг прокурор, цагдан сэргийлэх байгууллагад гаргана гэсэн нь цагдаагийн алба хаагчийн эдлэх эрхийг нь тодорхой зааж өгснөөс гадна үүрэг, хүлээх хариуцлагын арга хэмжээг тусгасан хууль дүрмийн заалт, хэм хэмжээнүүд байсан байна.

Дээрхи хууль тогтоомжуудад цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэж ирсэн талаар үечлэн тусгасан нь цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтын хөгжлийн баталгаа болж байна.

1992 онд Монгол улсын шинэ "Үндсэн хууль" батлагдаж түүнд нийцүүлэн "Монгол улсын цагдаагийн байгууллагын тухай хууль"⁷⁹ шинээр батлагдан гарсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болоод зогсохгүй эрх зүйн шинэчлэлтийн жишээ болсон юм.

Энэ хууль нь орчин үеийн цагдаагийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим, зорилго, зорилт, үндсэн үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн арга хэлбэрийг тодорхойлсон анхны төрөлжсөн хууль болсон бөгөөд цагдаагийн байгууллагын зэвсэг, тусгай хэрэгсэлийн талаар урьд өмнөх хууль тогтоомжуудад байгаагүй тусгай бүлэг, зүйлүүд тусгагдсан нь цагдаагийн байгууллага, алба хаагчаас зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх талаар шинэлэг эрх зүйн акт болсон юм.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 5-р бүлэгт цагдаагийн байгууллага, алба хаагчийн зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх, тусгай хэрэгслийн төрөл, хэрэглэх үндэслэл журам, ашиглах аргачлал, анхаарах болон хориглох тохиолдлуудыг дор дурдсан байдлаар тусгайлан зохицуулсан байна.Тодруулбал:

39 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын зэвсэг

⁷⁶ Мөн тэнд 119 дүгээр тал

⁷⁷ Мөн тэнд 121 дүгээр тал

⁷⁸Мөн тэнд 119 дугаар тал

⁷⁹ Цагдаагийн байгууллагын тухай хууль 1993 оны 12-р сарын 02-нд батлагдсан 8 бүлэг, 53 зүйлтэй хууль юм. Энэ хууль 1994 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

1. Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх алба хаагчиддаа галт зэвсэг олгох, алба хаагчид нь уул зэвсгийг биедээ авч явах эрхтэй.

2. Цагдаагийн байгууллага нь цэрэг, цагдаагийн албанд зориулж үйлдвэрлэсэн нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар уснаа явагч зэрэг тээврийн хэрэгсэл ашиглах эрхтэй.

40 дүгээр зүйл. Галт зэвсэг хэрэглэх

Гэмт үйлдлийг өөр арга, хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол цагдаагийн алба хаагч дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

1/ цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;

2/ цагдаагийн болон дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объект руу нууцаар нэвтрэн орсон, эсхүл зэвсэг хэрэглэн буюу бүлэглэн довтолсон;

3/ хүнийг барьцаанд авсан;

4/ ялтан, цагдан хоригдогч оргосон, хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээд зугатсан;

5/ галт зэвсэг, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн этгээд зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;

6/ хуяглан хүргэж яваа этгээдийг суллахаар зэвсэг хэрэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;

7/ хорих, цагдан хорих, баривчлах байранд нийтийн эмх замбараагүй байдал гарч, хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах бодитой нөхцөл байдал бий болсон.

Цагдаагийн алба хаагч бололцоотой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн

өмнө урьдчилан сануулна.

3. Галт зэвсэг хэрэглэснээс хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол зэвсэг хэрэглэсэн цагдаагийн алба хаагч эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч захирах даргадаа, дарга нь прокурорт нэн даруй мэдэгдэнэ.

41 дүгээр зүйл. Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх

Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ дараахь тусгай хэрэгсэл, мэх ашиглана.

1/ олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл;

2/ нэг бүрийн тусгай хэрэгсэл

3/ тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл

4/ хамгаалах тусгай хэрэгсэл

5/ самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх

6/ албаны нохой.

Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1,2,3-т заасан тусгай хэрэгслийг цагдаагийн төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэх, дуурайлган хийх, гадаадаас оруулж ирэхийг хориглоно.

42 дугаар зүйл. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл

1. Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл гэнэ.

2. Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна:

1/ олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч;

2/ усан хөөрөг;

3/ утаан хөшиг үүсгэгч

3. Цагдаагийн алба хаагч олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараахь зорилгоор хэрэглэж болно:

1/ нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох

2/ нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох;

3/ байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;

4/ хориглон эсэргүүцэж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах;

5/ энэ хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 1,3-т заасан тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна.

43 дугаар зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгсэл

1. Нэг хүнд нөлөөлөх хэрэгслийг нэг бүрийн тусгай хэрэгсэл гэнэ.

2. Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна:

1/ гар, хөл, хурууны гав

- 2/ хүлэг, ороох цамц;
- 3/ резинэн бороохой;
- 4/ цахилгаан бороохой;
- 5/ нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;
- 6/ резинэн ба хуванцар сумтай буу.

3. Цагдаагийн алба хаагч дараахь тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэж болно:

- 1/ цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, эсхүл эсэргүүцсэн;
- 2/ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх;
- 3/ цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд аюултайгаар эсэргүүцэж болох сэжигтэн, яллагдагч, ялтанг баривчлах;
- 4/ энэ хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан тохиолдолд;

44 дүгээр зүйл. Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл

1. Тээврийн хэрэгслийг зогсоох зорилгоор ашиглах зориулалттай төхөөрөмжийг тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл гэнэ.

2. Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгслийг дараахь тохиолдолд хэрэглэж болно:

- 1/ хүний амь нас, эрүүл мэндэд учирч болох бодит аюулыг таслан зогсоох шаардлага тулгарсан;
- 2/ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан өөрөө жолоодон зугатсан, эсхүл тийм этгээдийг тээвэрлэн зугатсан;
- 3/ тээврийн хэрэгслийг зогсоох талаар цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэн зугатсан.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1,2-т заасан тохиолдолд тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх боломжгүй бол галт зэвсэгт хэрэглэн, эсхүл ачааны автомашин болон бусад зүйлээр хаалт тавьж тээврийн хэрэгслийг албадан зогсоож болно.

45 дугаар зүйл. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар, хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг батлах

1. Галт зэвсэг, бүх төрлийн тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг улсын ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батлана.

2. Хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.

46 дугаар зүйл. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглох

Хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүмүүст дор дурдсанаас бусад тохиолдолд галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно:

- 1/ энэ хуулийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан тохиолдолд;
- 2/ галт зэвсэг хэрэглэж довтолсон, буюу эсэргүүцсэн;
- 3/ нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон буюу бүлэглэн довтолсон үед оролцсон хүмүүсийг дотор нь ялгах боломжгүй онцгой тохиолдолд гэж тус тусд нь ялгамжтай байдлаар заасан юм.

Мөн энэ хуулийн 5-р бүлгийн 45-р зүйлийн 1-р хэсэгт заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын дарга Ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан 1994.03.31-ний өдрийн 75-р тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан "Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар"-ыг цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажиллагаандаа ашиглан ирсэн ба улмаар цагдаагийн албанд мөрдөгдөх журам /стандарт/-ыг боловсронгуй болгох ажлын хүрээнд уг заавар нь хүчингүй болж 2010.04.02-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын дарга Монгол улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан 173-р тоот тушаалын 1-р хавсралтанд заагдсан галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавруудыг өнөөдрийг хүртэл цагдаагийн байгууллага, алба хаагч үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Уг тушаалд дараах байдлаар кодлож оруулсан байна. Үүнд:

Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар /код- 233/

Галт зэвсэг хэрэглэх заавар /код- 234/

Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх заавар /код- 235/

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх заавар /код- 236/

Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх заавар /код- 237/

Зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх заавар /код- 238/

Албаны нохой хэрэглэх заавар /код -239/

Цагдаагийн алба хаагчаас хуулинд заасан үндэслэл бүхий нөхцөл бий болсон тохиолдолд галт зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх бөгөөд энэ эрхээ хэрэгжүүлэхдээ тухайн алба хаагчаас тусгай хэрэгслийг зөв хуулийн хүрээнд хэрэглэх, эрхээ хэтрүүлэхгүй байлгах зорилгоор дээр дурдагдсан зааврууд батлагдан гарсан юм. Учир нь хуулинд заасан галт зэвсэг, тусгай хэрэгслийг хэрхэн яаж хэрэглэх аргачлал, юун дээр анхаарах ёстойг нь заавраар зохицуулж өгсөн байдаг.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллага нь түүхэн хөгжлийнхөө явцад өөрийн хүнд бэрх зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд зэвсэг тусгай хэрэгслийг хэрэглэн ирсэн бөгөөд тухайн цаг үеийнхээ нийгмийн нөхцөл байдалтай уялдан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актууд шинэчлэгдэн улам боловсронгуй болж ирсэн байна.

Үүнийгээ дагаад цагдаагийн байгууллага, алба хаагчаас зэвсэг, тусгай хэрэгслийг хэрэглэх эрх зүйн зохицуулалт, үндэслэл журам өөрчлөгдөн шинэчлэгдэж олон улсын жишигт нийцсэн зэвсэг, тусгай хэрэгслийг цагдаагийн байгууллага албандаа ашиглаж байна. Зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх нь гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй шууд холбоотой өөр арга хэрэгслээр түүнийг зогсоох боломжгүй үед хийгддэг, хүний эрх, эрх чөлөөг ихээр хөнддөг онцгой арга хэмжээ юм.

Иймд цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ хуулинд заасан галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл бүхий нөхцөл нэгэнт бий болсон тохиолдолд түүнд тохирсон хүчийг хэрэглэх нь эрхээ хэтрүүлэхгүй байх баталгаа нь болж байна.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Алтанцэцэгийн Гансүх

Улсын мөрдөн байцаах газрын Үнэлгээ, хяналт шалгалтын хэлтсийн
чиглэлийн ахлах мөрдөн байцаагч, докторант, цагдаагийн ахмад

Нийлэлийн товчлол:

Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр болох зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал сэдвээр илтгэлийг хэлэлцүүлж байгаа нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангид гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрийг “Урьдчилан үгсэн тохирсон бүлэг”, “Зохион байгуулалттай бүлэг”, “Гэмт бүлэглэл” гэж тодорхойлон хуульчилсан боловч одоог хүртэл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлээс үйлдсэн гэмт хэргийг нотолж, шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа явдалд үнэлэлт өгч, судлаач нараас зохион байгуулалттай гэмт явдлын бүтэц, онцлог шинжийг тодорхойлсон асуудлыг судалж, дүгнэлт хийх замаар зохион байгуулалттай гэмт явдлын, онцлог шинж, мөн чанар, бүтцийг тодорхойлж, цаашид эрүүгийн хуулийн ерөнхий ангид хуульчлагдсан гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрийг шинээр томъёолохыг зорьсон юм.

Дэлхийн улс орны хөгжлийн чиг хандлагыг даган эрүүгийн ертөнцөд зохион байгуулалттай гэмт хэрэг тодорхой байр суурь эзлэн, нарийн зохион байгуулалттай, төвлөрсөн удирдлага, байнгын тогтвортой ажиллагаа, ул мөрөө баллах нь үйл ажиллагаа нь улам боловсронгуй болж, техник, технологийн хөгжил, дэвшлийг ашиглан үйлдэж байгаа нь нийгмийн нэгэн төрлийн үзэгдэл гэлтэй.

Өнөөдөр манай нийгэм, эдийн засгийн хөгжил, улс орны гадаад, дотоод бодлого түүнчлэн техник, технологийн дэвшилтэй зэрэгцэн зохион байгуулалттай гэмт явдал өөрийн гэсэн хөгжлийн үе шаттайгаар боловсронгуй болсоор байна. Гэмт хэрэг нь зарим тохиолдолд зөвхөн тодорхой нэг хил хязгаарт үйлдэгдэх бус харин соёл урлаг, бизнес, улс төр, нийгмийг бүхэлд нь хамарч олон улсын хэмжээнд нэг улсын хил хязгаарт үл захирагдан үйлдэгдэх болсон бөгөөд энэ нь маш нарийн зохион байгуулалтанд орсныг илтгэж байна.

Зохион байгуулалттай гэмт хэрэг нь төр, нийгмийн байгуулалд хамгийн их аюул учруулдаг, бусниулан сүйтгэх шинжтэй бөгөөд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, ёс суртахуун, нийгмийн сэтгэл зүй, соёл урлагт хүртэл аюул занал, хор уршиг учруулдаг, нийгмийн янз бүрийн үе давхаргыг хамруулдгаар онцлог юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулинд түүхэнд анх удаа 1993 онд “Гэмт хэрэг үйлдсэн зохион байгуулалттай бүлэг” гэсэн ойлголтыг ерөнхий ангид хуульчилсан нь зохион байгуулалттай гэмт явдлын талаар тодорхойлсон чухал алхам болсон. Гэвч энэхүү тодорхойлолтыг чухам яаж ойлгох, практик амьдралд хэрхэн тайлбарлан нэг мөр ойлгон хэрэгжүүлэх талаар тодорхой шийдэл, зөвшилцөлд хүрээгүй юм.⁸⁰ Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд эрүүгийн эрх зүй дэх зохион байгуулалттай гэмт хэргийн тухай ойлголт, эрүүгийн эрх зүйн болон сэтгэл зүйн үндсэн шинж, хууль цаазын учир холбогдлыг зөв танин мэдэх нь онол, практикийн чухал ач холбогдолтой.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангид “Урьдчилан үгсэн тохирсон бүлэг”, “Зохион байгуулалттай бүлэг”, “Гэмт бүлэглэл” гэж

⁸⁰ Адъяабазар.Д. Мафи. Гэмт байгууллага УБ., 1999. 7 дахь тал

хуульчилсан нь өнөөгийн эрүүгийн ертөнц дэх зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэхэд чухал алхам болсон бөгөөд эрүүгийн эрх зүйн хөгжлийн түүхэнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн хүрээнд анх удаа “Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулах түүнд оролцох” гэмт хэргийг үндсэн, хүнд, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хуульчлан өгсөн нь цаг үеэ олсон эрх зүйн хэм хэмжээ болсон.

Хууль зүйн яамнаас Улсын Их Хурлын чуулганд өргөн бариад байгаа Монгол Улсын Гэмт хэргийн тухай хуулийн төслийн гуравдугаар бүлэгт “Гэмт хэрэг хамтран үйлдэх” хэлбрийн талаар хуульчлахдаа 3.1 дүгээр зүйлд “Гэмт хэрэг хамтран үйлдэх” гээд /Гэмт хэргийн гүйцэтгэгч, гэмт хэргийн хатгагч, гэмт хэргийн хамжигч, гэмт хэргийг зөрж гүйцэтгэх/, 3.6 дугаар зүйлд “Гэмт хэргийг бүлэглэн гүйцэтгэх” гээд /Санаатай гэмт хэргийг хоёр, эсхүл түүнээс дээш хүн хамтран биечлэн үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэх/, 3.7 дугаар зүйлд “Зохион байгуулалттай гэмт бүлэг” гээд /Гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн, тогтвортой хүмүүсийн холбоог зохион байгуулалттай гэмт бүлэг/ гэж томъёолсон байна.

Хэдийгээр нийгмийн хөгжлийн чиг хандлагад тохирсон зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэхэд чиглэсэн хэм хэмжээ 2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуульд хуульчлагдсан, одоо өргөн бариад байгаа Монгол Улсын Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд томъёологдож байгаа хэдий ч энэ нь зөвхөн тодорхойлолт төдий байгаа нь нууц биш юм. Оросын хуульч эрдэмтэн А.И.Долгова бүтээлдээ “Зохион байгуулалттай гэмт хэрэг гэдэг нь: Гэмт бүлэг ба зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд өөрсдийн нэгдэл нягтралд тулгуурлан гэмт аргаар олсон орлогоо нэмэгдүүлэх ба засаг төрийн байгууллагад нөлөөлөх нөлөөлөө бэхжүүлэх зорилгоор хууль бус ажиллагаа явуулахыг хэлнэ”⁸¹ гэж тодорхойлсон бөгөөд тэрээр “Организованная преступность” /1989/ номондоо “Зохион байгуулалттай гэмт явдал нь хоёр үндсэн утгаар хэрэглэгддэг ойлголт юм. Зөвхөн зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн олонлог байдлыг тодорхойлсон ойлголт.

Нэгдмэл криминологийн үзэгдэл нь өөртөө нилээд хэдэн төрлийн хууль бус үйл ажиллагааг багтаадаг бөгөөд ихэвчлэн хууль бус үйл ажиллагаа явуулдаг хүмүүсийн нэгдмэл систем юм”⁸² гэсэн ойлголт өгчээ.

Оросын Холбооны Улсын Эдийн засаг нийгмийн зөвлөлийн зөвлөлийн (1994 он) явуулсан бүх дэлхийн дотоод хэргийн Аюулгүй байдлын яамдын үндэстэн дамнасан гэмт хэргийн тухай бага хурал дээр танилцуулах материалууд дээр “Зохион байгуулалттай гэмт хэрэг” гэдэг нэр томъёог ашиглах тусгай нөхцлүүдийг зааж өгсөн.

Гэмт хэргийн байгууллагын гишүүдийг их бага хэмжээний байнгын үндсэн хууль эрхийн эсрэг үйл ажиллагаанд оролцох зорилгоор нэгдсэн этгээдүүд гэж үзнэ. Дүрэм ёсоор тэд хуулиар хориглосон бараа үйлчилгээг эсвэл хууль бус сувгаар орсон хууль ёсны бараа жишээ нь, хууран мэхлэх эсвэл залилангийн үр дүнд гарсан бараа нийлүүлэх, хэрэгжүүлэх гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааг явуулдаг. Зохион байгуулалттай гэмт хэрэг хуулиар ихэвчлэн хориглосон байдаг хууль ёсны зах зээлийн үйл ажиллагааны тухайн салбар хүрээнд үргэлжлэл болон бараг байнга оршиж байдаг.

Түүний тусгай хүчирхэг талууд хууль ёсны зах зээлд үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрийн удирдлагын үндсэн санаагаар нөхцөлдөж бий болсон байдаг. Зах зээлийн сул орон зайг хамгаалах ба эзлэн авах өргөжүүлэх шаардлага.

Хууль бус бараа үйлчилгээг нийлүүлэх зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа нь хамтын ажиллагаа ба зохион байгуулалтыг нэлээд их хэмжээгээр шаарддаг. Бусад дурын худалдааны үйл ажиллагаатай ижилхэн гэмт бизнес тодорхой салбар хүрээний үйлдвэрийн дадлага, мэргэжил мэргэшил ба өөрийн үйл ажиллагааг зохицуулах чадвар, хүчирхийлэл ба авлигын арга ашиглахаас гадна тухайн хэргийг явуулахад хамтрахыг албадах чадварыг шаарддаг.

Тэдгээрийн тоонд хууль эрхийг хамгаалах эрх бүхий байгууллагын хариуцлагатай этгээдийн авах хээл хахуулийн төлбөрөөс эхлээд, өөрийн хүмүүсийг улс төрийн бүтцэд оруулах буюу нэвтрүүлэх хүртэл хамгийн олон янзын арга хэрэгслүүд ордог. Зохион байгуулалттай гэмт хэргийн нэг жишээ нь олон улсын терроризм буюу алан хядлага.

Мөн Оросын холбооны улсын хуульч А.Н.Гуров зохион байгуулалттай гэмт явдлыг “Нийгмийн хэмжээний гэмт үзэгдлийн гэмт үйл ажиллагааг ажил /бизнес/ болгон эрхэлдэг, авилга ба бусад хамгаалах хэрэгслийн тусламжтайгаар нийгмийн хяналтаас хамгаалах системийг бий болгож, харьцангуй өргөн олныг хамарсан ажиллагаа явуулдаг тогтвортой удирдлагатай бүлэглэл гэж ойлгож болно”⁸³ гэж тодорхойлжээ.

⁸¹ Долгова.А.И. Криминология. М., 1999. 597 стр

⁸² Долгова.А.И. Организованная преступность. К., 1989. 85 стр

⁸³ Гуров. А.И. Красная мафия. М., 1992. 47 стр

Зохион байгуулалттай гэмт явдал нь ердийн уламжлалт гэмт явдалтай харьцуулахад өөрийн гэсэн тодорхой онцлогтой байдаг.

Нэг. Зохион байгуулалттай гэмт явдал нь гэмт үйлдлийн идэвхтэй шинж, гэмт хэрэг үйлдэх идэвхитэй шинжээрээ ердийн гэмт үйлдлээс ялгагддаг. Гэмт явдал нь тавьж буй зорилго, баримтлах чиг хандлага өөрийн гэсэн "философи"-оороо амьдралын хэвшил болдог.

Хоёр. Гэмт хэрэг байнга үйлдэх явдлыг баталгаатай болгох нөхцлийг бүрдүүлэхийн тулд гэмт этгээдүүдийн болон тэдгээртэй хамтран гэмт хэрэг үйлдэгсэд нь гэмт нийгэмлэгт нэгддэг. Ийм нийгэмлэг нь байгууллагын хэмжээнд зохион байгуулагдсан байдаг. Ийнхүү нэгдэхдээ нэлээд хатуу тогтсон бүтцийг эрхэмлэдэг бөгөөд гүйцэтгэх үүрэг, харилцан ажиллахаа хуваарилаад зогсохгүй ямар нэгэн хэм, хэмжээний нарийн бүтэц, дамжуулан захирах ёс дэглэмтэй байдаг ба бүлгийн гишүүн хэн ч бай өөрийн бусад гишүүдтэй харьцах, ажиллах журмаа мэддэг бөгөөд биеэ авч явах дэг, жаяг, хатуу тогтсон сахилга бат үйлчлэх ба эцсийн зорилго нь байгууллагаа дэмжих явдалд оршдог.

Зохион байгуулалттай гэмт бүлэг нь төрийн үйл ажиллагааны эсрэг төр, нийгмийг дээрэмдэх замаар хамгийн дээд ашиг олох сонирхолтой өөрийн гэсэн дотоод удирдлагатай системтэй байдаг. Орчин үеийн техник, хэрэгслээр зэвсэглэн, өөрийн гэмт хэргийн бүлгийн аюулгүй байдлыг хангаж, дайны хэлбэрээр зохион байгуулагдаж, тусгай мэргэжлийн хүчний бүтэц бий болгосон байдаг.

Гэмт хэргийн босож тогтсон хэлбэр нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухааны үйл ажиллагааны янз бүрийн хүрээний мэргэжилтнүүд, хууль эрх болон бусад асуудлаар зөвлөгөө өгдөг хүмүүсийг өөртөө нэгтгэсэн байдгаараа онцлог. Орчин үед төрийн эрх бүхий байгууллагуудад, зохион байгуулалттай бүлэглэлийн хууль эрхийг хамгаалах төлөөлөл бүхий этгээдүүд бий болсон бөгөөд үүгээрээ уламжлан өөрийн бүтцийг нэлээд бат бөх, нөлөө бүхий байр суурьтай, өөрийн ашиг сонирхлыг лоббидох хүчтэй аппаратыг бий болгосон байдгаараа онцлог.

Зохион байгуулалттайгаар гэмт хэрэг үйлдэх гэдгийг "Гэмт хэрэг үйлдэх явдлыг орлогын эх үүсвэр болгох зорилгоор урьдчилсан нэгдсэн, удирдагч, гүйцэтгэгчээ томилох, үүрэг ролио хуваарилах зэргээр зохион байгуулалтын бүтэц бий болгосон хоёр ба түүнээс дээш хүмүүсийн нэгдлийг хэлнэ"⁸⁴... гэж 1986 оны Эрүүгийн хуулийг тайлбарласан Улсын дээд шүүхийн тайлбарт байдаг.

Зохион байгуулалттай бүлгийн нэг гол шинж болох *урьдчилан нэгдсэн гэдэг* нь гишүүд нь бүтэц тогтолцооны байдлаар харилцан уялдсан, гүйцэтгэх чиг үүргээ хуваарилсан, удирдагч, гүйцэтгэгчийн хооронд холбоо тогтоосон, материаллаг сонирхлоор хоорондоо холбогдсон байхыг ойлгоно.⁸⁵

Монгол улсын Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны түүхэнд зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл гэсэн шинэ нэр томьёо бий болсонтой уялдан хуульчид, эрдэмтэд өөрсдийн үзэл бодлоор тайлбарласан. Монгол улсын гавьяат хуульч Ж.Авхиа "Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар" бүтээлдээ зохион байгуулалттай бүлгийг тодорхойлохдоо урьдчилан нэгдэн тогтсон, тогтвортой ажиллагаатай байх гээд *"тогтвортой ажиллагаа"* гэдгийг гишүүд нь тодорхой гэмт хэрэг үйлдсэн эсэхээс үл хамааран харилцаа холбоотой, харилцан үйл ажиллагаа нь байнгын шинж чанартай байх явдал бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдэж, үр дүнд нь орлого олох, бүлгийн болон оролцогч нэг бүрийн эрх ашиг сонирхлыг хангахад чиглэснийг ойлгоно гэж тодорхойлсон байна.

Зохион байгуулалттай бүлэг нь ямар нэгэн гэмт хэргийг хаана, хэрхэн үйлдэх талаар болон бүлгийн гишүүдийн гүйцэтгэх үүрэг, гэмт хэрэг үйлдэхдээ үлдээж болох ул мөрөө яаж арилгах, гэмт хэрэг үйлдэхэд зарцуулах мөнгө, санхүүгийн зэрэг асуудлыг илүү өндөр түвшинд зохицуулан тохирсон, хуваарилсан байна гэжээ. Түүнчлэн гэмт хэргийн ертөнцөд томоохон байр суурийг гэмт бүлэглэл эзлэх бөгөөд гэмт бүлэглэлийг "Мафи" гэсэн томьёололтой утга дүйн хэрэглэнэ гэжээ.⁸⁶

Шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан зохион байгуулалттай бүлгийн *"тогтвортой"* гэдгийг тус бүлэгт орсон этгээдүүд тодорхой гэмт хэрэг үйлдсэн эсэхээс үл хамааран харилцаа холбоо, харилцан ажиллагаа нь байнгын шинж чанартай байх явдал бөгөөд энэ нь гэмт хэрэг үйлдэж орлого олох, бүлгийн болон оролцогч нэг бүрийн эрх ашиг, зорилгыг хангахад чиглэсэн шинжтэй байна⁸⁷ гэж үзсэн бол

⁸⁴ Улсын дээд шүүхийн бигд хурлын тогтоол №35. УБ., 1994.

⁸⁵ Жанцан.С. Монгол улсын эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/. УБ., 2008. 30 дахь тал

⁸⁶ Авхиа.Ж, Ганболд.Б. Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002. 122 дахь тал

⁸⁷ Жанцан.С, Халиунсүрэн.Ж. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хлээлгэх эрүүгийн хариуцлага, криминологийн асуудал. УБ., 2008. 74 дэх тал

Улсын дээд шүүхийн тайлбарт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэгт заасан “**Зохион байгуулалттай бүлэг...**” гэдэг нь гэмт хэрэг үйлдэх явдлыг орлогын эх үүсвэр болгон эрхлэх зорилгоор урьдчилан нэгдэн нийлж удирдагч, гүйцэтгэгчээ томилох, үүргээ хуваарилах, зохион байгуулалтын бүтэц бий болгосон хоёр буюу түүнээс дээш хүмүүсийн нэгдлийг хамааруулан ойлгоно. “**Гэмт бүлэглэл**” гэдэг нь гэмт хэрэг үйлдэх явдлыг орлогын эх үүсвэр болгож, ашиг олох зорилготой, нэгдсэн, материаллаг бааз, мөнгөн сан, банк санхүүгийн бие даасан сүлжээтэй байх:

Зохион байгуулалтын нарийн бүтэц, тогтолцоог бий болгосон, удирдах бүрэлдэхүүн, гишүүнчлэл, хяналт мэдээлэл, тагнан турших албатай, өөрсдийн төлөөний хүмүүсийг хууль хяналтын болон төр, засгийн байгууллагад оруулах буюу тэднээс эгнээндээ элсүүлэх.

Өөрсдийн дунд тогтсон хатуу дэглэм, журам, тангараг, нууц үг, хэллэг, дохиолол холбоо, техник хэрэгсэл, зэр зэвсэгтэй байх гэх мэт бие хамгаалах болон гэмт халдлага хийх бэлтгэлтэй, үйлдлийн арга төлөвлөгөөтэй, гэмт хэрэг үйлдэхэд мэргэшсэн бүлэг этгээдүүдийн нэгдлийг ойлгоно.

Гэмт бүлэглэл нь цар хүрээ, бүтцийн хувьд том, нэг болон хэд, хэдэн улсын хооронд үйл ажиллагаа явуулдгаараа зохион байгуулалттай бүлгээс ялгагдана.⁸⁸ гэж тодорхойлсон нэлээд дэлгэрэнгүй тайлбар болсон.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Н.Жанцан “Гэмт бүлэглэл нь хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэхийн тулд буй болсон, нягтарсан ба зохион байгуулалттай бүлэг мөн..., Гэмт бүлэглэл нь зохион байгуулалттай бүлгээс илүү нягтарсан ба хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэх зорилготой байдаг онцлогоороо ялгагдана”⁸⁹ гэж үзсэн.

Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн талаар Хууль зүйн ухааны доктор, процессор Д.Адъяабазар “Мафи” гэсэн бүтээлдээ маш дэлгэрэнгүй тусгасан байна. Тэрээр зохион байгуулалттай гэмт явдлын бүтцийг:

- Зохион байгуулалттай гэмт хамтлаг буюу бүлэг
- Зохион байгуулалттай гэмт бүлэг буюу бүлэглэл
- Зохион байгуулалттай гэмт нийгэмлэг буюу байгууллага

гэж бүтэц зохион байгуулалт, гэмт хэргийн ертөнцөд болон нийгэмд эзлэх байр суурь, гэмт үйл ажиллагааны цар хүрээ, тогтвортой байдал зэрэг шалгуураар нь гурван төрөлд авч үзсэн байна.⁹⁰

Оросын холбооны улсын хуульч Б.Ярочкин зохион байгуулалттай гэмт явдлын бүтцийг мөн гурван төрөлд хуваан авч үзсэн. Үүнд:

- Зохион байгуулалттай бүлэг
- Зохион байгуулалттай гэмт бүлэглэл
- Зохион байгуулалттай гэмт нийгэмлэг⁹¹ гэж авч үзсэн байна.

Эдгээр тодорхойлолт, ойлголтоос үндэслэн зохион байгуулалттай гэмт явдлын бүтцийг:


- Зохион байгуулалттай бүлэг
- Зохион байгуулалттай гэмт бүлэглэл
- Зохион байгуулалттай гэмт байгууллага гэж авч үзэх боломжтой.

⁸⁸ Монгол улсын дээд шүүхийн тайлбар. Монгол улсын эрүүгийн хуулийн 36 дугаар зүйлийг тайлбарлах тухай. №10. УБ., 2003.05.05

⁸⁹ Жанцан.Н. Криминалоги. УБ., 2000. 246 дахь тал

⁹⁰ Адъяабазар.Д. Мафи. УБ., 1999. 9 дэх тал

⁹¹ Ярочкин.Б. Зохион байгуулалттай гэмт явдал, аюул хаанаас нйрлэж байна бэ. УБ., 2001. 12 дахь тал



Зураг 1. Зохион байгуулалттай гэмт явдлын бүтэц

Зохион байгуулалттай бүлэг гэж хоёр буюу түүнээс дээш тооны этгээд хамтран, эрх, үүргээ нарийн хуваарилан, тодорхой нууцлалыг сахин, гэмт хэргийг байнгын ашиг олох зорилгоор үйлдэхээр, урьдчилан нэгдсэнийг ойлгох бөгөөд доорхи онцлог шинжтэй байна. Үүнд;

- Гэмт үйл ажиллагаа нь харьцангуй удаан үргэлжилсэн, үйл ажиллагаа нь тогтвортой байдаг
- Гэмт хэрэг үйлдэхээр урьдчилан нэгдэж өөрийн гэсэн бүтэц бий болгосон
- Удирдагч /зохион байгуулагч/ болон хэд, хэдэн хамтран оролцогчидтой байна
- Хамтран оролцогчид нь үүргээ /эрх, үүрэг/ нарийн тодорхой хуваарилан тогтоосон байна
- Сайтар бодож боловсруулж зохион байгуулсан, холбоо барих, нууцлал хадгалах, сахих, харилцан бие, биенээ хянах тогтсон журамтай байна
- Бүлгийн дотор өөрийн гэсэн материаллаг хэрэгсэлтэй байдаг. Үүнд: Гэмт хэрэг үйлдэхэд зориулагдсан техник хэрэгсэл гэх мэт
- Гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эд зүйлээрээ бүлгийн гишүүд нь санхүүждэг зэрэг болно.

Зохион байгуулалттай бүлэг нь хоорондоо мөн ялгаатай байж болно. Жишээлбэл: бүлгийн гишүүдийн тооны байдал, өндөр түвшинд бүтээгдсэн техник хэрэгслээр хангагдсан байдал, зохион байгуулалтын онцлог, захирах захирагдах ёс буюу эрх, үүрэг хуваарилалт, бүлгийн гишүүдийн нууцлал хадгалах сахилга бат, бүлгийн зүгээс гишүүдээ сонгон авсан арга барил, бүлгийн гишүүдийн бүтэц /удирдагч ба зохион байгуулагч, гардан гүйцэтгэгчид, тагнуул буюу мэдээлэл ологчид, гэмт хэргийн замаар олсон эд зүйлээ борлуулагчид болон худалдан авагчид гэх мэт/ түүнчлэн төрийн албан хаагчид болон хууль хамгаалах байгууллагын албан тушаалтнуудтай холбоотой байх байдал зэргээрээ ялгаатай байна.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл нь гэмт хэргийг өндөр түвшинд дагнан үйлдэж ашиг олох зорилгоор нэгдсэн, тодорхой нутаг дэвсгэрийг өөрийн хараа хяналтандаа авсан, зохион байгуулах хэсэг бүхий аппараттай, өөрийгөө хамгаалах болон гэмт үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн зохион байгуулалттай бүлгүүдийн нийлбэр цогц бөгөөд доорхи онцлог шинжтэй.

- Гэмт хэргийн ертөнцөд нэрд гарсан удирдагчтай байх.
- Тодорхой нутаг дэвсгэрт хяналт тогтоон гэмт үйл ажиллагаа явуулдаг, түүнийгээ бусдын гэмт халдлагаас хамгаалдаг.
- Харилцан дэмжлэг үзүүлэх зорилго чиг үүрэгтэй, захирах захирагдах ёсны шаталсан хэлбэртэй.
- Төрийн байгууллагуудад ажилладаг нэр хүнд бүхий албан тушаалтнуудыг өөртөө элсүүлсэн, авилгын холбоо сүлбээтэй.
- Техник, технологийн өндөр түвшинд бүтээгдсэн техникээр хангагдсан, авто тээвэр болон төрөл бүрийн зориулалттай янз бүрийн гэмт үйлдэлд ашигладаг зэвсэг хэрэгсэлтэй байх гэх мэт онцлогтой байдаг.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл нь зохион байгуулалттай бүлгийг бодвол өндөр түвшинд зохион байгуулагдсан өөртөө хоёр буюу түүнээс дээш тооны зохион байгуулалттай бүлгийг багтаасан тодорхой нутаг дэвсгэрт өөрсдийн хяналтыг тогтоож байдгаараа ялгаатай

байдаг. Түүнчлэн төрийн өндөр албан тушаалтнуудыг өөрсдийн эгнээндээ нэгтгэн, тэднээр өөрсдийгөө хамгаалуулах, өмгөөлүүлэх гэмт үйл ажиллагааныхаа нотлох баримт, сэлтийг устгуулах, дарагдуулах, хариуд нь өндөр албан тушаалд удаан тогтоход нь нөлөөлөхүйц эдийн засгийн баталгаагаар хангах гэх мэт ажиллагаа явуулдаг байна.

Манай улсад гэмт бүлэглэл нэгэнт хэлбэршлээ олсон⁹² Үүний нэг тод жишээ бол дуулиан болсон "17 чингэлэг спиртийн хэрэг", "Казиногийн хэрэг", "Центер-поентийн хэрэг", "Гаалийн Ерөнхий газрын дарга асан Баатар нарын хэрэг", "Хадгаламж банкны 14-н тэр бумын хэрэг", "Монгол улсын ерөнхийлөгч асан Н.Энхбаяр нарын хэрэг" зэрэгт төр засгийн өндөр албан тушаалтан болон эрүүгийн ертөнцөд нэрд гарсан гэмт хэрэгтнүүд түүнчлэн бизнесийн нэр хүнд бүхий элитүүд холбогдсон явдал юм. Сүүлийн үед манай улсын нөлөө бүхий компанийн эзэд хууль хамгаалах болон цагдаагийн байгууллагын удирдлагууд УИХ-ын зарим гишүүд хоорондоо зөрчилдөн тэмцэлдэж өөр, өөрийн гэсэн фракцтай болсон зэрэг олны яриа байдаг. Хэдийгээр тэд үүнийгээ хүлээн зөвшөөрдөггүй боловч чухамдаа тэдний хооронд гардаг зөрчилдөөн дээрх ярианы үнэн бодит байдлыг илтгэх бүлгээ⁹³

Эдгээрээс үзвэл гэмт бүлэглэл өнөөдөр манай улсад үйл ажиллагаагаа явуулсаар байгаа нь тодорхой. Энэ нь Афины Солон /МЭӨ 638-559/ "Хууль эгээ л аалзны шүлс лугаа адил юм. Сул доройг тэр гарах газаргүй болтол хэрэн авдаг, харин хүчтэй нь түүнийг тасдан одох бүлгээ..." гэж хэлсний нотолгоо гэлтэй. 1991.10.21-ээс 25 өдрүүдэд ЗХУ-ын /хуучнаар/ Суздаль хотноо болсон НҮБ-ын олон улсын бага хурал дээр гэмт бүлэглэлийг тодорхойлохдоо "Гэмт хэрэг үйлдэх явдлыг амьжиргааны эх үүсвэр болгосон, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, коррупци болон өргөн хүрээний ашиглал үйлдэх хууль бус арга хэрэгслийг ашиглах замаар нийгмийн хяналтаас хамгаалах системийг өөртөө бий болгосон гэмт этгээдүүдийн тогтвортой, удирдлага зохион байгуулалт бүхий бүлэглэл байгуулахыг хэлнэ."⁹⁴ хэмээн тодорхойлсон. Оросын холбооны улсын ч эрдэмтэн А.И.Долгова "Гэмт хэргийн бүлэглэл гэдэг нь нэг буюу түүнээс дээш этгээд гэмт хэрэг үйлдэхийн тулд урьдчилан хатуу чанд төлөвлөгөө боловсруулж нэгдсэн бүлэг этгээдийг хэлнэ."⁹⁵ гэсэн бол Е.А.Ефимова "Гэмт хэргийн бүлэглэл нь тогтвортой шинжийг хадгална"⁹⁶ гэж тус тус тодорхойлсон.

Зохион байгуулалттай гэмт байгууллага гэдэг нь зохион байгуулалттай гэмт явдлын хамгийн дээд хэлбэр бөгөөд тогтвортой нарийн төвөгтэй шат дараалж захирах ёс ноёрхсон гэмт байгууллагын бүрдэл хэсгийг ойлгоно. Зохион байгуулалттай гэмт байгууллагыг "мафи" гэсэн ойлголттой утга дүйх шинжийг агуулсан гэж хуульч, эрдэмтэд үздэг.⁹⁷ Мафи буюу гэмт байгууллага нь анх ХҮШ-ХІХ зууны заагт Италын Сицилид бүрэн утгаараа үүссэн гэж судлаачид үздэг боловч тухайн үедээ зарим оронд Жишээлбэл: Хятадад "Цэцгийн тамга" нэртэй томоохон гэмт хэрэг үйлддэг сүлжээ байсан боловч энэ талаар дээрх улс орнууд одоо хэрнээ судлаагүйтэй холбоотой.

Оросын Холбооны Улсын Эдийн засаг нийгмийн зөвлөлийн /1993/ ерөнхий нарийн бичгийн даргын илтгэл "Нийгэм дэх зохион байгуулалттай гэмт хэргийн нийт харилцан үйлчлэл"-д өгсөн байдаг. Түүгээрээ тухайн үзэгдлийн шинж чанарыг доорх байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- Зохион байгуулалттай гэмт хэрэг гэдэг нь эдийн засгийн үндсэн дээр нэгдсэн, гэмт этгээдүүдийн бий болгодог үйл ажиллагаа юм. Энэ бүлэглэл дундад зууны үеийн Европт тохиолдож байсан феодализмын үеийн бүлэг залуучуудыг санагдуулдаг. Эдийн засгийн ашгийг тэд хууль бус үйлчилгээ, бараа нийлүүлэх замаар гаргаж авах буюу хууль бус хэлбэрээр хууль ёсны бараа үйлчилгээг нийлүүлэх замаар ашгийг сугалж авдаг.
- Зохион байгуулалттай гэмт хэрэг шатлан захирах ёсны бүтцийг төлөвлөж, хууль бус үйлдлийг хэрэгжүүлэх буюу хууль бус хэрэгслийн тусламжтай хууль ёсны өндөрлөгт хүрэх зорилгоор зохицуулах нууц гэмт хэргийн үйл ажиллагааг төлөвлөсөн байдаг.
- Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд хууль бус бараа үйлчилгээ хэрэглэгчдэд хэсэгчилсэн болон бүрэн монополь тогтоох хандлагатай байдаг боловч ийм маягаар хамаагүй их хэмжээний орлого олох боломжоо баталгаажуулдаг.

⁹² Адъяабазар.Д. Маф. /Гэмт байгууллага/. УБ., 1999. 11 дахь тал

⁹³ Адъяабазар.Д. Термандах.З. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс. УБ., 2005. 20 дахь тал

⁹⁴ Илтгэлийн эмхтгэл. УБ., 1992. 75 дахь тал

⁹⁵ Долгова.А.И. Криминалог." М., 1999. 157 стр

⁹⁶ Ефимова.Е.А. Криминалогия учебной пособие. С., 1964. 184 стр

⁹⁷ Адъяабазар.Д. Мафи. /Гэмт байгууллага/ УБ., 1999. 12 дахь тал

- Өөрсдийгөө хамгаалах зэвсэглэсэн тусгай бүлэг болон гэмт хэрэг дагнан үйлддэг хэд хэдэн зохион байгуулалттай гэмт бүлэглэлийг өөртөө нэгтгэсэн.
- Зохион байгуулалттай гэмт хэрэг нь зөвхөн хууль бус үйл ажиллагаа хэрэгжүүлэх буюу хууль бус үйлчилгээг нийлүүлэхээр хязгаарлагдахгүй. Үүнд: Илүү нарийн мэргэжлийн үйл ажиллагаа болох хууль ёсны эдийн засгийн хөшүүргээс электрон хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэн мөнгө угаах хэрэг мөн ордог. Хууль бус гэмт хэргийн бүлэглэл нь маш олон төрлийн өндөр орлоготой хууль ёсны хэлбэрүүд рүү нэвтэрч байдаг.

Зохион байгуулалттай гэмт байгууллага буюу мафи нь доорхи үндсэн шинжийг өөртөө агуулдаг.

1. Гэмт хэргийг байнга эрхэлж, санхүү материалын хүчирхэг бааз суурьтай бөгөөд харьцангуй тодорхой хувийг нь өөрсдийн хамгаалалтын нэг хэрэгсэл болох төр засгийн өндөр албан тушаалтнуудыг худалдан авахад ашигладаг.
2. Гэмт үйл ажиллагаа хэрэгжүүлэх, асар их хэмжээний орлого олоход чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хүчирхэг мэдээллийн бааз суурьтай байдаг.
3. Адил эрх мэдэл бүхий хүмүүсээр гэмт байгууллагыг удирдах хамтын удирдлагатай байх бөгөөд энэ нь удирдлагын хоёр шат бий болгох, нөгөө талаар нууцлалтай холбоотой. Ингэснээр жинхэнэ удирдагч нь “нууц ноён” болж үлддэг.
4. Гэмт байгууллага нь өөрсдийн гэмт үйл ажиллагаандаа зан заншил болон уламжлалын талаарх бичигдээгүй хууль, дүрэм журмыг чанд баримталж түүнийг зөрчсөний төлөө шударгаар хүлээлгэдэг хатуу тогтоосон хариуцлагатай байдаг.
5. Гаднаас мэдээ мэдээлэл олох, дотоод үйл ажиллагаандаа хяналт тавих, гэмт үйл ажиллагаа явуулах, болон өөрийн байгууллагын нууцлалыг хангахад чиглэгдсэн тагнан турших бие даасан албатай.
6. Хэд хэдэн улс гүрнийг дамнан гэмт үйл ажиллагаа явуулж хууль бусаар ашиг олдог.
7. Эгнээндээ хэд, хэдэн зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийг багтааж тэдний гэмт ажиллагааг удирдлагаар хангадаг зэрэг болно.

Эдгээрээс үзвэл зохион байгуулалттай гэмт явдлыг манай улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангид хуульчилсан “Зохион байгуулалттай гэмт”, “гэмт бүлэглэл” гэсэн тодорхойлолттой харьцуулан үзвэл Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг маань ерөнхий ойлголт бөгөөд түүнийг практикт хэрэглэхэд учир дутагдалтай.

Иймд монголын болон гадаад орнуудын Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд судлагдаж байгаа зохион байгуулалттай гэмт, зохион байгуулалттай гэмт бүлэглэл, зохион байгуулалттай гэмт байгууллага буюу мафийн талаарх хуульчид, эрдэмтдийн ойлголт, тодорхойлолтыг үндэслэн зохион байгуулалттай гэмт явдлын бүтцийг доорхи байдлаар тодорхойлох саналтай байна. Үүнд:

Зохион байгуулалттай гэмт гэдэг нь: холбоо харилцаа нууцлал сахих талаарх дотоод журамтай, гэмт хэрэг үйлдэж хууль бусаар ашиг олохын тулд нэгдсэн түүгээрээ санхүүждэг, тогтвортой ажилладаг, бүлгийн доторх гишүүдийнхээ чиг үүргийг нарийн хуваарилсан, зохион байгуулагч буюу удирдагчтай хоёроос дээш хүмүүсийн нэгдлийг ойлгоно.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл гэдэг нь: Гэмт хэрэг үйлдэж ашиг олох зорилготой, тодорхой бүс нутгийг хяналтандаа авсан, санхүүгийн хувьд бие даасан, материаллаг баазтай, техник технологийн өндөр түвшинд бүтээгдсэн техник хэрэгсэлтэй, төрийн өндөр албанд өөрийн хүнийг ажиллуулдаг, авилгын дотоод сүлжээтэй, хоёр буюу түүнээс дээш зохион байгуулалттай бүлгүүдийн нийлбэр цогцыг ойлгоно.

Зохион байгуулалттай гэмт байгууллага /мафи/ гэдэг нь: Хэд хэдэн улс гүрнийг дамнан гэмт үйл ажиллагаа явуулж онц их хэмжээний ашиг олох зорилготой, банк санхүүгийн бие даасан сүлжээтэй, мэдээллийн бааз суурьтай, мэдээлэл олох дотоод, гадаадад хяналт тавих зорилго бүхий тагнан турших албатай, хамтын удирдлага бүхий шаталсан босоо хэлбэртэй, зохион байгуулалт, нууцлалын нарийн тогтолцоотой, хатуу тогтсон бичигдээгүй хуультай, өөрийгөө хамгаалах зэвсэгт бүлэг болон байгууллагын хэмжээнд ажилладаг хэд хэдэн зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн нэгдлийг ойлгоно гэж тус тус тодорхойлж болно.

Дүгнэлт: /Санал/

Дэлхий дахинд даяаршлын үйл явц улам бүр гүнзгийрэхийн зэрэгцээ олон улсыг хамаарсан, үндэстэн дамнасан зохион байгуулалттай террорист үйл ажиллагааг, түүнээс улбаалсан гэмт хэрэг, тухайлбал галт зэвсэг, мансууруулах бодис болон хүнийг хууль бусаар хил давуулах, наймаалах гэмт хэргүүд газар авч, терроризмын аюул дэлхийг хэрж, өөрийн үйл ажиллагаагаа

явуулах сүлжээтэй болоод байгаа нь улс орныг нэгдмэл хүчээр хамтран ажиллахыг шаардаж байна.⁹⁸

Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн мөн чанар, ойлголтын талаар Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлолт өгч, холбогдох хууль, эрхийн акт, түүний хэм хэмжээг боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэж байна.

Хууль зүйн яамнаас Улсын Их Хуралд өргөн бариад байгаа Монгол Улсын Гэмт хэргийн тухай хуулийн төсөлийн 3 дугаар бүлэгт хуульчлагдсан гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр болох 3.6 дугаар зүйлд заасан “Гэмт хэргийг бүлэглэн гүйцэтгэх”, 3.7 дугаар зүйлд “Зохион байгуулалттай гэмт бүлэг”-ийн талаар тусгасан тодорхойлолт, нийгэмд нэгэнт буй болсон зохион байгуулалттай гэмт явдлын талаарх ойлголт, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал зайлшгүй шаардлагатай ба хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудын энэ талаарх ойлголт, мэдлэг дутмаг, Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хэм хэмжээг практикт зөв ойлгон хэрэгжүүлэх явдал нэг мөр болоогүй байгаа нь амьдралд буй болсон зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн үйл ажиллагаатай тэмцэхэд учир дутагдалтай байгаатай холбоотой.

2002 онд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 10-н жил өнгөрсөн боловч Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, судалгааны төв, Улсын дээд шүүхийн судалгааны төвийн дүн, мэдээнээс үзэхэд зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлээс үйлдсэн хэргийг бүртгэж, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан тоон мэдээ байгаа боловч шүүхээр шийдвэрлэгдээгүй байна. Дээрх баримтаас үзвэл хууль хэрэглэж байгаа практик ажилтнуудын зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн талаарх ойлголт дутмаг, энэ талаарх эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус байгаа харагдаж байна.

Иймд Улсын Их хуралд өргөн барьсан Монгол Улсын Гэмт хэргийн тухай хуулийн төслийг мөн хуулийн зорилт, зарчмыг ханган боловсронгуй болгох зорилгоор 3 дугаар бүлэг “Гэмт хэрэг хамтран үйлдэх”, 20 дугаар бүлгийн 20.6 дугаар зүйл “Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах” талаар тусгасан ойлголтыг нийгмийн шаардлагад нийцүүлэн судлаач миний бие доорхи байдлаар тусгуулан, томъёолуулахаар санал дэвшүүлж байна.

3 дугаар бүлэг Гэмт хэрэгт хамтран үйлдэх

3.6 дугаар зүйл. Бүлэглэн гүйцэтгэх

Санаатай гэмт хэргийг хоёр, эсхүл түүнээс дээш хүн хамтран биечлэн үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэх гэж үзнэ.

3.7 дугаар зүйл. Зохион байгуулалттай бүлэг

Гэмт хэрэг үйлдэхийн тулд нэгдсэн, холбоо харилцаа нууцлал сахих талаарх дотоод журамтай, гэмт хэрэг үйлдэж хууль бусаар ашиг олохын тулд нэгдсэн түүгээрээ санхүүждэг, тогтвортой ажилладаг, бүлгийн доторх гишүүдийнхээ чиг үүргийг нарийн хуваарилсан, зохион байгуулагч буюу удирдагчтай хоёроос дээш хүмүүсийн нэгдлийг *Зохион байгуулалтай бүлэг* гэнэ.

3.8 дугаар зүйл. Зохион байгуулалтай гэмт бүлэглэл

Гэмт хэрэг үйлдэж ашиг олох зорилготой, тодорхой бүс нутгийг хяналтандаа авсан, санхүүгийн хувьд бие даасан, материаллаг баазтай, техник технологийн өндөр түвшинд бүтээгдсэн техник хэрэгсэлтэй, төрийн өндөр албанд өөрийн хүнийг ажиллуулдаг, авилгын дотоод сүлжээтэй, хоёр буюу түүнээс дээш зохион байгуулалттай бүлгүүдийн нийлбэр цогцыг *Зохион байгуулалтай гэмт бүлэглэл* гэнэ.

3.9 дугаар зүйл. Зохион байгуулалтай гэмт байгууллага /мафи/

Хэд хэдэн улс гүрнийг дамнан гэмт үйл ажиллагаа явуулж онц их хэмжээний ашиг олох зорилготой, банк санхүүгийн бие даасан сүлжээтэй, мэдээллийн бааз суурьтай, мэдээлэл олох дотоод, гадаадад хяналт тавих зорилго бүхий тагнан турших албатай, хамтын удирдлага бүхий шаталсан босоо хэлбэртэй, зохион байгуулалт, нууцлалын нарийн тогтолцоотой, хатуу тогтсон бичигдээгүй хуультай, өөрийгөө хамгаалах зэвсэгт бүлэг болон байгууллагын хэмжээнд ажилладаг хэд хэдэн зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн нэгдлийг *Зохион байгуулалтай гэмт байгууллага /мафи/* гэнэ.

⁹⁸ Баатар.Ч, “Терроризм, аюулгүй байдал” УБ, 2006 он, 3 дахь тал

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАТАЛГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Зэвэгийн Цэрэнбат

ОХУ-ын ДХЯ-ны Москвагийн их сургуулийн
адъюнкт, цагдаагийн дэд хурандаа

Төрөөс улс орны дотоод аюулгүй байдлыг хангах бодлого, хууль сахиулах үйл ажиллагааны стратегийн үндсэн асуудлуудаар эрх зүйн шинэчлэлийг эрдэм шинэжилгээ судалгааны ажилд тулгуурлан иж бүрэн өөрчлөлтийг хийхээр төлөвлөн, ажиллаж байгаа нь сайшаалтай. Хууль зүйн Сайдын 2012 оны 09 дүгээр сарын 21-ны А/15 тоот тушаалаар “Хууль зүйн салбарын нээлттэй бодлого”⁹⁹ батлагдаж, хэрэгжиж байна. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ард иргэдээ хамгаалах хууль сахиулах төрийн бодлогыг гагцхүү тангараг өргөсөн төрийн тусгай алба хаагч л амьдрал дээр хэрэгжүүлж ажиллана. Судлаач энэ удаад “Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн баталгааны зарим асуудлууд” сэдвийг хөндөж байна. Ард иргэдийн дунд төрийн хууль сахиулах бодлого, үйл ажиллагааг хэвийн, өнөөгийн шаардлагад нийцүүлэн явуулахад цагдаагийн алба хаагчийн эрх зүйн баталгааны асуудал голлох үүрэгтэй болох нь судалгаанаас ажиглаж байна.

ЦЕГ-ын 2010 оны 691 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн албан хаагч, ажиллагсадын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”, ХЭҮК, ЦЕГ-ын хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийг хангахаар ЦЕГ-аас захиалсан судалгааны ажлыг ХСИС-ийн ШУТГазар “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл” сэдэвт нэгдсэн удирдамж батлуулж, судалгааны ажлыг 2012 оны 5 сараас эхэлсэн юм¹⁰⁰.

Нийгмийн хөгжлийн чиг хандлага, хүний эрхийг хамгаалах асуудалтай уялдаад цагдаагийн байгууллагын олон талт үйл ажилагаанд тулгамдаж байгаа асуудлуудын нэг нь алба хаагчийн эрх зүйн баталгаа юм. **Баталгаа** - хэмээх ойлголт нь хүн төрөлхтөний үйл ажиллагааны

⁹⁹ www.moj.gov.mn

¹⁰⁰ . Монгол улсын Хууль зүйн яам, Хууль сахиулах их сургууль, Цагдаагийн ерөнхий газар. “цагдаагийн алба хаагчийн ёсзүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэчлэл”. Судалгааны тайлан. УБ., 2013. 8 дахь тал.

хүрээний янз бүрийн салбарыг хамаарна. Тухйлбал: улс төрийн бодлого, дипломат албаны үйл ажиллагаанаас гадна цагдаагийн ажилтаны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралтай байдаг¹⁰¹.

Эрх зүйн хамгааллалтын баталгаа-Цагдаагийн албан хаагчид хуулиар хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд тохиолдох саад бэрхшээл, аюул заналыг өөртөө итгэлтэй, санаачлагатай давж туулах, биелүүлэх хууль, эрх зүйн тогтолцоо, баримтлах бодлого, арга, хэрэгсэлээр хангах тогтолцооны цогцийг хэлнэ¹⁰². Ямар ч нийгэмд хуулийг дээдлэх ухамсар олгох үйл ажиллагааг ард иргэдийн хүсэл эрмэлзлэл, төлөвшиж буй ухамсар дээр төрийн тусгай алба хаагч хууль ёсны шаардлага тавих нь нийгэмд хуулийг дээдлэх, сахиулах, үзэл бодол төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй. Цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг албан байгуулага, иргэн заавал биелүүлэх үүрэгтэй.

Хэрвээ хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хуульд заасан үндэслэл журмын дагуу тухайн байгуулага, иргэнээр биелүүлүүлэх үүрэг хариуцлагыг алба хаагч өөртөө хүлээсэн байдаг. Цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлага нь төр, хуулийн засаглалын албан тушаалтаны ганцаарчилсан шийдвэр (захиргааны акт) бөгөөд тухайн этгээдийн нэр, хаяг, дээр биелүүлэхийг шаардсан, зохих журмын дагуу заавал биелүүлэх үүрэгтэй, хариуцлагын тогтолцоо байдаг. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах чиг үүргийг гүйцэтгэхэд ямар нэгэн асуудалд орсон, агсам согтуу, онгирсон, доргисон, бухимдсан, эрсдэл учруулж болзошгүй хүмүүстэй харьцдаг учраас цагдаагийн алба хаагч өөрөө эрсдэл бүхий орчин, нөхцөлд үүрэг гүйцэтгэж байна¹⁰³.

Цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх нь өнөөгийн нийгмийн сэтгэл зүй, ард иргэдийн дунд хууль, дүрмийг сахих ухамсарт үйл ажиллагаага, алба хаагчийн харилцаа хандлага, соёл, төр, эрх зүйн хамгаалалт, баталгаатай салшгүй холбоотой. Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй эсэргүүцсэн зөрчил буурахгүй нийгэмд хавтгайрах шинжтэй болж буурахгүй байгаа учир ЗХТХ-н 30²-д заасан цагдаагийн алба хаагчийн тавьсан шаардлага үл биелүүлэх, заналхийлсэн зөрчилд 7-14 хоног хүртэл хугацаагаар баривчлах гэснийг өөрчлөн, 30 хоног баривчлах шийтгэл оногдуулна гэж нэмэлт оруулах; Цагдаагийн алба хаагчдыг доромжлох, дарамтлах, тэдний хууль ёсны шаардлагыг иргэдийн зүгээс эсэргүүцэх, хүч хэрэглэх, амь биед нь халдах зэрэг үзэгдэл сүүлийн үед нэмэгдэж байна.¹⁰⁴ Жишээ нь: 2012.08.14-ны өдрийн 20 цаг 30 минутанд Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Улаан-уул өртөөнд галт тэрэг зогсох үед пирон дээр ажиллаж байсан цагдаагийн алба хаагч ахлагч Б.Болджаргалын тавьсан хууль ёсны шаардлагыг иргэн Т. Оюунболд эсэргүүцэж бусадтай бүлэглэн зодож дүрэмт хувцасыг нь урж танхайрсан үйлдэл гаргаж шүүхээр шийтгэгдсэн байна.

2008-2012 онд цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад цагдаагийн 973 алба хаагч амь нас, эрүүл мэндээрээ хохирчээ¹⁰⁵.

Цагдаагийн ажилтануудыг эрх зүйн баталгаагаар нь баттай хангаж, хамгаалж чадсан тэр үед л манай нийгэмд гараад байгаа, шударга бус байдал, үлгэр дууриалалгүй байх зэрэг хууль бус үйлдэлүүд, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, багасгах боломжтой.

Нийгмийн дээд давхараг буюу хөрөнгөтэй, эрх мэдэлтэй хүмүүсийн дунд гарч байгаа шударга бус үйлдэл, хууль бус үйл ажиллагаа нь нийгмий сэтгэл зүйг бүхэлд бохирдуулах, төр, нийгэмд асар их хор, хохирол учруулсаар байгааг мэдээлэлийн хэрэгсэлээр цацагдаж байна. Тухайлбал: Цагаан захтануудын давхарагт (сонгуулийн дүнг будлиантуулах, шударга бусаар өрсөлдөх, талцах, хууль бусаар жагсаал цуглаан зохион байгуулах, албан тушаалын наймаа, авилга, хээл хахуул өгөх, авах, тендерийн хууль бус үйлдэлүүд, улс орны эрх ашгийг бодохгүй зөвхөн хар амиа бодох, мөнгө угаах, мэдээлэлийн хэрэгсэлийг хууль бусаар өөртөө ашиглах улмаар бусдыг гүтгэх, доромжлох гэх мэт).

Нийгмийн дунд, давхарагт (хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, архины ухамсаргүй хэрэглээнээс үүдэлтэйгээр гарч байгаа гэмт үйлдэлүүд, хүнд суртал гаргах, ажлын хариуцлага алдах, бусдыг үл хүндлэх, танхайрах, доромжлох, гүтгэх мэт).

¹⁰¹. Правовая и социальная защита сотрудников органов внутренних дел: учебное пособие / В.Я.Кикоть, В.А. Рыбин. Введение доктора юридических наук, профессора С.И. Гирько. М. : ЦОКР МВД России, 2009.- С. 65.

¹⁰². Гайдов В.Б. Правоохранительная служба в органах внутренних дел Российской Федерации: Учебное пособие.- М., ЦОКР МВД России, 2009, С. 95.

¹⁰³. Монгол улсын Хууль зүйн яам, Хууль сахиулах их сургууль, Цагдаагийн ерөнхий газар. “цагдаагийн алба хаагчийн ёсзүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэчлэл”. Судалгааны тайлан. УБ., 2013. 28. дахь талд.

¹⁰⁴. Мөн тэнд. 29 дахь талд

¹⁰⁵. ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төвийн гаргасан 2012 оны мэдээ

Нийгмийн доод давхарагт (булаалт, залилан, хулгайлах, хэн нэгнийг мөнгөний төлөө захиалгаар гэмт хэргийн хохирогч болгох, архийг хэтрүүлэн хэрэглэсэн үед үйлдэгдэж буй бусад гэмт үйлдэлүүд гэх мэт).

Нийгмийн давхарагуудад гарч байгаа гэмт хэргийн нөхцөл байдлаас ажиглахад нийгмийн дунд баян, ядуугийн ялгаа илт мэдрэгдэж, дээд давхараг руу орох, эрх мэдэлтэй, хөрөнгөтэй болохын тулд тэмцэл маш хүчтэй өрнөж байгаа учраас цагаан захтануудын дунд гарах гэмт хэрэг сүүлийн үед эрс нэмэгдэх хандлагатай байна.

Цагдаагийн алба, үйл ажиллагааг хүчгүй, сул дорой, хэн нэгний гар хөл мэт байлгах, төр, эрх зүйн хамгаалалтын баталгаагүй байлгах сонирхолтой хүмүүс байхыг үгүйсгэхгүй байна. Ядуу цагдаа нийгэм болоод төрд аюултай. Цагдаагийн ажилтаны ёс зүйн хэм хэмжээг зөрчих, гэмт хэрэг, зөрчилд холбогдож байгаа шалтгаан, нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах явцад цагдаад төрөөс тавих бодлого, эрх зүйн хамгаалалт баталгаа хангалтгүй байгаа нь ажиглагдаж байна.

ЦЕГ-ын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтсийн 2012 оны мэдээгээр цагдаагийн алба хаагчид 2008 онд 220, 2009 онд 206, 2010 онд 141, 2011 онд 177, 2012 онд 132, нийт 876 алба хаагч гэмт хэрэгт холбогджээ¹⁰⁶. Ялангуяа ард иргэдийн дунд албаны нэр хүнд сайн биш байна.

Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаанд саад хийсэн гэмт үйлдэл, эс үйлдэл, захиргааны зөрчлийг зохицуулах тухай хуулийн заалт байгаа хэдий ч өнөөдөр нийгмийн харилцааг бүрэн зохицуулах боломжгүй байгаа нь судалгаанаас ажиглаж байна. Манай улстай эрх зүйн тогтолцооны хувьд ижил төсөөтэй, сүүлийн үед шинэчлэгдээд байгаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн хамгаалалт, баталгаатай холбоотой ОХУ-ын зарим хуулиудын талаар товч дурдая. Цагдаагийн ажилтаны нийгэм, эрх зүйн хамгаалалт, баталгаатай холбоотой харилцааг Холбооны улын ДХЯ-ны Цагдаагийн ажилтаны нийгмийн баталгааны тухай бие даасан хуулиар зохицуулагдаг¹⁰⁷.

ОХУ-д цагдаагийн алба хаагчид халдах хэрэг, зөрчлийн бүрэлдэхүүнийг улсын *эрүүгийн болон захиргааны тухай хуулиар* тодорхой зохицуулалт хийж өгсөн байдаг. Тухайлбал захиргааны эрхийн тухай хуулиар дараах **үйлдэл, эс үйлдлийг гэм буруутайд тооцно:**

- Замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэлийн жолооч зохицуулагчийг эсэргүүцсэн дуут дохио өгөх, (ЗТХ. 12.12)
- Замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэлийн жолооч гүйцэт түрүүлж явах зорилгоор дуут болон гэрэлэн дохио өгч давуу эрх эдлэх, (ЗТХ. 12.17)
- Захиргааны зөрчлийн хэргээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон албан тушаалтаны хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх, (ЗТХ.17.7)
- Цагдаагийн ажилтанд албаны хамааралтай асуудлаар хууль бус тушаал шийдвэр, зөвлөмж өгөх, (ЗТХ.19.13)
- Терроризмын эсрэг тусгай ажиллагаа явуулж байгаа хэсэгт тусгай ажиллагаа явуулж байгаа ажилтаны хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх, (ЗТХ.20.27)
- Улсын тогтоосон хуулийн дагуу шүүхийн шийдвэрээр зарим этгээдийн эрхийг хязгаарлах, байрлалыг чөлөөлөх албан тушаалтаны шийдвэрийг биелүүлэхгүй байх, (ЗТХ.19.24.),
- Хөдөлгөхийг хориглосон лац (ломбо) тэмдэгийг санаатайгаар хөдөлгөх, урах, устгах (ЗТХ.19.2),

Түүнээс гадна хуулийн 4.3. д заасанаар захиргааны зөрчил гаргасан этгээд эрх бүхий албан тушаалтаны шийдвэрийг эсэргүүцсэн, хууль зөрчсөн үйлдэлээ үргэлжлүүлсэн тохиолдолд хариуцлагыг тогтоосон хуулийн дагуу асуудлыг хүндрүүлэх үзэх үндэслэл болно. Дээрхи тохиолдолд цагдаагийн алба хаагч захиргааны зөрчлийг таслан зогсоох албадлагын арга хэрэглэх зайлшгүй шаардлага гардаг.

ОХУ-ын эрүүгийн хуулиар цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны хэм хэмжээг хамгаалах зорилгоор **дараах үйлдэл, эс үйлдлийг** эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна.

- Нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн, албан үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбогдуулж алба хаагчийг болон түүний гэр бүлийн хүмүүсээс алах.(ЭХ. 105.2),

¹⁰⁶ .Мөн тэнд. 20 дахь талд

¹⁰⁷ .О социальных гарантиях сотрудникам органов внутренних дел Российской Федерации и внесении изменений в отдельные законодательные акты Российской Федерации: Федеральный закон Российской Федерации.- Ростов н/Д: Феникс,2012.- 93,(2) (Закон и общество).

- Албан үүргээ гүйцэтгэсэнтэйн холбогдуулж алба хаагчийг болон түүний гэр бүлийн хүмүүсийг тамлах. (ЭХ.117.2.),
- Төрийн төлөөлөгчийн хууль ёсны шаардлагыг идэвхтэй эсэргүүцсэн, эсэргүүцэхийг бусдад уриалсан, төрийн төлөөлөгчид зэвсэг хэрэглэсэн, нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсан.(ЭХ.212.1.),
- Нийгмийн хэв журмын зөрчлийг таслан зогсоосон, нийгмийн хэв журмыг сахиулсан төрийн төлөөлөгчийг эсэргүүцэх зорилгоор танхайрсан. (ЭХ. 213.2.),
- Урьдчилан мөрдөн байцаах ажиллагаа болон шүүх ажиллагаанд саад учруулсан. (ЭХ.294.),
- Урьдчилан мөрдөн байцаах болон шүүх ажиллагаа явуулж байгаа албан тушаалтаны амь нас, эрүүл мэндэд халдсан. (ЭХ.295.),
- Урьдчилан мөрдөн байцаах болон шүүх ажиллагаа явуулах, албан үүргээ гүйцэтгэсэнтэйн холбогдуулж хүч хэрэглэсэн, аюул учруулсан. (ЭХ.296.),
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, шүүгч, гэрч, мөрдөн байцаагч,прокурор болон шүүх хуралдаанд оролцогчидтой харилцахдаа гүтгэсэн. (ЭХ.298.),
- Цагдаагийн алба хаагчийн амь насанд халдсан. (ЭХ.317.),
- Төрийн төлөөлөгчтэй харилцахдаа хүч хэрэглэсэн.(ЭХ.318),
- Төрийн төлөөлөгчийг хэл амаар доромжилсон. (ЭХ.319.),
- Хууль сахиулах, болон хяналт, шалгалтын байгууллагын албан тушаалтантай харилцахдаа олж авсан аюулгүй байдлыг хангахтай холбоотой мэдээлэлийг задруулсан. (ЭХ.320.),
- Албан байгууллагын хэвийн үйл ажиллагааг хутган үймүүлэх, нийгмээс салан тусгаарлах нөхцлийг бүрдүүлсэн. (ЭХ.321.),

ОХУ-ын эрүүгийн хуулийн 63.1. ийн “ж, и”-д заасанаар албан тушаалтаныг албан үүргээ гүйцэтгэсэнтэйн холбогдуулан өөртэй нь болон гэр бүлийн хүмүүстэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн, гэмт үйлдэлдээ төрийн төлөөлөгчийн албаны хувцас, үнэмлэх ашигласан тохиолдолд эрүүгийн ялыг хүндрүүлж оногдуулахаар зүйлчилсэн байна.

Аргагүй хамгаалалтын тухай, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах ажиллагааны үед гарцаагүй байдлын улмаас гэм хор учруулах, тушаал шийдвэр биелүүлэх осол, аюултай үед сэтгэл зүйн болоод биеийн хүчээр албадлагын арга хэрэглэх зэрэг цагдаагийн алба хаагчийн үйл ажилагааны эрх зүйн баталгааны талаар эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр тодорхой зохицуулж өгсөн байна.

Гэмт этгээдийн эсэргүүцэл үзүүлж байгаа хүч, арга хэрэгсэлээс хамаараад алба хаагч хуульд заасан үндэслэл журмын дагуу галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч, мэх хэрэглэсэний улмаас эсэргүүцэгч этгээдэд бие, сэтгэл санааны болоод, эд материалын хохирол учруулсан нь цагдаагийн ажилтанд **ямар нэгэн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй**¹⁰⁸.

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийн 41-р зүйлд анх удаа энэ институцийг тусгайлан хуульчилахдаа “ Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтан шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэхийн тулд баривчилах, саатуулах үед энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй”...¹⁰⁹

Цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрийн харилцааг зохицуулах, хамгаалах эрх зүйн хөшүүрэг нь алба хаагч нь өөрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах гэсэн чин хүсэл эрмэлзлэл байдаг. Өөрөөр хэлбэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орчин, хүсэл эрмэлзлэл юм. ОХУ-ын цагдаагийн тухай хуулийн 30.1-д алба хаагчийн эрх зүйн хамгаалалтын баталгаан гээд: *Цагдаагийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэх, хууль ёсны шаардлага тавих, хууль сахиулах үйл ажиллагаа явуулдаа төрийг төлөөлж байдаг тул төрийн хамгаалалтанд байна*¹¹⁰. гэж тодорхойлсон.

Мөн цагдаагийн албанд алба хаах тухай тогтоолд алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, алба хаагчийн эрхийг хамгаалах асуудлыг нилээд тодруулж өгсөн байна. Тухайлбал: Уг тогтоолд алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан нь холбогдох хууль, дүрмэнд нийцэхгүй байна гэж үзвэл алба хаагч Дотоод хэргийн сайд хүртэл гомдолоо гаргахаас гадна, тогтоосон журмын дагуу шүүхэд гаргаж болно. Алба хаагч шууд захирах даргынхаа гаргасан дараах шийдвэрт гомдол гаргах эрхтэй үүнд:

- Албан тушаалыг нь өөрчилсөн

¹⁰⁸ Гайдов В.Б. Правоохранительная служба в органах внутренних дел Российской Федерации: Учебное пособие.- М., ЦОКР МВД России, 2009, С. 95.

¹⁰⁹ .С. Жанцан. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол / Гэмт хэргийн тухай сургаал / 1-р боть. УБ., 2009. 703 дахь тал.

¹¹⁰ . Федеральный закон << О полиции >>.-Москва: Проспект, О-11 2011, С.51.

- Албаны асуудлаар орон тоогүй болгосон
- Албан тушаал бууруулсан
- Мэргэжилийн цол, зэргийг бууруулсан
- Ажлаас чөлөөлсөн

Цагдаагийн алба хаагчийн эрх нь зөрчигдсөн гэж үзвэл хамгаалахын тулд дараах байдлаар шийдвэрлүүлдэг байна үүнд:

- Алба хаагч зөрчигдсөн эрхээ хамгаалуулахтай холбоотой ямар ч асуудлыг урьдчилан хэлэхгүйгээр байгууллагынхаа даргад шууд мэдэгдэхээс гадна шүүхээр хамгаалуулах эрхтэй.
- Алба хаагчдын хооронд болон даргалах бүрэлдэхүүтэй үзэл бодол таарахгүй зөрчилдсөн шаардлагатай гэж үзвэл шууд захирах даргаасаа эхлээд Дотоод хэргийн сайд хүртэл гомдолоо бичгээр гаргаж шийдвэрлүүлнэ.
- Алба хаагч гомдолоо дээд шатны шүүхэд гаргахдаа иргэний эрх, эрх чөлөө зөрчигдсөн шүүхийн шийдвэрт гомдол гаргах тухай хуулийг мөрдлөгө болгодог байна.

Монгол улсын үндсэн хуулийн 2. 10-д <<нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй>>¹¹¹. гэж заасан нь цагдаагийн алба хаагч бусад иргэдийн нэгэн адил үндсэн хуулиар баталгаатай эдлэвэл зохих эрх, эрх чөлөө, өөрийнхөө хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, хамгааллуулах олон нийтийн байгууллагатай байх тэр эрх зүйн орчныг бий болгох нь зүйд нийцнэ. Гэхдээ алба хаагчийн хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалах, олон нийтийн байгууллага байгуулах эвлэлдэн нэгдэх үйл ажиллагааг нь холбогдох хуулийн зүйл заалтыг үндэслэн журмаар зохицуулж болно.

Гадаадын зарим улс орнуудын цагдаагийн мэргэжилийн холбоо (ассоциации) нь алба хаагчдын хууль ёсны эрх, ашгийг хамгаалах үйл ажиллагаа нь нилээн туршлагатай болсон. Тухайлбал Баруун Европ, АНУ, Канад зэрэг орнуудад 1940 оны үеийн нийгмийг ардчилах үйл явцтай холбогдоод цагдаагийн алба хаагч түүний нийгэмийн болон эрх зүйн хамгаалалтыг нэмэгдүүлэх, нийгэмд цагдаагийн албаны нэр хүндийг дээшлүүлэх шаардлага бий болсон¹¹².

Орчин үеийн ОХУ-ын ДХЯ-ны Цагдаагийн анги салбаруудын цагдаагийн мэргэжилийн холбоо (ассоциации) нь эрүүгийн эрэн сурвалжлах ажиллагаа, сэргийлэхийн зохион байгуулалтанд 1917-1932 онд дотоодыг Хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүний мэргэжил, эдийн засгийн болон бусад эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах зорилгоор үйл ажиллагаа явуулж байсан.¹¹³

ОХУ-ын цагдаагийн тухай хуулийн 6.31. д Цагдаагийн ажилтаны мэргэжилийн холбоо (ассоциации) -д элсэх эрхтэй. гээд:

1. Цагдаагийн ажилтан өөрийн хууль ёсны нийгэм, хөдөлмөрийн эрх ашгийг хамгаалах зорилгоор мэргэжилийн холбоо (ассоциации) -д элсэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.
2. Цагдаагийн ажилтаны мэргэжилийн холбоо (ассоциации)- ны үйл ажиллагаа явуулах журмыг холбооны улсын хууль, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулна.¹¹⁴

Дотоод хэргийн байгууллагуудын мэргэжилийн холбоодын үйл ажиллагааны үндсэн зорилт нь:

- Байгууллагын албаны нэр хүндийг дээшлүүлэх
- Байгууллагын ажилтаны нийгмийн хамгаалалтыг тогтвортой нэмэгдүүлэх
- Мэргэжилийн холбооны гишүүдийн нийгмийн болон эрх зүйн хамгаалагдсан байдлыг улам бүр бэхжүүлэх
- Гишүүдийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, үг хэлэх үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөл бололцоог бүрдүүлнэ.¹¹⁵

ОХУ-д одоо мөрдөгдөж байгаа хууль болон хуульчилсан эрх зүйн актуудад цагдаагийн алба үйл ажиллагаа, ажилтаны эрх зүйн хамгаалалт, баталгаатай холбоотой асуудлуудыг нилээн тодорхой тусгасан нь дээрхи зүйл, заалтуудаас харагдан.

¹¹¹ Монгол улсын үндсэн хууль.Хууль зүйн үндэсний хүрээлэн. 4. дэх хэвлэл.УБ.,2010. 10дах тал.

¹¹² См.,Архипов О.Г. Социально-правовой статус работников органов внутренних дел. Автореферат.Дисс., Канд., юрид., наук. М.,1992, С.34.

¹¹³ См., Бурдин К.И. Методические проблемы функционирования общественных объединений и организаций в органах внутренних дел.М.,1995.С.24

¹¹⁴ Федеральный закон << О полиции >>.-Москва: Проспект, О-11 2011, С.52.

¹¹⁵ . Гайдов В.Б. Правоохранительная служба в органах внутренних дел Российской Федерации: Учебное пособие.- М., ЦОКР МВД России, 2009, С. 99.

Үүргээ гүйцэтгэж яваад л гэмт хэрэгт холбогдох, ёс зүйн зөрчил, үйл ажиллагааны журам, үйлчилгээний стандарт зөрчсөн болох тохиолдол бий. Иймд цагдаагийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх нийгэм, эдийн засаг, **ялангуяа эрх зүйн баталгаа**, нөхцөлийг тодорхой болгох асуудал ч хөндөгдөж байна¹¹⁶.

Ингээд Монгол улсын засгийн газрын эрх зүйн шинэчлэлийн бодлого хөтөлбөрийн хүрээнд хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цагдаагийн албаны тухай болон бусад хуулиудын төсөл хэлэлцэгдэж байгаа энэ үед ажилтаны эрх зүйн баталгаатай холбоотой асуудлаар дараах зүйл заалтуудыг оруулах нь зүйтэй гэж үзэж байна үүнд:

Долоо дугаар зүйл. Хууль сахиулагчийн эрх.

7.1.8. Албан байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, боловсронгуй болгох, алба хаагчийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, хамгааллуулах зорилгоор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, зөрчигдсөн тохиолдолд гомдол гаргаж шийдвэрлүүлэх. *Гэж өөрчлөн найруулах.*

7.1.9. Хууль сахиулагч гүйцэтгэх албан тушаалтан нь өөрсдийн төлөөлөлийг дотроо сонгож мэргэжилийн төв байгууллагын болон орон нутгийн мэргэжилийн байгууллагын удирдах бүрэлдэхүүн (Зөвлөл)-д оруулж ажиллуулах. *Гэж шинээр оруулж зүйлчлэх.*

7.1.10. Хууль сахиулагч гүйцэтгэх албан тушаалтанаас төрийн албадлага хэрэглэх эрхтэй холбогдсон харилцааг цагдаа, мөрдөх, маршалл, шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, иргэний харьяалал, шилжих хөдөлгөөний тухай тус тусын хуулиар зохицуулагдана. *Гэж нэмэлт өөрчлөлт оруулах.*

28 дугаар зүйл. Улс төрийн баталгаа.

28.1. Хууль сахиулагч нь албан үүргээ гүйцэтгэх, хууль ёсны шаардлага тавих, хууль сахиулах үйл ажиллагаа явуулдаа төрийг төлөөлж байдаг тул төрийн хамгаалалтанд байна. *гэж шинээр оруулж зүйлчлэх.*

28.3 Хууль сахиулагч гүйцэтгэх албан тушаалтан нь өөрийн мэргэжлийн үйл ажиллагаанд хамааралтай мэргэжлийн холбоо (ассоциаци)-нд эвлэлдэн нэгдэх эрхтэй. *Гэж өөрчлөн найруулах.*

28.4 Хууль сахиулагч гүйцэтгэх албан тушаалтан нь хууль сахиулах үйл ажиллагаанд харшлахгүйгээр, байгуулага, албан тушаалтаны алба, үйл ажиллагааны чанар үр өгөөжийг сайжруулах, өөрийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, хамгааллуулах зорилгоор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдэлнэ. *Гэж өөрчлөн найруулах.*

28.5 Гүйцэтгэх албан тушаалтаны мэргэжилийн холбооны ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. *Гэж шинээр оруулж зүйлчлэх.*

29 дүгээр зүйл. Хууль зүйн баталгаа.

29.7. Алба хаагчийн хувийн аюулгүй байдал, албаны бэлэн байдлыг хангах, тэдний мэдлэг, дадлага, чадвар, чадамж, хандлагыг дээшлүүлэх сургалтыг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу мэргэжилийн байгууллагын дарга зохион байгуулж, үр дүнг тооцно. *Гэж шинээр оруулж зүйлчлэх.*

29.8. Мэргэжилийн төв байгууллагын болон орон нутгийн мэргэжилийн байгууллагын удирдах бүрэлдэхүүн (Зөвлөл)-д сонгогдсон гүйцэтгэх албан тушаалтан нь алба хаагчдын ёс зүй, тэдний хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах ажлыг энэ хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн актуудад нийцүүлэн зохион байгуулж ажиллана. *Гэж шинээр оруулж зүйлчлэх зэрэг санал дэвшүүлж байна.*

Аливаа нийгэм дахь өөрчлөлт, шинэчлэлтийн зорилго нь өнгөрсөн, одоо, ирээдүйн хөгжлийн тунгаамал байдагт л оршино. Цагдаагийн ажилтаны эрх зүйн хамгаалалт, баталгааны эрх зүйн орчин боловсронгуй болж, амьдралд бодитой хэрэгжиж эхэлсэнээр удирдлага зохион байгуулалт, алба хаагчдын албандаа хандах, идэвх, санаачлага, ажлын чанар үр дүн сайжирч үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах төрийнхээ өмнө хуулиар хүлээсэн үүргээ амжилттай гүйцэтгэх явдал юм.

¹¹⁶. Монгол улсын Хууль зүйн яам, Хууль сахиулах их сургууль, Цагдаагийн ерөнхий газар. “цагдаагийн алба хаагчийн ёсзүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэчлэл”. Судалгааны тайлан. УБ., 2013. 29. дахь талд.

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Төмөр-Очирын Азжаргал
ХСИС-ийн Ерөнхий эрдэмийн сургуулийн,
ТЗЭЗТ-ийн багш, дэслэгч, докторант

Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хамгаалах түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг хамгаалах нь гаалийн байгууллагын хүлээсэн хүндтэй үүрэг билээ. Энэхүү үүргээ биелүүлж ажиллахад гаалийн харилцаанд оролцогчдын зүгээс хууль тогтоомжийг санаатай болон болгоомжгүй хэлбэрээр зөрчих явдал цөөнгүй тохиолддог.

Гаалийн зөрчил нь эрх зүйн зөрчлийн нэг төрөл бөгөөд захиргааны зөрчлийн үндсэн шинжийг агуулсан байдаг.

Гаалийн зөрчил гэдэг нь: Нийт буюу тодорхой нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон гаалийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл эс үйлдэхгүйг хэлнэ. Олон улсын эрх зүйд гаалийн зөрчлийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Дэлхийн гаалийн байгууллагын нэр томъёоны тайлбарт гаалийн зөрчил гэдэгт: Гаалийн байгууллын хууль тогтоомжийг зөрчсөн эсхүл зөрчихийг завдсан үйлдэл гэж тодорхойлжээ.¹¹⁷

Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенцид: Гаалийн зөрчил нь гаалийн хуулийг зөрчсөн, эсхүл зөрчихийг завдсан аливаа үйлдэл гэж заажээ.¹¹⁸

¹¹⁷ <http://www.ecustoms.mn>

¹¹⁸ Конвенци гэдэг нь: Аль нэг олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон /гарын үсэг зурсан батламжилсан/ улс орнууд заавал дагаж мөрдөх ёстой олон улсын эрх зүйн баримт бичгүүд /гэрээнүүд/ юм. Конвенци нь Гаалын хамтын ажиллагааны

Гаалийн зөрчлөөс сэргийлэх түүнийг мөрдөн шалгах, таслан зогсоох талаар захиргааны журмаар харилцан туслах Найрбын олон улсын конвенцид: Гаалийн зөрчил гэдэг нь гаалийн хуулийг зөрчсөн зарчихийг завдсан үйлдэл, эс үйлдэл гэж заажээ.

Гаалийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагааны гол зорилго нь гаалийн хууль тогтоомжийн дагуу гаалийн байгууллагаас явуулах төрөл бүрийн хяналтын үйл ажиллагааны тусламжтайгаар түүний тогтоосон дүрэм журмыг гадаад худалдаанд оролцогч иргэд, аж ахуйн байгууллагаар мөрдүүлэх, тэдэнд хөнгөн шуурхай үйлчлэхэд оршино.¹¹⁹ Гаалийн шалгалтын гол зорилго нь гаалийн хилээр бараа тээврийн хэрэгслийг хуулийн дагуу нэвтрүүлэх, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг илрүүлэх, түүнийг хууль бусаар нэвтрүүлэхээс сэргийлэх, гаалийн хилээр холбогдох бичиг баримтгүй нэвтрүүлж байгаа бараа, тээврийн хэрэгслийг илрүүлэх, барааны үнэ, чанар, тоо хэмжээ болон БТКУС-н /барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем/ дагуу барааг тодорхойлоход оршино.¹²⁰

Гаалийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагаа нь гаалийн эрх зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг олж илрүүлэх үйл ажиллагааны томоохон хэсэг юм. Хяналт шалгалт хийснээр улсын хилээр хууль бусаар бараа тээвэр нэвтрүүлэх, хориглосон болон хязгаарласан бараа оруулж ирэх гэх мэт үйлдлүүдийг тухайн үед нь барьж илрүүлэх үйл ажиллагаа болж байдаг.

Дээрхээс үзэхэд гаалийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагаа нь гаалийн зөрчлийг илрүүлэх арга зам болж өгдөг ба гаалийн хяналт болон шалгалтын хэлбэрээр илэрнэ. Энэ нь улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг илрүүлэх, түүнийг хууль бусаар нэвтрүүлэхээс сэргийлэх, гаалийн хилээр холбогдох бичиг баримтгүй нэвтрүүлж байгаа бараа, тээврийн хэрэгслийг илрүүлэх гэх мэт гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд нягт уялдаа холбоо болж өгч байна.

Тиймээс гаалийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагааг боловсронгуй болгох үүднээс гаалийн зөрчлийн гадаад худалдааны нийт эргэлтийн судалгааг гаалийн байгууллагад тулгамдаж буй асуудлыг тодруулах зорилгоор гаалийн байцаагч нараас авсан судалгаатай харьцуулж дүгнэлт гаргахыг зорьлоо.

Эхлээд гадаад худалдаа, гаалийн статистикийн 2009-2012 оны тоо баримт, мэдээ, мэдээллийг үндэслэн авч үзье.

Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлт, түүний дотор экспорт, импортын хэмжээ сүүлийн дөрвөн жилд маш хурдацтай өссөн. Энэ хурдацтай өсөлт нь гаалийн татвараас зайлсхийх зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, хэлбэрийг шинэчлэх шаардлагыг бий болгож байна. Гадаад худалдааны нийт эргэлт /мян.ам.долл./¹²¹

Харгалзах үзүүлэлт	2009 он	2010 он	Өөрчлөлт хувиар	2011 он	Өөрчлөлт хувиар	2012 он
Экспорт	1 885.4	2 908.5	154.3	4 817.5	165.6	4 384.6
Импорт	2 137.7	3 200.1	149.7	6 598.3	206.2	6 738.3
Нийт эргэлт	4 023.1	6 108.6	151.8	11 415.9	186.9	11122,9

Дээрх хүснэгтэд тооцоо хийж үзвэл 2009-2012 онд гадаад худалдааны нийт эргэлт 2.84, түүний дотор, экспорт 2.56; импорт 3.09 дахин нэмэгджээ.

Гадаад худалдааны эргэлтийг өмнөх онтой харьцуулбал экспорт буурч, импорт өссөн үзүүлэлт харагдаж байна.

Гаалийн харилцаанд оролцогч (мян.)

	2009 он	2010 он	Өөрчлөлт	2011 он	Өөрчлөлт
Иргэн	5 420	6 395	+975	10 779	+4 384

зөвлөлөөс батлан гаргадаг хамгийн чухал бичиг баримт болно. Энэ зөвлөл байгуулагдсанаас хойш 18 Конвенци батлаад байна.

¹¹⁹ Ш.Цогтоо. Гаалийн эрх зүй ерөнхий ба тусгай анги. УБ., 2003 он, 241-р тал

¹²⁰ ГЕГ- гаалийн хяналт шалгалт иргэдэд мэдээлэх хэсэг

¹²¹ Гаалийн ерөнхий газар. Статистик мэдээлэл.

Хуулийн этгээд	5 099	5 329	+230	6 366	+1 037
Нийт	10 519	11 724	+1 205	17 145	+5 421

Дээрх хүснэгтээс харахад, 2009-2011 онд гаалийн бүрдүүлэлт хийсэн иргэн 5359, хуулийн этгээд 1267-оор нэмэгдсэн нь 2009 онтой харьцуулахад иргэний эзлэх хувийн жин 49.7%, хуулийн этгээдийнх 19.9% болж өссөн байна.

Хүснэгтээс үзэхэд 2009-2011 онд гаалийн харилцаанд оролцогч иргэний хувийн жин 11.4 хувиар нэмэгдэж, тэр хэмжээгээр хуулийн этгээдийн хувийн жин буурсан байна. 2011 оны байдлаар гаалийн харилцаанд оролцогчдын 62.9 хувийг иргэн эзэлж байна.

Дээрх статистик мэдээнд тулгуурлан дүгнэлт хийхэд гаалийн харилцаанд оролцогчийн тооны огцом өсөлт, хувийн жинд өөрчлөлт орж байгаа нь гаалийн татвараас зайлсхийх зөрчил өсөх магадлалтай байгааг харуулж байна.

Зөрчлийн мэдээ

он	Нийт зөрчил	Гаалийн татвараас зайлсхийх зөрчил	Нийт зөрчилд эзлэх хувийн жин	Санаатайгаар		Болгоомжгүйгээр	
				тоо	хувь	тоо	хувь
2009	3006	517	17.1	363	70.2	154	29.8
2010	2875	589	20.5	409	69.4	180	30.6
2011	3254	618	19.0	418	67.6	200	32.4
2012	3198	106	33,3	-	-	-	-

Нийт хэрэг зөрчлийн дийлэнх нь гаалийн үнэ, барааны тоо хэмжээ, гаалийн бүрдүүлэлтийн горим, барааны нэр төрөл, марк зориулалт, гарал үүслийг худал мэдүүлэх, гаалийн баримт бичгийг солих, засварлах зэрэг аргаар гаалийн болон бусад төрлийн татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн үйлдэл эс үйлдэхүй үйлдэгдсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 2012 онд зөрчлийн тоо 1,7 хувиар буурсан боловч гаалийн татвараас зайлсхийх үйлдэл 42 хувиар өсчээ.

2009- 2012 оны Гэмт хэргийн шинжтэй зөрчил:

	2009 он	2010 он	2011 он	2012 он
Гэмт хэргийн шинжтэй үйлдэл	112	85	89	49

Гадаад худалдаа болон гаалийн харилцаанд оролцогчдын тоо хэмжээ өсөн нэмэгдэхийн хэрээр зохион байгуулалттай, шинэ төрлийн зөрчил нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.


Торгууль, нөхөн төлүүлсэн татварын (сая.төг)

	Санаатайгаар		Болгоомжгүйгээр	
	Торгуулийн дүн	Нөхөн төлүүлсэн	Торгуулийн дүн	Нөхөн төлүүлсэн
2009	91.9	306.3	41.8	139.3
2010	108.0	360.0	60.3	201.0
2011	184.5	615.0	83.7	278.9
2012	356.6	-	-	-

Эндээс харахад, нийт торгуулийн дүнгийн 67.4 хувь нь санаатайгаар зайлсхийсэн гаалийн орлогын татвар, 32.6 хувь нь болгоомжгүйгээр зайлсхийсэн үйлдэл болж байна. Гаалийн татвараас зайлсхийсэн зөрчлийг хянан шийдвэрлэснээр улсын төсөвт нэмж 2.5 тэрбум төгрөг нөхөн төвлөрүүлсэн байна.

Гаалийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг үнэн бодитой тодорхойлох, гаалийн байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журам, тушаал, заавар амьдралд хэр нийцэж, чухамхүү аль заалтууд хүнд суртал, чирэгдэл, авлига үүсэх нөхцөл бүрдүүлж байгааг тодруулах зорилгоор практикт ажиллаж буй 120 алба хаагчаас авсан судалгааны дүнг танилцуулъя.


1. Та гаалийн байгууллагад хэдэн жил ажиллаж байна вэ?



2. Та бүхний мөрдөн хэрэгжүүлдэг ямар хууль, дүрэм, журмын аль заалтууд амьдралд нийцдэггүйг доорхи зайд нэрлэн бичнэ үү.

- Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох Засгийн газрын 63 дугаар тогтоол, Монгол Улсын Гаалийн ерөнхий газраас улирал бүр гаргадаг гаалийн үнийн бааз, Зорчигчийн журам амьдралд нийцдэггүй
- Барааны үнэлгээ хэт өндөр байдаг
- Импортын бараанд Засгийн газрын 63 дугаар тогтоол, Гаалийн тарифын хуулийн дагуу гаалийн үнийг тодорхойлох явцад Гаалийн ерөнхий газраас тогтоосон импортын барааны жишиг үнийн жагсаалт зарим нэрийн бараанд хэт өндөр үнээр тавигдсан байдаг нь хүндрэлтэй байдаг.
- Солонгос болон бусад улсаас “Карго” нэрээр газраар оруулж ирж байгаа ачаа, түүнд хийх гаалийн бүрдүүлэлт, тавих хяналт шалгалт амьдралд ер нийцэхгүй байна.
- 170 гаруй журмын 50 хувь нь бүрэн хэрэгжихгүй байна.
- Татварын аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтүүд
- Шударга ёс хэрэгжүүлэх тухай их ярьдаг боловч, удирдах дээд байгууллагаас асуудалд эсрэгээр ханддаг
- Гаалийн урьдчилсан бүрдүүлэлт хийх тухай журам
- Гаалийн тухай хууль
- ТАХТХ-ийн заалт, ГТХ-ийн 74, 82, 84 дүгээр заалт, Төрийн албаны тухай хууль
- Татварын хувь хэмжээ их /онцгой, НӨТ/
- Гаалийн тухай хуулийн 1-р бүлэг 3-17,18
- Төрийн албаны хуулийн төрийн жинхэнэ албан хаагчийн ажилд шалгаруулж авах заалт
- Илгээмжийн журам/ ДБЯ-тай хамтарсан
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль
- Эм, эмийн зүйлс улсын хилээр нэвтрүүлэх журам
- Онцгой албан татварын тухай хууль ба автомашины татвар
- Гаалийн ерөнхий газрын зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлсэд бүрдүүлэлт хийх журам
- Гаалийн хяналт шалгалт шалгалт хийх Гаалийн ерөнхий газрын даргын 50 дугаар тушаал
- Гаалийн тухай хуулийн гаалийн улсын байцаагчдын эрх ашгийг хамгаалах заалтууд
- 1999, 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгох

3. Танай байгууллагаар үйлчлүүлдэг иргэдээс хэр их гомдол ирдэг вэ?



4.Танай байгууллагын удирдлагын ажлын буруу зохион байгуулалт, зохисгүй шийдвэр, арга барилын дутагдлаас болж шүүмжлэгдэхэд хүргэдэг бол доорхи зайд бичнэ үү.


- Удирдлага нь намын харъяаллын бус мэргэшсэн байх
- Зарим хууль тогтоомжийн актуудыг тодорхой болгон, шинээр гарах тухай бүр нэгдсэн ойлголт өгч байх
- Удирдлага гаалийн улсын байцаагч бүртэй тулж ажилладаггүй
- Ажлын зохион байгуулалт нүсэр, зарим зохисгүй шийдвэр нь үйлчлүүлэгчдийг бухимдуулах, цөхрөөх, барьцах, шударга ёс алдагдахад хүргэдэг ба ажлын арга барил хоцрогдсон, боловсон хүчний чадвар доройтсон
- Удирдлагаас боловсон хүчний бодлогыг буруу явуулдаг, намчирхдаг, ах дүү, садан төрөл, найз нөхдөө ахлахын албан тушаалд тавьдаг, гадаадад явуулдаг бөгөөд шагнал урамшил, цолыг олгохдоо шударга бус ажилладаг
- Дунд шатны ажилтнууд үүрэгт ажлаа дутуу дулимаг гүйцэтгэдгээс үйлчлүүлэгчдэд чирэгдэл гаргаж хүндрүүлдэг
- Удирдлагын шударга бус үйл ажиллагаа, давхар шалгалт
- Ажилчдын нийгмийн халамжинд анхаарах
- Хэлтэс албадын дарга нарын ур чадвар муу, нэгжийн ахлах дарга нар шийдвэр гаргаж чаддаггүй
- Шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналт муу
- Цохолт хийн шийдвэрлэх зүйл заалтыг тодорхой болгох
- Ажлын байрны зохицуулалт, байршил муу
- Удирдлага нь улс төрөөс хараат байдаг, асуудлыг удаан шийдвэрлэдэг, шат дамжлага олон
- Зарим иргэд, үйлчлүүлэгчдийн шударга бус буруу ташаа мэдээлэлд зөвхөн нэг талаас ханддаг

5. Таны гаалийн үзлэг, шалгалт хийх явцад чухамхүү ямар төрлийн эд барааг нуун далдалж хил нэвтрүүлэх оролдлого олонтоо гарч буйг доорхи зайд бичнэ үү.

- Тоо хэмжээ дарах, үнэ дарах тохиолдол байд
- Өндөр татвартай /онцгой буюу экспортын татвар/ архи, согтууруулах ундаа, ноос, ноолуур гэх мэт
- Гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн татвар багассан тул ерөнхийдөө ийм оролдлого багассан
- Татвар шингэсэн бараа
- Гаалийн үнэлгээ бага бол ямар ч бараа байж болно
- Карго ачаанд үзлэг хийхэд тоо ширхэг, жин байнга зөрдөг
- Татвараас зайлсхийх явдал байнга гардаг
- Автомашины сэлбэг
- Өндөр үнэтэй бараа
- Шалгалт сайн хийхгүй бол ямарч барааг нууж гаргаж болно
- Алт, үнэт эдлэл, ноолуур
- Гоо сайхны бараа, овор бага үнэ ихтэй бараа гэр ахуйн хэрэглээны хуучин эд зүйлс
- Бичиг баримт хуурамч
- Эм, эмнэлэгийн багаж хэрэгсэл, тамхи, хятадаас импортлосон хулдаас, дэвсгэр, барилгын материал

- Элдэв лиценз зөвшөөрөлтэй бараа
- Гүний гаальд нуун далдлах оролдлого бараг гардаггүй
- Хязгаарласан хориотой бараа
- Ангийн арьс, гар утас
- Гахай, тахианы мах, өөх
- Түүх соёлын дурсгалт зүйлс
- Эмийн найрлагад ордог амьтны гаралтай түүхий эд /бугын чив засаа, доньд гэх мэт/
- Химийн бодис
- Мотоцикл
- Гадаадаас ирж байгаа бичиг баримт дээр дурдагдаагүй барааг мэдүүлэхгүй гаргах оролдлого хааяа гардаг


6.Таны бодлоор гаалийн татварын үнэлгээ хэр бодитой байдаг вэ?




7. Хэрэв гаалийн татвар, хураамж бодитой бус бол чухамхүү ямар эд барааны үнэ бодитой бус буюу хэт их байдаг талаар баримт дурдан бичнэ үү.

- Суудлын авто машины 1501-2500 шоо метр цилиндрийн багтаамжтай машины татвар
- Тоног төхөөрөмж, хүнд механизм, даавуун материал, хүнс, өргөн хэрэглээний бараа, барилгын материалын хийц төмөр бэлдмэл үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж
- Гаалийн жишиг үнэ хэт өндөр
- Цахилгаан бараа
- Айванхоу майнз ХХК зэрэг гадаадын хөрөнгө оруулалттай /тэр дундаа Хятадын/ аж ахуйн нэгжүүд татварын бараагаа хэт өндөр үнэлүүлж луйвар хийдэг
- Гадаадын хөрөнгө оруулалттай зарим аж ахуйн нэгжийн татвараас чөлөөлөгдсөн барааны үнэ хэт их байдаг. Ихэнх электрон барааны үнэ /жишээ нь: Номин, Элба гэх мэт/ маш багаар үнэлэгддэг
- Ахуйн хэрэглээний бараа /тавилга/
- Хятад улсаас орж ирж байгаа импортын барааны татвар их
- Гүний гаалийн үнэлгээтэй хилийн гаалийн зарим барааны үнэлгээ ижил байдаг нь буруу
- Импортын Солонгос, Япон улсаас оруулж ирж буй суудлын автомашиныг хэт өндөр үнээр үнэлдэг ба үйлдвэрлэлд 5-10 жил болсон автомашиныг 1500-3200 доллараар үнэлдэг

8. Таныг гаалийн татвар хураалтын төлөвлөгөө биелүүлсний тань төлөө шагналын фондоос хэдэн удаа урамшуулал олгож байсан бэ?



9.Таны үзлэг, хяналт шалгалт хийдэг ажлын байрыг ямар хугацаанд өөрчилдөг вэ?



10. Таныг өөрийн хариуцсан үүргээ гүйцэтгэх явцад дараах зүйлс тохиолдож байсан уу?

	Доорх хүмүүс	Хууль бус санал тавих		Дарамт, шахалт үзүүлэх	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Танд хандаж	Иргэд, үйлчлүүлэгчид	45 2.6%	38 3.1%	31 3.8%	47 2.5%
	Дээд албан тушаалтан	16 7.5%	57 2.1%	29 4.1%	50 2.4%
	Найз нөхөд, хамаатан садан, танил хүмүүс	20 6%	62 1.9%	6 20%	57 2.1%
	Хамт ажиллагсад	24 5%	58 2%	12 10%	52 2.3%
	Харилцагч байгууллагынхан	16 7.5%	57 2.01%	11 10.9%	53 2.2%
	Улс төрийн нам, бүлгийн гишүүд	4 30%	54 2.2%	8 15%	60 2%
	Бусад	5 24%	46 2.6%	9 13.3%	44 2.7%

Дэвшүүлж буй санал:

1. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох /Татварын эрх зүйн хууль тогтоомжийн уялдаа холбоо хангалтгүй, зарим зүйл заалтыг нийгмийн болон эдийн засгийн хөгжилтэй уялдуулан өөрчлөх шинэчлэх шаардлагатай, тухайлбал эрүүгийн хуулийн 166 зүйл, санаатай үйлдэл /

2. Гаалийн бүрдүүлэлт хийх явцад олон төрлийн татварыг нэг дор ногдуулан барагдуулж төвлөрүүлдэг байдлыг өөрчлөх шаардлагатай. Тухайлбал: Импортын гаалийн татвар, Экспортын татвар, Тусгай татвар /ямаа ишигний арьс/, НӨАТ, Онцгой албан татвар, Авто бензин дизелийн түлшний албан татвар, төрийн байгууллагын үйлчилгээ үзүүлсэний хураамж г/м/. Энэ нь болгоомжгүйгээр гаалийн зөрчил гаргах үндэс болж байна.

3. Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн код, горим, хөнгөлөлт чөлөөлөлтөд хамаарах барааны нэр төрөл, үзүүлэлт зориулалтыг зааж өгсөн эрх бүхий байгууллагын шийдвэр, тогтоол бодитой судалгаа шинжилгээнд үндэслэгдээгүй байдал, зарим төрлийн гаалийн татварын хувь хэмжээ оновчгүй, эсхүл өндөр хувь хэмжээтэй байгаа нь иргэдийн гаалийн татвараас зайлсхийх үйлдэл практик ажилтнуудаас авсан судалгаагаар нотлогдож байна. Иймээс татварын хувь хэмжээ болоод хөнгөлөлт чөлөөлөлтийн үндэслэлийг амьдралд нийцсэн хэрэгжих боломжтой болгох. Энэ нь гаалийн харилцаанд оролцогчдын хууль, эрх зүйн мэдлэг чадвар дутагдалтай байгаатай ч холбоотой.

4. Гаалийн байгууллага болон хууль хяналтын байгууллагуудын олон улсын худалдааны хөгжлийн чиг хандлага, нарийн технологи бүхий бараа тээврийн хэрэгслийг таниж мэдэхгүйн улмаас гаалийн зарчил үйлдэгдэж байна. Тухайлбал барилгын гадна шилэн фассат үүнийг шил гэж мэдүүлж бага татвар төлөх явдал гарч байсан. Гэтэл тэр нь сүүлийн үеийн технологиор боловсруулагдсан барилгын гадна талын хавтан юм. Барилгын гадна талын фассат гэдгээр нь мэдүүлбэл гаалийн татвар өндөр төлөхөөр байдаг учраас. Энэ нь гаалийн байцаагчийн мэдлэг туршлага дутмаг, Олон улсын худалдааны туршлага муу зэрэгтэй холбоотой билээ.

5. Солонгос болон бусад улсаас “Карго” нэрээр газраар оруулж ирж байгаа ачаа, түүнд хийх гаалийн бүрдүүлэлт, түүнд тавих хяналт шалгалт амьдралд нийцэхгүй байгаа нь харагдаж байна. Тиймээс хяналт шалгалт хийх журмаас эхлээд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Гаалийн зөрчил үйлдэгчдийн үйл ажиллагаа, бүтэц, арга хэлбэр улам нарийн зохион байгуулалтанд орж байгаа энэ үед дээр дурдсан шалтгаан нөхцлийг арилгах, үгүй болгох нь гаалийн хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх гол арга зам болно гэж үзэж байна.

ГАДААД ХЭЛИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Чагнаадоржийн Батчимэг

ХСИС-ийн ГХСТ-н ахлах багш, хэл шинжлэлийн
магистр, цагдаагийн ахлах дэслэгч

Нийтлэлийн агуулга:

Хөгжил даяаршлын асар их хурдацтай хөгжлийн үе болох өнөө үед гадаад хэлийг судалснаар гадаад ертөнцтэй харьцаж шинэ шинэ мэдээлэл авах зайлшгүй хэрэгцээ, шаардлага амьдралаас урган гарч байгаа билээ. Орчин үед гадаад хэлний мэдлэг өндөр байх шаардлага нийгмийн захиалга болоод байна.Тухайн суралцагчдад хамгийн түрүүнд гадаад хэл сурахын ач холбогдол хэрэгцээ шаардлагыг таниулах,хүсэл сонирхолыг нь бий болгох нь тэдний дотоод сэдлийг идэвхжүүлэн улмаар зорилгодоо хүрэх хүсэл эрмэлзэлд нь хөтлөх нь чухал .

Түлхүүр үгс:

Идэвхи чармаалт, урам зориг, сургалтын орчин, хэрэгцээ шаардлага, сэдэл тэмүүлэл.

Гадаад хэлийг заан сургаж байгаа багш тухайн суралцагчдынхаа нас,сэтгэхүйн онцлого, сурах сонирхол арга барил, орчин нөхцөлийг нь судалж гадаад хэл сурч эзэмшихэд нь тусалж дэмжиж байх хэрэгтэй

Аливаа гадаад хэлийг сурах нь 3-н түвшинд зохион байгуулагдаж байдаг бөгөөд их дээд сургуульд элсэн гадаад хэлний анхан шатны болон дунд шатны түвшиний мэдлэг эзэмшисэн суралцагчдад дараагийн шатны мэдлэг олгох буюу өөрөөр хэлбэл тухайн оюутны эзэмшиж байгаа мэргэжлийн хэлийг сургах зорилт тавигддаг.

Үүний дагуу гадаад хэлний багш нар хэрэглээний болон мэргэжлийн бичгийн ярианы хэлийг эзэмшүүлхийг зорьж ажилладаг.

Гэтэл их дээд сургуульд элсэгчдийн гадаад хэлний түвшин харилцан адилгүй. Тэр ч бүү хэл зарим сургуульд англи хэлийг огт үзээгүй орос хэл үзсэн гэх нөгөө хэсэг нь орос хэл огт үзээгүй байдаг нь багш нарт хүндрэлтэй байдаг ба элсэгчдээс авсан судалгаагаар 78.1% нь англи хэлний 22.9% нь орос хэлний анхан ба дунд шатны мэдлэгтэй болох нь харагдсан. Ийм тохиолдолд дунд сургуульд үзсэн хэлийг цааш үргэлжлүүлэн заана гэхээр зарим нэг их дээд сургуульд аль нэг буюу зөвхөн англи хэлийг зааж байгаа нь учир дутагдалтай байдаг.

Гадаад хэлийг мэргэжил болгон эзэмших өөрөөр хэлбэл амьдралын эх үүсвэр болгох асуудал нь төрөлжсөн сургалт өөрийн стандарт агууламж сургалтын технологи бүхий боловсролын цогц тогтолцооны асуудал юм.

Гадаад хэлийг сурах өөр нэг түвшиний хувьд мэргэжлийн ажилчин, эмч, инженер хэнч байсан тухайн хэлийг мэдлэгийн түлхүүр болгох зорилгоор сурч эзэмших асуудал нь академич Б.Энхтүвшингийн тэмдэглэснээр соёлжсон ертөнцийн нэгэн гол үнэлэмж байх нь гарцаагүй юм.

Энэ л үүднээс гадаад хэлийг хэрэглээгээ болгон судалдаг. Гэхдээ энэ шаардлагад нийцэхийн тулд хүн хэл шинжээч байх албагүй ээ. Харин хүмүүс зохих түвшинд харилцан ярилцаж өөрийн бодлоо илэрхийлж мэргэжлийнхээ судалгааны чиглэлээр мэдээллийг олж хэрэгцээгээ хангах түвшинг гол болгох хэрэгтэй.

Иймд гадаад хэлний хичээлээр суралцагч оюутны хоцрогдол, түвшингийн ялгааг арилгах, тухайн хичээлээр мэргэжлийн үг хэллэгийг эзэмшүүлж, мэргэжлийн ном зохиол ашиглаж сургах, дүрмийн тодорхой мэдлэгийг эзэмшүүлэх, ярих чадварыг хөгжүүлэхэд анхаарч тухайн хичээл бүрт ярианы дадлага хийлгэх сургалтын идэвхитэй аргуудыг хэрэглэх, сургалтын техник хэрэгсэлийг ашиглах зэрэг нь гадаад хэлний сургалтыг сайжруулахад дөхөмтэй ажиллагаа болох нь сургалтын явцаас харагдаж байдаг.

Гадаад хэлний сургалтын явцаас дүгнэлт хийн цаашид анхаарч ажиллах дараах хүчин зүйлүүдээс дурьдвал:

- Хэлний бус орчинд гадаад хэл сурахад анхаарах ёстой зүйл бол ярих чадварыг хөгжүүлж, ярианы дадлага эзэмшүүлэх
- Ярианы дадлага эзэмшүүлэх цаг тусгайлан гаргаж дугуйлан хичээллүүлэх
- Гадаад хэлний багш нар тасралтгүй хөгжиж байх шаардлагатай тул багшийн мэргэжил дээшлүүлэхэд анхаарах

- Сургалтын орчинг бүрдүүлж, хэлний хичээлийн лаборотори кабинетаар хангах, техник хэрэгсэл сургалтанд тогтмол хэрэглэх

Нөгөө талаар гадаад хэлний сургалт нь сургах, сурч судлах 2 талын хамтын ажиллагаанд тулгуурлан гадаад хэлний сургалтыг идэвхижүүлэх арга замыг оновчтой хэрэглэснээр суралцагчдын сэтгэхүй хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэх олон хувилбарт арга барилд суралцах нөхцөлийг бүрдүүлдэг.

Гадаад хэлний сургалтыг идэвхижүүлэх хүчин зүйлс нь багшийн заах арга зүйгээс гадна суралцагсдын сэдэл тэмүүлэл, сонирхол хэрэгцээг өрнүүлэх нь чухал юм. Гадаад хэлний сургалтанд тухайн хичээлдээ төрөлх хэлнийхээ бүтэц тогтолцоо утгыг, зааж буй гадаад хэлнийхээ бүтэц тогтолцоо утгатай харьцуулан тайлбарлах нь суралцагсдад ойлгоход дөхөмтэй.

Гадаад хэлний бүтээх сургалтын явцад оюутан сонсогчдын гол үйл ажиллагаа нь хэрэглээний болон мэргэжлийн холбогдолтой шинэ мэдлэг, мэдээ, мэдээлэл хуримтлуулах чадвар эзэмшүүлэх сэтгэлгээний шинэ хэв маяг төлөвшүүлэх үйл явц юм.

Танин мэдэх үйл явцын ерөнхий зүй тогтолзыг гадаад хэлний сургалтанд хэрэгжүүлэх боломжтой. Жишээлбэл: Анги танхимд эзэмшиж ойлгосон мэдлэг туршлага хэл сэтгэхүйн үйлд ашиглан хэл ярианы мэдлэг бүтээх хэрэглээ болгоход танин мэдэх ажиллагаа чухал юм. Гадаад хэлний сургалтаар олсон мэдлэг ухагдахуунаа хэрэгжүүлэх бие даасан танин мэдэх үйл ажиллагаа чухал шаардлагатай болоод байна.

Оюутан сонсогчид гадаад хэлээр бэлтгэлд бэлтгэх илтгэх урлагийн арга барил эзэмших гадаад дуу шүлэг сурах уралдаан тэмцээнд оролцож танин мэдэх хэрэглээний сэдэл тэмүүлэлтэй болсоор байгаа.

Гадаад хэлний сургалтаар суралцагсдын сэтгэхүйг хөгжүүлэн идвэхийг өрнүүлэх бас нэг хүчэн зүйл нь тэднийг сурах үйл ажилгаанд өдөөж нөлөөлж байдаг сургалтийн орчин нөхцөлийг бүрдүүлэх явдал юм.

Учир нь гадаад хэлний хичээл бол тухайн хэлээр харилцах парагматик орчин болдог иймээс гадаад хэлний хичээлээр суралцагсдын сонсох бичих унших ярих чадваруудыг хөгжүүлэн хэрэглээ сонирхолд нийцсэн бодит үзүүлэн кино, техник хэрэгсэл төрөл бүрийн сургалтанд идвэхтэй аргуудийг хэрэглэх нь чухал юм. Учир нь гадаад хэлний сургалтанд материаллаг хэлбэрийг хэрэглэх нь түүгээр дамжиж материаллаг юмстай харилцан бие даан гадаад хэлээх ярилцах харилцаанд орлцох боломж бий болдог.

Гадаад хэлний сургалтаар суралцагсдийн бие даан гүйцэтгэж байгаа үйлдэл үйл ажиллганы үр дүн тэдний ихэнх оролцоог хамтран хэлэлцэн урашуулан дэмжих замаар гадаад хэлийг аль болох тэдний сонирхол хэрэглээнд ойртуулан сурч эзэмших хүсэл тэмүүллийг нь өрнүүлэх шаардлагатай.

Монгол улсын иргэд хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэмд өөрийгөө бүрэн дүүрэн мэдрүүлэн амьдрах ажиллахад шаардагдах мэдлэг, чадвар, технологи соёл эзэмших, сонгох таатай орчин бүрдүүлэхэд боловсорлын эрхэм зорилго оршино гэж боловсролын талаарх үндсэн баримт бичигт заасан билээ. Энэхүү таатай орчинг:

- Материаллаг орчин
- Сэтгэл зүйн орчин
- Бүтээлч үйлийн орчин гэж ангилж болох юм.

Гадаад хэлний сургалтаар оюутан сонсогчдыг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулахдаа тэдний нас, хүйс, мэргэжил, дадлага, туршлага, авьяас сонирхолыг нь тооцож байх нь зүйтэй юм.

Энд тухайн сургууль, багшийн онцлогоос хамаарч уг асуудалд ихээхэн уян хатан хандаж байх нь ойлгомжтой. Эндээс гадаад хэлээс харилцах, бүтээлч үйлийн орчин нь багш сонсогчдын хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай орчин болно. Суралцагч ба багш нарын аль нь ч сэтгэл санаа оюун ухааны тодорхой эрч хүчтэй байдаг. Эдгээр нь гадаад хэлийг сурч буй хүний дотоод нөөц болдог. Дотоод нөөцийг бүтээх чадавхи нь нийгмийн шавхагдашгүй баялаг болдог.

Дүгнэлт

Иймээс гадаад хэлний сургалтын үйл ажиллагааны гол хүчин болсон оюутан сонсогчдыг хөгжүүлэх сургалтанд дараах хэд хэдэн зарчмыг баримталдаг.

- Багш нар өөрсдөө тодорхойлж гаргасан хариулт. Шаардлагатай байгаа асуудлыг хөндөх
- Гадаад хэлний сургалтанд шийдвэрлэх асуудлыг тавьж шийдэлд хүргэхэд нөлөөлөх арга бариллыг боловсруулах

- Гадаад хэлний багш нарын сургалтын үйл ажиллагаанд хэрэгжиж буй шинэлэг дэвшилтэд арга барилыг хэрэглэх
- Шаардлагатай мэдээлэл арга зүйгээр хангах
- Орчин үеийн техник хэрэгслийг ашиглах гэх мэт болно.

Эцэст нь дүгнэхэд суралцагчид нь гадаад хэлний сургалтаар хөгжиж байх чухал хүчин зүйл нь хэлний харилцааны хэрэглээний бүтээлч орчинг бүрдүүлэн ажиллах ба суралцагсадынхаа идэвх чармайлтыг урамшуулан дэмжих нь явдал юм.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МАШИНТ ЭРГҮҮЛИЙГ АШИГЛАЖ БАЙГАА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

Сүхбаатарын Аринунбаяр

СХД-ийн Цагдаагийн I-р хэлтсийн хэсгийн
байцаагч, магистр, цагдаагийн ахлах дэслэгч

Өнөөдөр цагдаагийн эргүүлийг, байнгын шуурхай удирдлагаар хангах чиг үүргийг ч шуурхай удирдлагын алба биелүүлж байна. Энэ алба нь, эргүүлийн үүрэг гүйцэтгэхийн өмнө албаны бэлэн байдлыг шалгаж, зааварчлахаас гадна, үүрэг гүйцэтгэх явцад зохих хяналтыг хэрэгжүүлэн, эргүүлийн чиглэлд бий болсон хэв журмын нөхцөл байдлаас хамаарч, бусад албадын харилцан хамтын ажиллагааг хангаж, нэмэлт хүч хэрэгслийн туслалцаа дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авдаг юм.

Түүнчлэн эргүүлийн үйл ажиллагааны нэг онцлог нь, зам тээврийн салбарт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тусгайлсан үүргийг хэрэгжүүлэн биелүүлэх явдал юм. Замын цагдаагийн эргүүл нь, тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнд хяналт тавих, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган биелүүлэх явдал юм.

Хэв журмын албаны эргүүлийн үйл ажиллагааны онцлог, чиг үүрэг нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд голлох байр суурийг эзэлж, цар хүрээ нь өргөн болох нь тодорхой байна.

Эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдал нь хэв журмын албаны ажлын зохион байгуулалтанд шууд нөлөөлөх хүчин зүйл болно.

Цагдаагийн байгууллага эргүүлийн үйл ажиллагааг Хөдөлгөөнт /машин/, Явган, Мотоцикль, Нохой, Морьт хэлбэрээр эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, хүн амын нягтрал, хөдөлгөөн, бий болсон цаг үеийн нөхцөл байдалд зохицуулан гүйцэтгэж иржээ.

Цагдаагийн эргүүлийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой эрх зүйн актуудыг мөрдөж, хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ “Хөдөлгөөнт эргүүл ажиллах заавар”, “Дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн кабонд ажиллах заавар”-ыг ЦЕГ-ын дэд даргаар батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байжээ.

Нэг чиглэлд офицер 4, цагдаа-жолооч 4, нийт 8 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй, 3-4 ээлжтэйгээр 24 цагаар тасралтгүй үүрэг гүйцэтгэж байсан байна. Чиглэлд ажиллах алба хаагчдын сэтгэл зүйн байдалд үнэлэлт, дүгнэлт өгсөний үндсэн дээр, темпераментийн хослолыг бүрдүүлж, хамтрагч нарыг томилж байжээ.

Техник, хэрэгслийн хувьд: Автомашины суурин станц 1, гар станц 1, бугуйн гав, цахилгаан бороохой 1, резин бороохой 1, хутганаас хамгаалах хантааз 2, проектор 1, согтуурал хэмжигч 1, гэрэлтдэг хантааз 2, хөтлөгдвөл зохих баримт бичиг: Рапортын дэвтэр, Гэмт хэрэг, зөрчлийн дуудлагын бүртгэл, Зарлан мэдээллийн дэвтэр, Захиргааны зөрчлийн бүртгэл, Объектийн судалгаа, Үзлэгийн тэмдэглэл, Зайны сургалтын хавтас зэрэг бүрдэлтэй байхаар зохицуулалт хийсэн байна.

Хөдөлгөөнт буюу машинт эргүүлийг удирдах удирдлага нь гудамж талбай, олон нийтийн газар, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход машинт эргүүлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, хяналт шалгалтыг давхар гүйцэтгүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх явдлаар хангагдана.

Тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсийн даргаас эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлан үнэлж, хөдөлгөөнт эргүүлийг зохион байгуулах талаар гаргасан шийдвэр нь уг эргүүлийг удирдах удирдлагын үндэс болно.

Өнөөдөр хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа машинт эргүүлийн офицер, ахлагч нарт маш олон хүндрэл учирч байдаг.

Машинт эргүүлийн чиглэлд үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нар нь үүрэг гүйцэтгэх хугацаандаа ихэвчлэн захиргааны зөрчил, тогтоосон журам зөрчсөн үйлдлийн тухай дуудлага хүлээн авч шалган шийдвэрлэдэг.

Зарим тохиолдолд гэмт хэргийн тухай дуудлагыг хүлээн авч, хэргийн газар хамгийн түрүүн очиж, хэргийн газрыг хамгаалалтанд авч, гэмт хэрэг, зөрчлийн тухай эрэн сурвалжлах хойшлуулшгүй ажиллагаа явуулж байна.

Машинт эргүүлийн офицер, ахлагч нар захиргааны тогтоосон журам зөрчиж зөрчил гаргасан иргэдэд торгуулийн арга хэмжээ авах эрх нь байдаг хэдий боловч эргүүлийн офицер нь эргүүлийн цагдаагийн адил хэмжээнд торгуулийн арга хэмжээ авах эрхтэй байдаг байна.

Учир нь эргүүлийн офицерийн торгох торгуулийн арга хэмжээний дээд хязгаар нь 1000-5000 төгрөг торгуулийн арга хэмжээ авдаг. Иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг шийтгэвэрээр торгох гэхээр торгох эрх нь эргүүлийн офицерт байдаггүй байна.

Энэ нь, эргүүлийн офицерийн гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хийх, нөгөө талаар захиргааны тогтоосон хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавихад учирч байгаа нэг том хүндрэл бэрхшээл юм.

Түүнчлэн Монгол Улсын Хөдөлмөрийн хуулиар 24 цагийн үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагч 72 цаг амрах ёстой байдаг боловч өнөөгийн нөхцөлд энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд амраадаггүй, амрах нөхцөл боломжоор тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хангадаггүй.

Өвлийн улиралд 24 цаг ажиллаад 72 цаг амрах, зуны улиралд 24 цаг үүрэг гүйцэтгээд 48 цаг амрахаар зохицуулагдаж байна. Энэ нь Нийслэлийн ХЭГ-т ажиллах хугацаанд 24 цаг үүрэг гүйцэтгээд 72 цаг амрах боломжоор тодорхой хэмжээгээр хангаж чадаж байсан.

Гэтэл, цагдаагийн байгууллагын шинэчлэлийн бодлогын хүрээнд дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн хэв журмын тасагт хувиарлагдан очсон хөдөлгөөнт эргүүлийн офицер, ахлагч нар өнөөдрийн байдлаар 24 цагийн үүрэг гүйцэтгээд тухайн ээлжээс буусан өдрөө амардаг боловч амарсаны маргааш нь 6 цагийн явган эргүүлийн үүрэг гүйцэтгэх үүргийг давхар хүлээж байна. Энэ нь тэдний ажил үүрэг гүйцэтгэлийн чанар, үр дүнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Учир нь оройн 17 цагаас оройн 23 цаг хүртэл үүрэг гүйцэтгээд маргааш өглөө нь бүтэн 24 цагийн турш өөрсдийн хариуцсан нутаг дэвсгэрт машинт эргүүлийн үүрэг гүйцэтгэхээр тэдний үүрэг гүйцэтгэх чадвар тодорхой хэмжээгээр буурах, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх, залхах нөхцөл бүрддэг байна.

Машинт эргүүлд үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нар өвлийн улиралд хүйтэн машинд 24 цаг үүрэг гүйцэтгэдэг, энэ хугацаанд даарч эрүүл мэндээрээ байнга хохирч байдаг байна.

Учир нь, авто машиныг байнгын ажиллагаатай байлгаж, дулаан байх гэхээр тухайн хоногийн хугацаанд үүрэг гүйцэтгэхэд зориулан олгож байгаа шатахууны хүрэлцээ хангалттай олгогддоггүйгээс машинаа тодорхой хугацаанд унтрааж, түлшээ хэмнэх хэрэгтэй болдог бөгөөд энэ нь машинт эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нарт тулгарч байдаг 2 дахь хүндрэл бэрхшээл юм.

Машинт эргүүлийн машинд өвлийн улиралд хоногт 12-14 литр шатахуун, зуны улиралд 7-9 литр шатахуун олгох нормтой байдаг байна. Энэ нь бодит байдалтай нийцдэггүй, гэмт хэрэг, захиргааны зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд хаанаа ч хүрдэггүй байна.

Мөн, авто машины парк шинэчлэлт нэн түрүүнд хийх шаардлагатай байна. 2008 онд Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газарт нийлүүлэгдсэн БНСУ-ын HUNDAI үйлдвэрт үйлдвэрлэсэн Аксент маркийн 50 авто машин нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, захиргааны зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 24 цагийн турш зогсолтгүй ажилласнаар моторын үйл ажиллагаанд нь эвдрэл гэмтэл их гардаг байна.

Энэ машины тасралтгүй ажиллах хугацааг нь, энгийн хүний унаж байгаа автомашинтай харицуулахад 10 жил явсан автомашинтай адил хэмжээнд ажилласан байдаг нь маш их ачаалалтай ажилладаг болох нь харагдаж байна.

Мөн тус автомашин нь БНХАУ-д үйлдвэрлэгдсэн автомашин учир битүүмжлэл маш муутай, дотор салонд дуу чимээ маш хурдан ордог, эд анги нь хэврэг тул тогтоосон стандарт шаардлага хангадаггүй байна.

Түүнээс гадна, 24 цагийн хугацаанд үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн офицер, ахлагч нарт олгогддог хоолны мөнгө 2300 төгрөг байдаг нь одоогийн зах зээлийн ханшаар хангалттай хүнсний бүтээгдэхүүн авах боломжгүй байгаа нь одоогийн тулгамдаж байгаа асуудлын нэг юм.

Нөгөө талаар, ажил үүргийн давхардал Нийслэлийн Хөдөлгөөнт эргүүлийн газар байхад байдаг байжээ. Тухайлбал Мэдээлэл Шуурхай Удирдлагын төвөөс ирж байгаа дуудлага мэдээлэлийг чиглэлд үүрэг гүйцэтгэж машинт эргүүлийн байгаа алба хаагч нар хүлээн аваад гэмт хэрэг, зөрчлийн газарт шуурхай очдог боловч тухайн дуудлаганд харъяа дүүргийн цагдаагийн хэлтсийн шуурхай удирдлагын үзлэг багтай давхардаж очиж байдаг тул энэ давхардсан дуудлаганд очсон автомашины шатахуун үргүй зардал гарч байдаг байна.

Авто машин бүрт олгогдож байгаа тусгай хэрэгсэл нь, олон улсын стандартад нийцэхгүй техник хэрэгсэл байдаг. Энэ тусгай хэрэгсэлийг цагдаагийн алба хаагч захиргааны зөрчил гаргасан иргэнд хэрэглэхэд иргэдийн бие эд эрхтэнд тодорхой хохирол учруулж, алба хаагч нарт эргээд хариуцлага тооцогдоход хүрдэг.

Эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хувцасны хангалт нормыг бусад төрөл мэрэгжилийн алба хаагч нараас норм хугацааг нь богиносгож олгуулж байх ч шаардлагатай.

Учир нь гудамж талбай, олон нийтийн газар машинт эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хувцас форм нь нарны гэрэл, цас бороо, салхинд гандаж өнгө үзэмж нь, конторт сууж үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдаас түрүүлж муудаж, өнгө үзэмж муутай болсон байдаг нь иргэд, олон нийттэй хамгийн их харьцдаг алба хаагчдын гадаад хувцаслалтанд анхаарах цаг болсныг харуулж байна.

Түүнчлэн 24 цагийн хугацаанд хөдөлгөөнт буюу машинт эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа офицер, ахлагч нар Мэдээлэл Шуурхай Удирдлагын төв болон харьяа дүүргийн цагдаагийн хэлтсээс ирж байгаа нийт гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээлэлийн 60-70 хувийг хүлээн авч шийдвэрлэдэг байсан.

Өнөөдрийн байдлаар, хөдөлгөөнт эргүүлийн машинууд нь дүүргийн цагдаагийн хэлтсийн мэдэлд шилжин очсоноос хойш ажлын ачаалал нэмэгдэж нийт дуудлага мэдээлэлийн 80-90 хувийг хүлээн авч шийдвэрлэдэг болсон бөгөөд хоногийн хугацаанд хөдөлгөөнт эргүүлийн нэг авто машин 15-30 дуудлага мэдээлэл хүлээн авч шийдвэрлэж байна.

Мөн алба хаагч нарт олгогдож байгаа өвлийн хувцсыг ялгавартайгаар олгогдож байгааг анхааралдаа авах цаг болсон байна.

Учир нь замын цагдаагийн зохицуулагч цагдаа нь өдрийн 6-8 цагийн үүрэг гүйцэтгэдэг бол машинт эргүүлийн алба хаагч нар 24 цагийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд замын цагдаагийн албанд ажиллаж байгаа алба хаагч нарт нохойн арьсан гутал, ноолууран цамц зэргийг нэмэгдэл байдлаар олгодог нь харьцангуй ялгаатай.

Тэгэхлээр энэ өвлийн хувцасны нэмэлт хангалтыг машинт эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт ижил тэгш олгож байх шаардлагатай юм.

Түүнээс гадна, машинт болон явган эргүүлийн алба хаагч нар дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн харьяанд шилжин очсон цагаас хойш алба хаагч нарын ажлын үзүүлэлтийг сайжруулах нэрийдлээр торгуулийн хуудасыг их хэмжээгээр шахаж байна.

Өдөрт нэг алба хаагч 10-20.000 төгрөг, машинт эргүүлийн алба хаагчдыг 24 цагийн хугацаанд 20-30000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч захиргааны зөрчил илрүүлж ажилла гэсэн үүрэг чиглэл өгөгдсөний улмаас, цагдаагийн алба хаагч нар иргэд, олон нийтийг ялимгүй шалтаг шалтгаанаар захиргааны арга хэмжээ авч иргэдийг хохироох, хууль зөрчих асуудал их гарах болсон.

Түүнээс гадна, автомашины эвдрэл гэмтлийг машинт эргүүлд ажиллаж байгаа офицер, жолооч-цагдаа нар тухайн эвдрэл гэмтлийг хамтарч, хариуцсан чиглэлд нь ойрхон байгаа засварын газраар өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан засуулдаг явдал байсаар байна.

Учир нь, Цагдаагийн Ерөнхий газрын автобазад засуулдаг хэдий боловч автобаазын засварчид чанарын шаардлага хангахгүй техник хэрэгслээр засварладаг учир тэр нь тогтоосон норм шаардлагыг хангахгүй, хугацаанаас өмнө дахин эвдэрч байдаг учир тэд хувийн засварын газраар янзлуулахад хүрдэг.

Автомашины дугуй ч мөн шаардлага хангадаггүй. Тавьж олгосон дугуй нь машинд олгогдсон өдрөөс хойш 30000 км явж дахин дугуй олгогдох ёстой байдаг боловч тогтоосон км болон хугацаанд замын саад бартаанаас болж норм хугацаанаасаа өмнө элэгдэж дуусдаг тул алба хаагчид нь, өөрсдийн дотоод нөөц бололцоогоороо дугуй худалдан авч тавихад ч хүрч байжээ.

Нөгөөтэйгүүр тогтоосон хугацаанд хүрээгүй техникийн эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд хариуцсан чиглэлд ажиллаж байгаа нийт офицер, жолооч-цагдаа нар нь хариуцах жишээтэй анхаарч, өөрчилмөөр, хоёр талтай авч үзэж болмоор асуудлууд гарсаар байдаг байна.

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Жагваралын Батмөнх

СХД-ын Цагдаагийн II-р хэлтсийн

хэв

журмын офицер, магистр, цагдаагийн ахмад

Цагдаагийн байгууллага 1990-ээд оны эхнээс “цагдаа-иргэний харилцаа цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа “ гэмт явдалтай тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд , олон нийтийн оролцооны эрх зүйн үндэслэлийг хуульчлан тогтоосон билээ.

МУ-н Үндсэн хуулийн оршил хэсэгт Эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго гэж тодорхойлсон. Энэ нь Монгол Улсын нийгмийн хөгжлийн ирээдүйн чиг баримжааг тодорхойлсон зорилгын туйл учраас бүх нийтийн идэвхи санаачлага бүтээлч ажиллагааны дүнд хэрэгжих учиртай.

Иймд иргэний ардчилсан нийгмийн үндсэн асуудлын нэг нь цагдаа–иргэний харилцааг боловсронгуй болгох, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах бодлого, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх явдал юм.

Өнөөдөр энэ хурлаар хэлэлцэж буй сэдэв нь өөрөө нилээд өргөн , хүрээтэй учир миний бие ЭБША ны тодорхой нэг үе шат болох, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад иргэдийг оролцуулах талаар хуулинд тусгагдсан зарим зүйл заалтууд одоогийн нөхцөлд хэрхэн хэрэгжиж буйд та бүгдийн анхаарлыг хандуулъя.

Цагдаа – олон нийтийн хамтын ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан :

- Байгууллага, иргэд, аж ахуй нэгж, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх

- Гэмт хэрэг, зөрчлийг үл тэвчих нийгмийн ухамсрыг бэхжүүлэх, соён гэгээрүүлэх

- Гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх нийгмийн хэв журмыг сахин хамгаалах үйл ажиллагаанд төрийн болон нутгийн захиргааны байгууллага нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг хариуцлагыг бэхжүүлэх нийгэмд түгээмэл гарч байгаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг иргэдэд сурталчлах нээлттэй мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх хэрэг зорилтыг хэрэгжүүлэхэд гэмт хэргийг шуурхай илрүүлэх , гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох , зорилгоор хэргийн нотлох баримтыг бүрдүүлэх , үндсэн чиг үүрэг бүхий хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага , албан тушаалтнууд тодорхой үүрэг гүйцэтгэдэг .

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн шийдвэрээр байцаан шийтгэх тодорхой ажиллагаанд хөндлөнгийн гэрч, батлан даагч, барьцаа өгөгч, мэргэжилтэн, гэрч, орчуулагч, хэлмэрч ¹²²нарыг ЭБШ хуулинд заасан үндэслэл журмын дагуу оролцуулдаг .

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 28-р зүйлийн 28.3т хэрэг бүртгэгч , мөрдөн байцаагчаас тодорхой хэргийг шалгах явцад энэ хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд гаргасан тогтоолыг аж ахуйн нэгж , байгууллага албан тушаалтан заавал биелүүлнэ гэсэн заалт нь дээрх оролцооны хууль зүйн үндэслэл болно .

Цагдаагийн байгууллага нь эрүүгийн хуулийн тусгай ангид заагдсан хэргийг бүртгэх , мөрдөх харьяаллын тухай хуулийн заалтаас харахад ЭБШ ажиллагааны энэ чиг үүргийг бараг дангаараа гүйцэтгэж байна гэж дүгнэж болно.

1. Гэрчийн оролцоо

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45дугаар зүйлд “ Хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа , тухайн хэрэгт холбогдолгүй хүнийг гэрч гэнэ хэмээн тодорхойлжээ. Энэ тодорхойлолтод зааснаас гэрчид байх ёстой үндсэн хоёр шинж байна.

Үүнд :

- Хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа
- Хэрэгт холбогдолгүй байх явдал хамаарна .

¹²² Я . Цэвэлийн зохиолын монгол хэлний товч толь бичиг т

“ орчуулагч – ямар нэгэн бичиг хэлийг өөр хэлэнд хөрвүүлдэг хүн

Хэлмэрч – аливаа хэлний үгийг өөр хэлэнд орчуулах хэлэх хүн хэмээн бичжээ. УБ 1966 он 426 “ 728 дахь тал

Хэрэгт холбогдолгүй байх нь гэрчийн бусад мэдүүлэг өгөгчдөөс ялгарах онцлог юм. Үүгээрээ сэжигтэн , яллагдагч, шүүгдэгч болон хохирогчоос ялгардаг . иймд уг ойлголтыг тухайн хэргийн сэжигтэн , яллагдагч, шүүгдэгч болон хохирогчийн аль аль нь биш байх гэсэн утгаар тайлбарлаж хэрэглэвэл илүү оновчтой юм . Чухам эндээс л гэрчийн мэдүүлгийн нотолгооны онцлог тал илэрдэг .

Гэрч тухайн хэрэгт яллах болон цагаатгах аль ч талын , алинд ч хувийн сонирхолгүй бөгөөд зөвхөн хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаагийнхаа хувиар сайн дураараа, эсхүл хуульд заасан журмаар дуудагдан мэдүүлэг өгч иргэнийхээ үүргийг биелүүлдэг юм.

Энэхүү хэрэгт шууд хувийн сонирхолгүй байдал нь гэрчийн мэдүүлгийг ерөнхийд нь бусад хувийн сонирхол бүхий этгээдийн мэдүүлгээс үнэний магадлалын хувьд илүүд үзэх шалтгаан болдог . Түүнээс гадна гэрчид худал гэрчилбэл эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай урьдчилан сануулдаг нь түүний мэдүүлгийн үнэн зөвд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг талтай .

Гэхдээ энэ бүгд нь гэрчийн мэдүүлгийг ямагт бусад мэдүүлгээс илүүд үзэх шалтгаан болж чадахгүй бөгөөд түүнийг шалгах, бусад нотлох баримттай харьцуулж судлах замаар л үнэн бодитой байх магадлалын зэргийг нь тогтооно.

Гэхдээ гэрч хэргийн явцад шууд ашиг сонирхол илэрхийлж оролцохгүй боловч аль нэг талд нь дам ашиг сонирхолтой этгээд байж болно. Жишээ нь , сэжигтний эсхүл хохирогчийн хамаатан , дотны найз нөхөд гэх мэт . Эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд гэрчийн мэдүүлэг хамгийн өргөн хэрэглэгддэг бөгөөд гэрчийн мэдүүлэг тус бүрийг үнэлж цэгнэх , нотлох баримтын системд цогц байдлаар авч үзэх зэргээр нягт нямбай хандахыг шаарддаг .

Практикаас ажиглахад хэрэг бүртгэлт , мөрдөн байцаалтын шатанд гэрчийг нэг асуудлаар олон удаа дуудан ирүүлэх , ажил амьдралд нь чирэгдэл учруулах , тэдэнтэй ёс зүйгүй харьцах , хуулиар далайлган сүрдүүлэх зэрэг зөрчил дутагдал оршсоор байна.

2. Орчуулагч , хэлмэрчийн оролцоо

Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч этгээд нь монгол хэл мэддэггүй , бол өөрийн хэл буюу мэддэг хэл , бичгээр, хараагүй , хэлгүй дүлий этгээд дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч , хэлмэрчийн тусламжтайгаар мэдүүлэг өгөх , гомдол гаргах , хэргийн холбогдох материалтай бүрэн танилцах эрхээр хангагдана “ гэсэн хуулийн заалтын дагуу хэрэг бүртгэгч , мөрдөн байцаагч , нь орчуулга хийх , хэлмэрчлэх мэдлэг чадвартай хүнийг орчуулагч , хэлмэрчээр томилно .

Орчуулагч хэлмэрч нь дуудсан цагт ирж орчуулах , хэлмэрчлүүлэхээр даалгасан үүргийг бүрэн , зөв биелүүлэх үүрэгтэйгээс гадна санаатайгаар худал орчуулсан , хэлмэрчилсэн бол түүнд Эрүүгийн хуулинд заасан хариуцлага хүлээлгэнэ.

3. Хөндлөнгийн гэрчийн оролцоо

Энэ нь “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн шийдвэрээр байцаан шийтгэх тодорхой ажиллагааны явц , үр дүнг баталгаажуулахаар тухайн ажиллагаанд оролцож буй иргэн “ юм .

ЭБШ хуулийн 192 дугаар зүйлд заасны дагуу үзлэг , нэгжлэг , хураан авах , түүнчлэн ЭБШ хуульд хөндлөнгийн гэрч оролцуулахаар заасан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад хоёроос доошгүй гэрчийг заавал оролцуулна¹²³ .

Хөндлөнгийн гэрч нь хэргийн байдлыг тодруулах , шалгах ажиллагаанд оролцсонтой холбогдох , гарсан зардал хөлсөө гаргуулж авах эрхтэйн дээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн дуудсанаар ирэх, байцаан шийтгэх ажиллагааны журмыг сахих , нууц задруулахгүй байх үүрэгтэй. Энэхүү хуулийн шаардлагыг практикт хангах явцад процессын шинжтэй зөрчил , дутагдал гарч байгаа нь прокурорын хяналтаар илэрсэн байдал ажиглагдаж байна.

4. Мэргэжилтний оролцоо

ЭБШ хуульд мэргэжилтэн гэж хэн болох түүнийг эрх зүйн байдлыг тусгайлан заагаагүй гэхдээ мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаанд мэргэжилтэн оруулахыг үгүйсгээгүй.

Тухайлбал ЭБШ хуулийн 131 дүгээр зүйлд зааснаар хэрэг бүртгэгч буюу мөрдөн байцаагч мөрдөн байцаалтын туршилт хийхэд уг хэрэгт хувийн сонирхолгүй мэргэжилтэн урьж оролцуулна .

Тэрчлэн 16 нас хүрээгүй яллагдагчийг мөн 18 нас хүртэлх этгээдийг оюун ухаан нь гүйцэд хөгжөөгүй гэж үзвэл түүнийг байцаахад сурган хүмүүжүүлэгчийг оролцуулж байгаа нь мэргэжилтэн оролцуулж байгаагийн нэг хэлбэр мөн.

Сурган хүмүүжүүлэгч байцаалтын явцад насанд хүрээгүй байцаагдагч санаагаа хэрхэн илэрхийлж байгаа түүний хэлсэн үг, өгүүлбэрийг яаж ойлгож болох зэргийг сурган хүмүүжүүлэх

¹²³ Б. Бат-эрдэнэ Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй УБ 2004 оны 98 дах тал

зүй хийгээд сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс тайлбарлах буюу өөрөөр хэлбэл мэргэжилтний байр сууринаас байцаалтанд оролцуулна. Эрүүгийн тодорхой хэрэгт шинжлэх ухааны үүднээс тайлбарлах өвөрмөц тодорхой нэр томъёог тодруулах зэрэг шаардлага улам бүр нэмэгдэж байгаа нь мэргэжилтний оролцоог өргөжүүлэх хандлага бий болж байна.

5. Батлан даагч барьцаа өгөгчийн оролцоо

Хэрэг бүртгэлт , мөрдөн байцаалтын үед гэмт хэргийн сэжигтэн яллагдагч нарт ЭБШ хуульд заасан үндэслэл журмын дагуу таслан сэргийлэх арга хэмжээ авахад батлан даагч , барьцаа өгөгч гэсэн оролцогч бий болдог .

Батлан даагчид тавигдах үндсэн шалгуурыг шинээр хуульчилж өгсөн нь энэ оролцогчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэрэгсэл болсон . Өөрөөр хэлбэл оршин суух хаягтай , тодорхой ажил хөдөлмөр эрхэлдэг , хөрөнгийн эх үүсвэртэй , насанд хүрсэн хүн батлан даагчаар оролцож хэрэв дааж авсан хүн нь оргон зайлвал торгууль хүлээж , оргосон этгээдийг эрэн сурвалжлахад гарсан бүх зардлыг нөхөн төлөхөөр хуульчилсан нь батлан даагчаар хэнийг оролцуулахад онцгой анхаарч сөрөг үр дагавар гарсан тохиолдолд хариуцах эзэнтэй болгосон нь чухал заалт болсон гэж үздэг .

Үүнээс арай өөр хэлбэрээр барьцаа өгөгч мөн оролцоно . Барьцаа өгөгч нь таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа байгууллагын дансанд бэлэн мөнгө , бусад үнэ бүхий зүйлийг шилжүүлж байгаа байгууллага хүн байна.

Хэрэв үүргээ биелүүлээгүй бол барьцаанд өгсөн зүйлийг улсын орлого болгоно

Дээрх байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрх зүйн байдлыг ЭБШ хуульд тодорхойлж тусгасан боловч энэ оролцоо нь хэрэг бүртгэх , мөрдөн байцаах ажиллагаанд хэр зэрэг ач холбогдолтой , тустай , зайлшгүй шаардлагатай болохыг тэр бүр олон нийт мэдэж , учир холбогдлыг нь бүрэн ойлгохгүй байгаа нь энэ талаарх хуулийн заалтыг сурталчлан таниулах ажил хангалтгүй байгаатай холбоотой юм.

Дүгнэлт:

ЭБШ хуулийн холбогдох зүйл заалтад хийсэн судалгаанаас байцаан шийтгэх ажиллагааны үндсэн үе шат болох хэрэг бүртгэлт , мөрдөн байцаалтын ажиллагаанд иргэдийг татан оролцуулах боломж нөхцөл эрх зүйн орчин бүрдсэн байна. Харин хэрэг бүртгэгч , мөрдөн байцаагч нар ЭБШ ажиллагаанд оролцож байгаа иргэд байгууллагад хүндэтгэлтэй хандаж хуульд заасан эрх үүргийг нь хэрэгжүүлэх бололцоогоор хангахад онцгой анхаарч ажиллах учиртай.

Ингээд хэлэлцэж буй асуудалтай холбогдуулж дараах саналыг дэвшүүлж байна.

1. Хэрэг бүртгэх , мөрдөн байцаах байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний үр дүнд иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг судлах

2. Цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг эрчимжүүлж гэмт хэргийн тухай мэдээллийг цуглуулах боломжтой шинэлэг арга хэлбэрүүдийг нэвтрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх иргэдийн сэтгэлгээг өөрчлөх тэдний эрх зүйн ухамсрын төлөвшлийг нэмэгдүүлэх

3. Байцаан шийтгэх ажиллагаанд оролцсоны улмаас тэдний амь нас , эрүүл мэнд , гэр бүлийнхэнд нь аюул учруулахгүй байх баталгааг бүрдүүлэх ба бусад байдлаар эрх ашиг нь зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээ авах

4. Өнөөгийн нөхцөлд хэрэг бүртгэгч , мөрдөн байцаагч нарт зөвхөн хууль зүйн мэдлэг төдийгүй социологи, статистик , улс төр , эдийн засаг , сэтгэл зүй , техник технологи зэрэг шинжлэх ухааны мэдлэгийг тодорхой хэмжээнд эзэмшсэн байх шаардлага тулгарч байна. Энэхүү шаардлагыг хангасан тохиолдолд байцаан шийтгэх ажиллагаанд иргэд байгууллагыг татан оролцуулах боломж нөхцөл бүрдэж болох юм.

ХУУЛЬ БУСААР МОНГОЛ УЛСЫН ХИЛ НЭВТРЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Төмөртөгтохын Болор-Эрдэнэ

Батлан хамгаалахын их сургуулийн магистрант

Аливаа улсын оршин тогтнохын үндэс нь хил хязгаарын халдашгүй дархан байдал билээ. Монгол Улсын үндсэн хуулийн дөрөв дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал улсын хил халдашгүй дархан байна гэж зааж өгсөн нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг бататган бэхжүүлж, хил хамгаалалтын эрх зүйн үндсийг тогтоож өгсөн хэм хэмжээ болжээ.

Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх үзэгдэл 1967-1990 оны хооронд хамгийн их буюу өмнөд хил дээр 3738 удаагийн зөрчил гарсны 51,5 хувь нь тагнан турших, өдөөн хатгах, улс төрийн шинжтэй, 48,5 хувь нь төөрөх, ан хийх, хил давсан малаа хайх, ховор өвс ургамал түүх зэрэг ахуйн шинжтэй байсан бол 1990 оноос Монгол орон ардчилан зах зээлийн харилцаанд шилжиж хууль бусаар хил нэвтрэх гэмт хэргийн үйлдлийн арга, сэдэлт зорилт нь бүхэлдээ өөрчлөгдсөн юм.

2002 оны Эрүүгийн хуульд хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйлд заасан ба улсын дээд шүүхийн тайлбарт уг гэмт хэргийг дараах байдлаар тайлбарласан байна.

Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын хилийг нэвтрэх эрхийн хүчин төгөлдөр паспорт, баримт бичиггүй буюу эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, эсхүл залилан мэхлэх арга хэрэглэн хуурай газар, ус, агаарын орон зай, газрын хэвлийгээр / орсон, гарсан, дамжин өнгөрсөн /, нийгэмд аюултай, эрүүгийн хуульд заасан, гэм буруутай үйлдлийг / үйлдэхүйг / хэлнэ. Уг гэмт хэрэг сүүлийн жилүүдэд эрүүгийн хуулийн бусад зүйлд заасан гэмт хэргүүдтэй нийлмэл байдлаар үйлдэгдэж байгаа нь нийгмийн хор аюулыг ихэсгэж байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар анхан шатны шүүхээр 124 хэрэг шийдвэрлэгдсэнээс 79 хэрэг нь эрүүгийн хуулийн 233 дугаар зүйлтэй давхар зүйлчлэгдсэн ба эрүүгийн хуулийн 145,147,175,140,261,268,269,270 зүйлд заасан гэмт хэргүүдтэй давхар зүйлчлэгдсэн байна.

Хууль бусаар хил нэвтрэх гэмт хэргийн гаралт хамгийн их өсөж байсан үе буюу 1998-2005 онуудад амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны үр дүнд ажилгүйдэл газар авсан, хөдөлмөрийн хөлс бага байгаа нь Монгол оронд тархсан ядуурлын гол шалтгаан гэсэн дүгнэлт гарч байсан ба 2005 онд Монгол Улсад ажилгүйдлийн тоо 217,700-д хүрч нийт ажилгүйдлийн 60-70 хувь нь 16-35 насны залуучууд байсан гэсэн судалгаа гарч байжээ.

Үүнээс үүдэн гадаадад гарч ажиллаж амьдрах сонирхолтой залуучуудын тоо нэмэгдэж хууль бусаар хил нэвтрэх гэмт хэргийн гаралт улам өссөн байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар хууль бусаар хил нэвтэрсэн гэмт хэрэгт нийт 161 хүн холбогдсон ба тэдгээрийг насны хувьд авч үзвэл 78 хувь нь 18-36 насны хүмүүс байгаа нь ид хөдөлмөрийн насны залуучууд уг гэмт хэргийг үйлддэг болох нь харагдаж байна.

Мөн уг гэмт хэргийг үйлдэж буй этгээдүүдийн 69 хувь нь эрэгтэйчүүд эзлэж байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин мөн өссөн байна. Боловсролын хувьд бүрэн дунд боловсролтой, эрхэлсэн тодорхой ажилгүй, эзэмшсэн мэргэжилгүй, гэр бүлийн байдал харьцангуй тогтвортой хүмүүс энэ гэмт хэрэгт холбогдож байгаа нь судалгаанаас харагдаж байна. Уг гэмт хэргийн гаралт Буянт-Ухаа боомт дээр нийт зөрчлийн 84,4 хувь, Замын-Үүд боомт дээр 0,6 хувь, бусад боомт газруудаар 15 хувь нь үйлдэгдсэн байна.

Буянт-Ухаа боомт дээр гарсан хилийн зөрчлийг гадаадаас дотоод руу чиглэлтэй зөрчил дийлэнх хувийг эзлэж байгаа нь уг гэмт хэргийг үйлдсэн этгээдүүдийн 27 хувь нь өмнө нь гадаадын аль нэг улс оронд ажиллаж амьдарч байсантай холбоотой байгаа юм.

Тэр дундаа Солонгос улсад ажиллаж, амьдарч байгаад визны хугацаагаа хэтрүүлж хар тамга даруулсан этгээдүүдэд эх орондоо ирсэн ч дахин Солонгос гарч ажиллаж мөнгө олох зорилгодоо хөтлөгдөн хуурамч бичиг баримт ашиглан хилээр орсон, гарсан олон удаагийн давтан үйлдлээр хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн үйлдлийг хийсэн байна.

Хууль бусаар хил нэвтэрсэн гэмт хэрэг үйлдэгч этгээдүүд амар хялбар аргаар ашиг хонжоо олох, ахуй амьдарлаа дээшлүүлэх ахуйн шинжтэй зорилгоор уг гэмт хэргийг үйлддэг байна. Шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэгтээ ажил олдохгүй, олдсон ажил нь цалин бага учир ахуй амьдарлаа дээшлүүлэх зорилгоор уг гэмт хэргийг үйлдсэн гэж ихэнх сэжигтэн мэдүүлсэн байна.

Дээрх бүгдээс дүгнэн үзэхэд уг гэмт хэргийн гаралтад нийгэм эдийн засгийн байдал, хувь хүний ухамсар зэрэг нь нөлөөлж байна.

Мөн гадаадад өндөр цалинтай ажилд зуучлана, их, дээд сургуульд оруулж өгнө, гадаад хүнтэй гэр бүл болоход зуучлана гэсэн зар сурталчилгаа нь хувь хүний сэтгэл зүйд нөлөөлж уг гэмт хэргийг үйлдэхэд өдөөн хатгалга болдог байна.

Тиймээс уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд төрийн зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Үүнд:

Нэг. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, иргэдийн эх орондоо ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх.

Хоёр. Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалт, сурталчилгаа зохион байгуулах

Гурав. Гадаадад ажиллаж, амьдрах, сурахад зуучлана гэсэн зарыг хэвлэл мэдээллийн хэрэгслэлд байршуулахад хяналт тавих, тусгай зөвшөөрлийг үндэслэж дээрх зарыг нийтлэдэг болгох.

Дөрөв. Хил хамгаалах, цагдаа, тагнуулын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах,

Тав. Эрүүгийн хуулийн болон Хилийн тухай хууль холбогдох эрх зүйн актуудыг боловсронгуй болгох зэрэг болно.